

Д.Эрдэнэсан, А.Цог-Очир,
Б.Цасанчимэг, Д.Наранцэцэг

МОНГОЛ ХЭЛ IX

Ерөнхий боловсролын 12 жилийн сургуулийн
9 дүгээр ангийн сурах бичиг

Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын Яамны
зөвшөөрлөөр хэвлэв.

Хоёр дахь хэвлэл

СУРГУУЛИЙН НОМЫН САНД ОЛГОВ.
БОРЛУУЛАХЫГ ХОРИГЛОНО.

Улаанбаатар хот
2019 он

DDC 74.2
HAA 373
M-692

Монгол хэл IX: Ерөнхий боловсролын 12 жилийн сургуулийн 9 дүгээр ангийн сурах бичиг. /Эрдэнэсан Д., ба бус; Ред. Мөнхтуяа Б. - УБ. 2017. - 148х



Дасгал



Бүтээлч даалгавар



Анхаарах дүрэм, санамж



Хэлэлцүүлэг хийх, ярилцах,
мэтгэлцэх



Өөрийгөө сорих



Тайлбар, тодорхойлолт

Азийн Хөгжлийн Банкны “Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах төсөл”-ийн хүрээнд хэвлүүлэв.

Энэхүү сурах бичиг нь "Монгол Улсын Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай" хуулиар хамгаалагдсан бөгөөд Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яамнаас бичгээр авсан зөвшөөрлөөс бусад тохиолдолд цахим болон хэвлэмэл хэлбэрээр бүтнээр эсхүл хэсэгчлэн хувилах, хэвлэх, аливаа хэлбэрээр мэдээллийн санд оруулахыг хориглоно.

Сурах бичгийн талаарх санал, хүсэлтээ textbook@mecs.gov.mn хаягаар ирүүлнэ үү.

© Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын яам

ISBN 978-99978-61-12-2



ГАРЧИГ

ӨМНӨХ АНГИД ҮЗСЭНЭЭ СЭРГЭЭН ДАВТЪЯ.	5
МЭДРЭМЖ, СЭТГЭГДЭЛ, ҮЗЭЛ БОДЛОО ИЛЭРХИЙЛЬЕ.	
◆ Эхэд мэдрэмж, сэтгэгдлээ хэрхэн илэрхийлснийг уншиж, тэдгээрийн ялгааг тодорхойлъё.	10
◆ Эхийн бичлэгийн төрлийн онцлогийг мэдэж, үзэл бодлоо илэрхийлье.	14
◆ Мэдрэмж, сэтгэгдэл, үзэл бодлоо илэрхийлье.	20
ТААМАГЛАЛ ДЭВШҮҮЛЭН ТАЙЛБАРЛАЯ.	
◆ Таамаглал дэвшүүлэн, баталж нотолсон эхийг уншиж ойлгоё.	24
◆ Таамаглал дэвшүүлэн, баталж нотолж, үгүйсгэж бичих аргад суралцъя.	39
◆ Асуудал дэвшүүлэн, баримт үзэл бодлыг хослуулан, санаагаа илэрхийлье.	48
УЧИР ШАЛТГААНЫГ ТАЙЛБАРЛАЯ.	
◆ Шалтгаан, үр дагаврын холбоо хамаарал, баримт, үзэл бодлыг задлан шинжилье.	66
◆ Нийлмэл өгүүлбэрийг холбон найруулах аргад суралцъя.	82
◆ Асуудал дэвшүүлэн, үзэл бодлоо илэрхийлэхдээ шалтгаан, үр дагаврын холбоог үндэслэл нотолгоотой гаргая.	91
ДЭВШҮҮЛСЭН АСУУДАЛ, ҮЗЭЛ БОДОЛ, ДҮГНЭЛТИЙН ХОЛБОО ХАМААРЛЫГ ТАЙЛБАРЛАЯ.	
◆ Эхийг уншиж, ойлгон, сэдэв, гол санааг тайлбарлая.	110
◆ Дэвшүүлсэн асуудал, үзэл бодол, дүгнэлтийн холбоо хамаарлыг задлан шинжилж тайлбарлая.	112
БАРИМТАД ҮНДЭСЛЭН САНААГАА ИЛЭРХИЙЛЬЕ.	
◆ Сэдвийн хүрээнд баримт мэдээлэл цуглуулж, эмхлэн цэгцэлье.	122
◆ Баримтад үндэслэн, тайлбарлан бичье.	126
МЭТГЭЛЦЭЭН ЗОХИОН БАЙГУУЛЪЯ.	
◆ Мэтгэлцээн зохион байгуулъя.	132
МЭДЛЭГ, ЧАДВАРАА ДҮГНЭЕ.	143


БИД ЕСДҮГЭЭР АНГИДАА ЮУ СУДЛАХ ВЭ?

№	Тулгуур ойлголт	Эзэмших чадвар	Суурилах эх, хэрэглэгдэхүүн
1	Баримт	Мэдрэмж, сэтгэгдэл, үзэл бодлоо илэрхийлэх	Уншигчийн захидал
2	Мэдрэмж		
3	Сэтгэгдэл		
4	Үзэл бодол		
5	Ажиглалт	Таамаглал дэвшүүлэн тайлбарлах	“Эх хэл, түүх, соёл, уламжлал” сэдвийн хүрээнд таамаглал дэвшүүлэн, тайлбарласан эх
6	Асуулт, таамаглал		
7	Дэвшүүлсэн асуудал		
8	Үндэслэл, нотолгоо		
9	Дүгнэлт, үр дүн		
10	Таамаглах, батлах, үгүйсгэх өгүүлбэр	Учир шалтгааныг тайлбарлах	“Эх орон, байгаль орчин, эрүүл аж төрөхүй” сэдвийн хүрээнд асуудал дэвшүүлэн, учир шалтгааныг тайлбарласан эх, өгүүлбэр
12	Шалтгаан ба үр дагавар		
13	Дэвшүүлсэн асуудал		
14	Үндэслэл нотолгоо		
15	Үзэл бодол	Дэвшүүлсэн асуудал, үзэл бодол, дүгнэлтийн холбоо хамаарлыг тайлбарлах	Утга зохиолын шүүмж
16	Эхийн сэдэв, гол санаа		
17	Дэвшүүлсэн асуудал		
18	Тайлбар		
19	Үзэл бодол, дүгнэлт	Баримтад үндэслэн санаагаа илэрхийлэх	“Ном уншихын ач тус” сэдэвт баримт, мэдээлэл
20	Баримт		
21	Бичих төлөвлөгөө		
22	Ноорог, найруулгын алдаа		
23	Цогцолбор (Эх) бичих	Мэтгэлцэх	“Цахим хэрэглээ” сэдвийн хүрээнд асуудал дэвшүүлсэн эх, мэдээлэл
24	Мэтгэлцээн		
25	Дэвшүүлсэн асуудал		
26	Баримт		
27	Нотлох		
28	Няцаах	Хэл зүй, үгийн санг хэрэглэх	Төрөл бүрийн эх, өгүүлбэрийн жишээн дээр
29	Цэг цэглэлийн дүрэм		
30	Нийлмэл өгүүлбэр (Өгүүлбэрийг орон, цаг, зорилго, шалтгааны утгаар холбон найруулах, хувиргах)		
31	Угсруулан, зэрэгцүүлэн холбох үгийн хэрэглээ		
32	Эх, өгүүлбэрийн найруулгын алдаа		
33	Мэргэжлийн үг, нэр томъёоны үгийг хэрэглэх		
34	Өөр өөр цаг үе дэх үг хэллэг		
35	Ойролцоо ба эсрэг утга		



ӨМНӨХ АНГИД ҮЗСЭНЭЭ СЭРГЭЭН ДАВТЪЯ

Тоочин тайлбарласан, дүрслэн тайлбарласан эхийг уншихдаа баримт, дүрслэл, тайлбарыг ялгаж, мэдлэгээ бататгая.



Миний тухай та нар юу мэдэх вэ?

Шинэ мэдээлэл олохыг хүсэж байна уу?

Миний нэрийг үндэсний бичгээр бичээд, үгийн бүтцээр задлаарай.

Миний тухай бичил эхийг уншаад, мэдээлэл олж аваарай.

Миний тухай ямар сэтгэгдэлтэй байна вэ?



Тоочин тайлбарласан эхийг уншъя.

Шоргоолжтой газрын ой эрвээхэйнээс айдаггүй

Их нийгэмч амьтан шүү дээ, шоргоолж чинь. Тэд зохион байгуулалт, хатуу дүрэм журамтай амьдардгаараа хүнтэй төстэй. Хүн, нийгмийн бүтээгдэхүүн бол шоргоолж өөрийн хатан хаант улсын цэрэг нь юм. Мөнхийн хөдөлгөөн дунд амьдрал нь буцалж байдаг энэ амьтан харахад жижигхэн ч санаанд багтамгүй хүч чадалтай, тоо толгой нь асар олон. Одоогоор 9500 зүйлийн шоргоолж байгаагаас Монголд 43 зүйл байдаг. Шоргоолж их хэмжээгээр байдаг, дэлхийн нийт ой модны 12 хувийг бүрдүүлдэг Бразилийн ой ямар сайхнаараа байгааг хүмүүс анзаардаггүй. Шоргоолж ихтэй ой хортон шавжны нөлөөнд хэзээ ч автдаггүй. Сөрөг гэхээсээ ашигтай тал нь давуу.

а. Шоргоолжны шинжүүдийг дараах хоёр баганад ялгаж бичсэний учрыг тайлбарлаарай. Хоёр баганад байгаа үгсийн гол ялгаа юу вэ?

Нийгэмч амьтан гэнэ шүү, энэ шоргоолж.	Шоргоолжны онцлог
<ul style="list-style-type: none"> ◆ Ажилсаг ◆ Хамтач ◆ Өрөвдмөөр ◆ Нөхөрсөг ◆ Хүчтэй ◆ Тустай ◆ Гэрсэг 	<ul style="list-style-type: none"> ◆ Мөнхийн хөдөлгөөн дунд байдаг. ◆ Маш олон зүйл байдаг. ◆ Ой модонд тустай. ◆ Хортон шавжнаас хамгаалагч. ◆ Бразилийн ой сайхнаараа байдаг нь шоргоолжны ач тус.

- “Шоргоолж” сэдвээр дөрвөн мөрт шүлэг зохиож бичихийн тулд аль эгнээний үгийг сонгох вэ? Яагаад?
- Тайлбар бичихийн тулд аль эгнээний үгийг сонгох вэ? Яагаад?

б. “Шоргоолж ашигтай амьтан” гэсэн санааг баталсан өгүүлбэрийн аль нь зөв бэ?

Дэлхий дээр 9500 зүйлийн шоргоолж байдаг учраас шоргоолж ашигтай амьтан.

Бразилийн ой сайхнаараа байдаг нь шоргоолж ашигтай амьтан гэдгийг илэрхийлнэ.

Онъсогод шоргоолжны ямар шинжийг онцлон дүрсэлсэн байна вэ?
“Баатар” хэмээсний учир юу вэ?



1. Газар доор хар цай буцална.
2. Хүнээс жаахан байж
Хүч ихтэй нь аймшигтай.
3. Шил нь сэтэрхий баатар
Сээр хүзүү тасархай баатар



2

Мэдээллийг дэлгэрүүлье.

... Одоогоос 225 жилийн өмнө Австрали тивд очсон нэгэн англи хүн, хэвлий дэх уутандаа зулзагаа хийчхээд хойд хоёр хөл дээрээ үсэрч яваа амьтныг хараад, “Энэ ямар амьтан болохыг хэлж өгнө үү” хэмээн нутгийн анчдаас асуухад цаадуул нь өөрсдийнхөө хэлээр “Кенгуру” буюу “би мэдэхгүй” гэж хэлсэнд өнөөх соёлт хүн тэр амьтныг хэлж байна хэмээн ойлгосноос уутат тэр амьтныг дэлхий дахинаа “кенгуру” хэмээн нэрлэх болжээ. Харин монголчууд имж гэдэг.

Тэгвэл намайг яагаад шоргоолж гэж нэрлэсэн юм бол? Дараах эхийг уншаад, ийнхүү нэрлэх болсон баримт ба шалтгааныг тайлбарлахдаа хүснэгтийг ашиглаарай.

Шоргоолж

Шоргоолж нь биеийн дунд хэсгээр нарийн, газарт нүх хийж оршдог шавж гэж тольд өгүүлжээ. Шоргоолж гэдэг үгийг үндэсний бичгээр “ширгулжи” гэж бичдэг. Үүнийг ширгу-лжи гэж задалж болно. Иймэрхүү бүтэцтэй амьтан ургамлын нэр монгол хэлэнд нэлээд буй. Жишээ нь, усанд оршдог найман хөлтэй нэг зүйл хорхойг наймалж гэж нэрлэдэг. Энэ нь найм гэсэн тооны нэрээс үүссэн байна. Шоргоолж гэсэн үгийн үндэс нь “шурга, шургах” юм. Шоргоолж гэдэг үгийн ширгу+(лжи), шургах гэдгийн ширгу+(ху) хоёр нэг үндэстэй болох нь тодорхой байна.

(Х.Лувсанбалдан)

Юуг тайлбарласан	Хэрхэн тайлбарласан	Тайлбарлахдаа юуг ашигласан	Шаардлагатай мэдээлэл нь



Тоочин тайлбарласан эх нь аливаа зүйлийн тухай уншигчдад тодорхой мэдээлэл өгөх зорилготой байна. Өөрөөр хэлбэл, элдэв баримтыг зохиогчийн хувийн дүгнэлтгүй, үйл явдлын болсон дэс дараа, бодит байдал, тоо баримтыг тэр хэвээр нь бичихийг хэлнэ.

Аливаа зүйлийг уран сайхны аргаар дүрслэн тайлбарлаж болно.



Тайлбарлан бичих арга

Тоочин тайлбарлах

Дүрслэн тайлбарлах

Учир шалтгааныг тайлбарлах

Таамаглал дэвшүүлэн тайлбарлах

3

Тоочин тайлбарласан, дүрслэн тайлбарласан эхийг уншиж, харьцуулъя.

- Хоёр эхийг бичсэн зохиогчийн зорилго адил уу? өөр үү?
- А эхийг уншигч нь хэн байж болох вэ? Яагаад? Б эхийг уншигч нь хэн байж болох вэ? Яагаад?
- Эхийг бичихдээ ашигласан зохиогчийн аргыг тодорхойлно уу?
- “Дэлхийн цөм нь нарны гадарга шиг 5000°C орчим халуун. Газрын давхаргын зузаан 35 км. Галт уул бол цөмөөс бялхан гарч буй магма болох лав юм. Лав хөрвөл уул үүснэ” гэсэн хэсгийг дүрсэлсэн тайлбар болгож хувиргана уу?


А. Дэлхий

Манай дэлхий ойролцоогоор 4.5 тэрбум жилийн тэртээ үүсжээ. Эхлээд хий ба тоосноос бүрэлдсэн хуйларсан бөөн үүл байв. Энэ үүл хуйларсаар, хайлмал бодисоос бүтсэн бөмбөлөг болжээ. Үүний гадаргуу нь хөрч, хажуу газрын давхарга бий болон, уур хий нь үүл болон хувирчээ. Үүлнээс хүчтэй аадар бууж, түүнээс тэнгис үүсжээ.

Тохиромжтой дулаан, агаарын хийн хольц нарны гэрлээс амьтан үүсэх нөхцөл бүрэлджээ. Эртний чулуулгийн доторх амьтан ургамлыг судалснаар олон сая жилийн тэртээх амьдралын дүр зургийг сэргээж чаджээ.

Дэлхий бол аварга том хатуу бөмбөрцөг юм. Дэлхий нь газрын давхарга, цаваг мандал, цөм гэсэн гурван хэсгээс бүтнэ. Цаваг мандлын дээд хэсэг дэх халуун хайлмал чулуулгийг магма гэнэ. Түүний дээр газрын давхарга шилжин нүүж байдаг.

Дэлхийн цөм нь нарны гадарга шиг 5000°C орчим халуун. Газрын давхаргын зузаан 35 км. Галт уул бол цөмөөс бялхан гарч буй магма болох лав юм. Лав хөрвөл уул үүснэ.



Б. Чулуун хуудастай ном

Бидний хөлийг түшин өргөсөн газар дэлхий асар том ном мэт. Газрын царцдасын давхарга бүр, хөрсний үе бүр энэ номын хуудас юм. Бид хамгийн өнгөн талын сүүлчийн хуудас дээр амьдарч байна. Номын хамгийн эхний хуудсууд тэнгис далайн ёроол, эх газрын суурийн их гүнд дэвсээтэй байгаа. Тэр анхны хуудсууд, номын эхний бүлэгт хүн хүрч уншиж чадаагүй байна. Тэнд юу гэж бичигдсэнийг бид зөвхөн таамаглаж чадна. Номын хуудсууд бидэнд ойрхон, гар хүрч болмоор байх тусам уншихад арай амар байгаа юм. Халуун хайлмагийн урсгалд түлэгдэж хорчийсон хуудсууд, уул нурууд газар дээгүүр яаж товойсныг хэлж өгч байна. Газрын царцдас дээшлэх, доошлох бүрд тэнгис далайн ус нэг хальж, нэг ширгэж байсныг өөр хуудсууд өгүүлнэ. Тэнгисийн дунгаас бүрдсэн цагаан давхаргат хуудсуудын дараа нүүрс мэт хар хуудсууд үргэлжилнэ. Энэ бол үнэхээр нүүрс юм. Түүний зузаан хар хуудаснаас газар дэлхий дээр тэр нэгэн цагт ургаж байсан гүн шигүү ойн түүхийг уншиж болно.

Номын зураг мэт хэсэг газраас хожим нь нүүрс болсон шигүү ойд амьдарч байсан зэрлэг амьтны яс, навч, мөчрийн ором олдсоор байна. Ингэж хуудас хуудсыг сөхөн эргүүлсээр бид газар дэлхийн бүх түүхийг уншиж чадна. Хамгийн сүүлийн, хамгийн дээр орших хуудаснаас манай зохиолын шинэ баатар - хүн гарч ирдэг.. (М.Ильин, Е.Сегал “Хүн яаж хүн болсон бэ?”)

д. Дараах хүснэгтэд Б эхээс ялгаж бичсэн үгтэй утгаараа харгалзах үгийг А эхээс олж, дэвтэртээ бичээрэй.

А. Дэлхий	Б. Чулуун хуудастай ном
.....	◆ Номын хуудас
.....	◆ Өнгөн талын сүүлчийн хуудас
.....	◆ Анхны хуудсууд, номын эхний бүлэг



Уран зохиолын бус эхэд өгүүлэгч мэдрэмж, сэтгэл хөдлөлөө илэрхийлэх нь чухал бус, харин өгүүлж буй зүйлийн тухай мэдээлэл дамжуулахыг чухалчилсан байдаг.



Тайлбарлан бичсэн эхийн аль нэг хэсэгт уран дүрслэл орж болох ч ийм эх бүхэлдээ дүрслэн тайлбарласан эх болохгүйг санаарай.



Нэг сэдэвт уран зохиолын ба уран зохиолын бус эхээс гол санааг олъё.

Хойлог

Тахианаас томгүй 30-40 см өндөр, 2,5-3 кг орчим жинтэй, хөх бордуу зүстэй, зоо нуруу хар судалтай, элгэн биеэрээ цагаан толботой энэ шувуу Монгол Алтай, Говь-Алтайн нуруу, Алтайн цаадах говийн уулс, Хангайн нуруу, Хөвсгөл, Тагнын салбар уулсын эгц өндөр хадан хясаа, тагийн бүс, царамд амьдардаг. **Цавчим өндөр уул хадан дунд ургадаг ховор өвс ургамлыг хойлог л олж иднэ.**



Түүний махыг идэж, ясыг нь буцалгаж уусан хүн үхдэггүй гэх яриа бий. **Хүний биеийн дархлааг сайжруулж, орлуулж баршгүй олон амин дэм өгдөг.** Бага насны охид, нас биед хүрсэн бүсгүйчүүдэд амсуулдаггүй байж.

- ◆ Дээрх 3 эхийг анхааралтай уншина.
- ◆ Гол санааг нэг өгүүлбэрт багтаан бичнэ үү.
- ◆ Эхийн тодруулсан хэсгээс энэ шувуу яагаад ховордсон, яагаад дархалсан шалтгааныг хэлнэ үү.
- ◆ "...охид, ...бүсгүйчүүдэд амсуулдаггүй байж" гэсний учрыг сурвалжлаарай.
- ◆ Аль нь уран зохиолын бус эх вэ? Яагаад?


Хойлог

- ... Хоног хүрэхгүй шарх эдгээдэг **Хонин тогоон эм** гэж ярьдаг. Үд хүрэхгүй өвчин анагаадаг **Үнэгэн цагаан эм** гэж хэлцдэг.
- ... Ардын домогт өгүүлдэг эм бол Асгат уулын хойлгийн мах шүү... (Б.Я)

2

МЭДРЭМЖ,
СЭТГЭГДЭЛ,
ҮЗЭЛ БОДЛОО
ИЛЭРХИЙЛЬЕ

Мэдрэмж, сэтгэгдэл



Үзэл бодол


Эзэмших мэдлэг, чадвар

- ◆ Эхэд мэдрэмж, сэтгэгдлээ хэрхэн илэрхийлснийг уншиж, тэдгээрийн ялгааг тодорхойлъя.
- ◆ Эхийн бичлэгийн төрлийн онцлогийг мэдэж, үзэл бодлоо илэрхийлье.
- ◆ Мэдрэмж, сэтгэгдэл, үзэл бодлоо илэрхийлье.




Эхэд мэдрэмж, сэтгэгдлээ хэрхэн илэрхийлснийг уншиж, тэдгээрийн ялгааг тодорхойлъё.

- ◆ Мэдрэмж, сэтгэгдлээ хэрхэн илэрхийлснийг ялган унших
- ◆ Мэдрэмж, сэтгэгдлийн ялгааг тодорхойлох
- ◆ Сэтгэгдлээ илэрхийлэх



Бодит юм үзэгдэл, мэдрэмж, сэтгэгдэл гэж юу болох, түүний ялгааг ярилцъя.

- а. “Бодит юм үзэгдэл, мэдрэмж, сэтгэгдэл, бодол ухаарал” гэсэн үгийн утгыг толь бичгээс лавлаарай. Эдгээр үгийг холбосон сум ямар утга илэрхийлж байгааг тайлбарлаарай.




- б. Хүүхдүүд ээ! “Хэрвээ..... болбол” аргаар төсөөлөн бодъё.

- ◆ Дараах өгөгдлөөс сонгоно.
- ◆ Чимээгүй орчинд төсөөлөн бодно.

Хэрвээ, ус үгүй болбол

Хэрвээ, агаар үгүй бол

Хэрвээ, дөрвөн улирал биш, ганц улиралтай болбол.....



- в. “Байгаль дэлхийн юм үзэгдэл хоорондоо салшгүй холбоотой” байдгийн шалтгааныг 80-100 орчим үгэнд багтаан, баримт жишээгээр тайлбарлан бичээрэй.



2

Эхэд мэдрэмж, сэтгэгдлээ хэрхэн илэрхийлснийг ялган уншъя.

- Зохиогч мэдрэмж, сэтгэгдлээ хэрхэн илэрхийлснийг харьцуулан уншаарай.
- Зохиол бүтээлээс төрсөн мэдрэмж, сэтгэгдэл, бодол ухаарлыг эхээс олж, өнгөөр ялган тэмдэглээрэй.
- Зохиол бүтээлийн юу нь онцгой анхаарал татсан, ямар мэдрэмж, сэтгэгдэл төрүүлсэн, түүнийг ямар үг, өгүүлбэрээр илэрхийлснийг дүгнэн ярилцаарай.

Бодит юм үзэгдэл

Мэдрэмж

Сэтгэгдэл

Бодол ухаарал

Д.Нацагдоржийн “Намар” шүлгийг уншаад... Нулимс бөмбөрөм дээрх бадгийг сэтгэл догдлохгүй уншихын аргагүй бөгөөд бидний ердийн ярианд хэрэглэдэг үгс яахаараа Нацагдоржийн шүлгүүдэд ийм **ер бусын ид шидтэй мэт** байраа яг таг эзэлж, **сэтгэл рүү цутгах мэт** орж ирээд, **хамаг эд эсийг тэмтрэх мэт** болдог байна аа!

Дэндүү уйтгартай, зүрх сэтгэл шимшрэм, хамаг бие нялхрам, ертөнцийн салхинд ганцаардам, заримдаа залхуутайяа санагдам мэдрэхүйгээр Нацагдорж бидэнд нэвтэрч, “Сэтгэлийн доторх уйтгарт явдлыг” сэргээн, алив нэгийг дурсан санах, эргэн бодохоос аргагүйд хүргэнэ. Түүний шүлгүүдийг уншсаны эцэст **ертөнцийн амьдрал даанч богино, сайхан хорвоогоосоо салахын мөч ирнэ, бүх юм хугацаатай шүү** гэдгийг **шүүрс алдан бодож**, “Урьхан хонгор салхи өвс модыг намилзуулахад” ... гэж **өөрийн эрхгүй амандаа шивнэх** агаад, **сэтгэл сульдаж, өнгөрсөн одоог эргэцүүлж, амьдралынхаа агшин бүхнийг сэргээн бодмоор болно.**
(О. Дашбалбар)

“Хунт нуур” бүжгийн жүжгийг үзээд... Би “Хунт нуур” үзэх гээд танхимд орж хөгжимчдийг харж суух тэр агшинд хорвоо дэлхий тэр чигтээ энэхүү тансаг ариун танхим шиг санагдсан. Удалгүй хүсэн хүлээсэн мөч ирлээ. Тэрхүү гайхамшигт хунгуудыг харж суухад би яг л тэдний нэг нь болж, хамаг муу муухай бүхнээ орхин одох мэт ариун тансаг мэдрэмж миний бүхий л биеэр долгиж байв. Хөгжим нь бүр гайхалтай. Би жингүйдэж байгаа ч юм шиг. Би өөрөө их хөөрхөн болсон ч юм шиг. Балет дуусаад гэрэл асахад хүн бүхэн их л сайхан санагдаж, бодол, үйлээ ариусгах сан гэсэн хүсэл өөрийн эрхгүй сэтгэлийг минь эзэмдлээ.
(9а анги Г.Аззаяа)

Сооичира бид хоёр. Японы тэрбумтан, агуу зохион бүтээгч Хонда Сооичирагийн “Огторгуйд дүүлэн одох моторт дугуй” хэмээх номыг уншлаа. Ямар мундаг вэ? Миний сэтгэл хөөрч байна. Агуу Хонда...“Хонда мотоцикл унаад, цэлгэр тал нутгаар давхиж яваа юм шиг. Миний цамц салхинд дэрвээд л...нисэж явна...” Би ниснэ ээ, яг Хонда шиг ниснэ дээ... Сооичира хүү мөрөөдлөө биелүүлж, зорьсондоо хүрэхийн тулд мятаршгүй байж чадсан нь гайхамшигтай. Би Сооичира хүүгээр ямар их бахархаж бас түүнд атаархаж байна гээч. Тэр чадсан шүү. Би бас чадна аа. Хонда мотоциклын сүнгэнэсэн зөөлөн дуу миний чихэнд сонсогдсоор л... Би энэ дууг хэзээ ч мартажгүй байж зорьсондоо хүрч гайхамшигийг бүтээх болно. Би хичээнэ ээ.

(8б анги Д.Батзориг)



(Л.Бавуудорж “Эх”)

Уран зургийн галерейд

... Ороход л ямар нэгэн зүйл санааг минь эзэмдэж, би өөрөө өөртэйгөө анх удаа нэлээн удаан яриу.

Зураг харцаараа ярьдаг юм билээ. Л.Бавуудоржийн “Эх” зурагт захиагаа базан барьж буй ээжийн нүд хэн нэгнийг надаас нэхээд байх шиг. ...Тэр надад уйлан байж юу гэж хэлснийг минь мэдмээр байна уу. “Эжий рүүгээ гүй”
(9а анги Б.Одмаа)

- а. Эхээс мэдрэмж, сэтгэгдэл, бодол ухаарал илэрхийлсэн үгсийг хүснэгтэд бичээд, тус бүрийн онцлогийг тодорхойлж, дүгнээрэй.

Эх	Мэдрэмж	Сэтгэгдэл	Бодол ухаарал
Хунт нуур			
Сооичира бид хоёр			
Уран зургийн галерейд			
Дүгнэлт			

- б. Бодол ухаарлаа илэрхийлэхэд “өөрийн төлөөний үг” түлхүү хэрэглэсэн учрыг тайлбарлана уу.

... Юрий Нагибины “Женя Румянцева” өгүүлийг уншаад чимээгүй уйлж, бага насаа үгүйлэв. Юутай сайхан цэвэр тунгалаг, мөрөөдөмтгий, тусч хөвгүүн явж вэ? Тэр бүхнээсээ аажуухан хөндийрч, аль нэг талаараа өөрөөсөө холдох зам руу хазайж л байж... Хэн нэгэнд гомдох, гомдлоо илэрхийлэх нь ичгүүртэй юм. Өөрийгөө өрөвдөж, өөрийгөө хайрладаг хүн л их гомдомтгой байдаг аж.

Алив бүхнийг уучилж чаддаг болсон цагтаа л чи хүн болно гэж өөртөө хэлж байна. Өөрийгөө ажиж, өөрийгөө ямар хүн болохыг мэдэх сэн, өөрийгөө алив бүхэнд шалгах сан гэж л зүтгэж байна. Өөрийнхөө муу чанараас ангижрах юм сан гэж шаналж байна. Би амархан гомдомтгой, хэтэрхий түргэн, онгиороо зантай аж...

(О.Дашбалбар)

- в. Мэдрэмж, сэтгэгдэл гэж юу вэ? Ярилцаарай.

Бүтэц, агуулга	Жишээ	Ямар үг, өгүүлбэрээр ихэвчлэн илрэх вэ?	
Мэдрэмж	Харах -	Нүд гялбуулах шиг	<ul style="list-style-type: none"> ◆ Тэмдэг нэр ◆ Дүрслэх дуурайх үг ◆ Баймж үг ◆ Бүтэц бус өгүүлбэр ◆ Хэлц үг ◆ Адилтгасан, жишсэн өгүүлбэр
	Үнэрлэх -	Агь гангын үнэр сэнхийх мэт	
	Амтлах -	Намрын айраг амтагдах мэт	
	Хүрэлцэх -	Булбарай арьс	
	Сонсох -	Булгийн хоржигноон мэт	
Сэтгэгдэл	Эерэг сэтгэгдэл	Гайхалтай санагдлаа.	<ul style="list-style-type: none"> ◆ Жинхэнэ нэр ◆ Тэмдэг нэр ◆ Үйл үг ◆ Баймж үг ◆ Хэлц үг
	Сөрөг сэтгэгдэл	Уйтгартай байна.	



Мэдрэмж, сэтгэгдлээ илэрхийлье.

а. Сэтгэгдэл, мэдрэмжээ илэрхийлэхэд ямар ямар үг хэрэглэж болох вэ? Тус бүр 10-аас дээш холбоо үг жагсааж бичээрэй.

Мэдрэмж

(Таван мэдрэхүйд мэдрэгдсэн зүйл)

.....
.....
.....

Сэтгэгдэл

(Мэдрэмжээс үүдсэн бодол)

.....
.....
.....



б. Зохиол бүтээлээс төрсөн сэтгэгдэл, мэдрэмжээ илэрхийлж ярья.
(кино, уран зураг, ном, хөгжим, дуу ...)

Ярихын
өмнө...

- ◆ Мэдрэмж, сэтгэгдэл илэрхийлэх үгийн жагсаалтаас ашиглаарай.
- ◆ Ойлгохгүй үг байвал утгыг нь мэдэж аваарай.
- ◆ Үгсийг өнгө аясаар нь ангилна уу. (эерэг, сөрөг)
- ◆ Мэдрэмж, сэтгэгдлээ тайлбарлан ярих товч төлөвлөгөө гаргаарай.

Ярихдаа анхаарна уу.

- ◆ Зохиол бүтээлийг уншиж, сонсож, харж байхад чамд ямар мэдрэмж төрсөн бэ?
- ◆ Зохиол бүтээлийн юу нь, яагаад сайхан санагдсан бэ? Эсвэл юу нь яагаад таалагдаагүй вэ?
- ◆ Зохиол бүтээлээс юуг ухаарсан бэ?

Өөрийгөө дүгнээрэй.

- ◆ Чи өөртөө итгэлтэй, ойлгомжтой ярьж чадсан уу?
- ◆ Сэтгэгдлээ жирийн уйтгартай байдлаар биш, сэтгэл хөдлөлтэй ярьсан уу?
- ◆ Сэтгэгдэл, мэдрэмж илэрхийлэх үгс хэрэглэсэн үү? Тэдгээр үг нь чиний сэтгэл хөдлөлийг бүрэн илэрхийлж чадсан уу?
- ◆ Уран дүрслэл ашигласан уу? Хэр оновчтой байсан бэ?
- ◆ “Бодит юм, мэдрэмж, сэтгэгдэл, ухаарал” гэсэн бүтцийг гаргаж чадсан уу?
- ◆ Зохиол бүтээлээс төрсөн сэтгэгдлээ тайлбарлан ярьж чадсан уу?

Ярьсны
дараа...



Эхийн бичлэгийн төрлийн онцлогийг мэдэж, үзэл бодлоо илэрхийлье.

- ◆ Эхийн бичлэгийн төрлийн онцлогийг мэдэх
- ◆ Эхээс зохиогчийн үзэл бодлыг олох
- ◆ Үзэл бодлоо илэрхийлсэн аргатай танилцах
- ◆ Үзэл бодлоо илэрхийлэх

II

5

Үзэл бодол гэж юу вэ? Ярилцъя.

а. Цогцолбор болон холбоо үгсийн утгыг тайлбарлан ярилцаарай.



Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх нь хүний салшгүй, төрөлх эрх бөгөөд түүний эрхэм “зорилго”, утга учир нь нийгэм, олон нийтэд мэдээлэл, соёл, үзэл бодол түгээж, нийгмийн ухамсар, соёлыг төлөвшүүлэх явдал гэж үздэг.

Хүн бүр уран сайхны алив арга хэрэгслийг ашиглан, үзэл бодлоо илэрхийлэх эрхтэй юм. Аливаа асуудлыг шүүмжилсэн дуу, шүлэг зохиох, уран зураг зурах, нөхөрсөг шог, фото эвлүүлэг хийх, баримтат болон уран сайхны кино бүтээж, нийтэд түгээх зэргээр үзэл бодлоо илэрхийлэх нь олон нийтийн анхаарлыг маш их татдаг.

(Мэдэх эрх: Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх “Глоб Интернэшнл” ТББ, 2005)

Үзэл бодлоо илэрхийлэх

Өөрийгөө илэрхийлэх

Үзэл бодол зөрөх

Үзэл бодлоороо нэгдэх

Үзэл бодлоо хамгаалах

Өөрийн гэсэн итгэл үнэмшил

Үзэл бодлын эрх чөлөө

б. Дараах үгийн утгыг ярилцаарай. Тайлбараа толь бичигтэй харьцуулж, утгыг нь мэдэж аваарай.

- ◆ Үзэл -
- ◆ Бодол -
- ◆ Үзэл бодол -



“Үзэл бодол”-төлөвшин тогтсон санаа. “Үзэл”-ямар нэг юмны талаар хатуу баримталсан санал бодол. “Бодол”-хүний оюун санааны илэрхийлэл.


(“Монгол хэлний хураангуй тайлбар толь бичиг” Монсудар УБ., 2009)



6

Эхийг уншиж ойлгон, бичлэгийн онцлогийг мэдье.

а. Уншигчийн захидлын бүтцийн дагуу эхийг анхааралтай уншаарай.



Давтаагүй хэдэн санаа

(Зохиолч П.Баярсайханд хүргэх ил захидал. Товчлон авав.)

Сайхан зусаж байна уу? Анд минь. Өнөөдөр 1993 оны 7дугаар сарын 27.

Найз нь Сэлэнгэ мөрнийг өгсөж уруудан загас гөхдөж өнжив. Сүүлийн хэд хоног "Хорвоо дэлхий уудам, хийх ажил их байна" гэсэн ядуу байгаад баян болсон ажил хэрэгч нэгэн солонгос хүний сэтгэл уужруулах сайхан үг сэтгэлээс салахгүй байна. Бодвол өөрийгөө "хэтэрхий их амарлаа" гэж дургүйцэж байгаа ч юм уу, аль эсхүл "Баяраа минь, өдийд насныхаа бүтээлийг туурвих учиртай шүү. Бүү алгуурла" хэмээн сануулах хүсэл төрсөнтэй холбоотой ч байж мэдэх юм. Гэхдээ энүүхнийг дуулгах гэж захидал бичээгүй юм шүү. Учир нь чиний "Хөх туурийн тал", "Анир гүн нутаг минь", "Гэрэл гэгээг хүснэ" зэрэг хэдэн номыг нааш чирж, навтартал уншсанд байгаа юм.

Үнэнийг хэлэхэд, чиний зохиолыг их амтархан уншдаг хэрнээ "амттайн" учир шалтгаан юундаа байдгийг ялгаж чадахгүй байлаа. Чи уучлах биз ээ.

Чухам өнөө үед алдагдан буй монгол хүний сэтгэлийн дотоод сайхан чанарууд чиний өгүүллэгт нэн ултай, итгэл үнэмшилтэй байгаа нь баярлуулж байна. Тэгэхдээ бүр хуулчихсан юм шиг амьд тодорхой шүү. Энэ бол чиний зохиолын дүрийн үнэт чанар, давтагдашгүй шинж, эрэл нээлт нь мөн. "Хөх туурийн тал"-ыг дуутай, нулимстай туулж яваа Лувсан өвгөн үнэхээр сайн хүн. Зүгээр ч нэг сайн бус, алт шиг сэтгэлтэй, өрөөлийн төлөө өөрийгөө гаргуунд нь орхиж чаддаг хүн.

Чиний зохиол тэр бүр нийтийг хамарч шуугиан тарьдаггүйд бүү эмзэглэ. Ахуйн дүрслэл, аж байдлын (хөдөөгийн) хэвшлийг дүрийн сэтгэл зүйтэй хослуулан, чи дэндүү нямбай, дэндүү нарийн илэрхийлж... анхаардаг учраас орчин үеийн хот суурингийн өвөрмөц ...амьдралд өссөн хийгээд дассан уншигчдад чиний зохиол... залхаг уйтгартай амьдрал, соёлгүй бүдүүлэг орчин, хэтэрхий гэнэн цагаан сэтгэл, үлгэр домгийнх мэт ойлгогдохгүй... хүмүүсийн тухай мэт санагдаж болох юм. Хот суурин, хөдөөгийн хүмүүсийн хооронд, ер нь монгол хүний амьдрал, хүсэл мөрөөдөл, сэтгэл санаанд асар том зааг гарчээ. Энэ сэдэв жинхэнэ зохиолчийн, тэр тусмаа сэтгэл зүйн чиглэлийг баримталдаг чиний хувьд зөв сонголт.



Харин, сайхан сэтгэлт өтгөстэй зөрчилдөж буй залуусын дүр бол чиний өгүүллэгийн гол баатрууд. Үүнд чиний сэтгэл эмзэглүүлсэн санаа, хөндсөн асуудал, зохиолын зөрчил байгаа юм. Энэ нь зохиолчийн арга барил үнэхээр шинэ болохыг харуулж байна. Жишээ нь, "Тавиул" өгүүллэгийн гол дүр нь өвөө эмээ хоёр бус, Ариун хүү, тавиул үнээний тугал, багш хүүхэн гурав. Тэд цөм "тавиул". Тавиул үнээ тугалаа хаян хээр хононо. "Мөндөл" хочит Ариуны эх хүүгээ хаяад хотод одсон. Цонхоор харж, сэтгэлт залуугаа бодон гуниглах багш хүүхэн бол хөдөө хөөгдсөн "засгийн тавиул". Тэдний хувь тавилан заяа төөрөг бол чиний өгүүллэгийн амин сүнс, гол санаа, үндсэн зөрчил шүү дээ.

Өөр нэг сонирхолтой эрэл бол "жижиг" хүмүүсийн дүр юм


"Чулуу" өгүүллэгийн Арилдий юутай сайхан дүр төрх вэ? Бас "Тавиул"-ын чинь Дарамын дүрийг их тоолоо. Тэд орчлонгийн хамгийн ариун сайхан хүмүүс! Чиний Барьд ("Чулуу"), Лувсан ("Хөх туурийн тал"), Дэлэг ("Сармагчин бол сармагчин"), Катя ("Улаан малгайтай охин") зэрэг шилдэг дүрүүдээс ч давжээ. Бага залуу насны олон сайхан хүмүүстэйгээ чиний зохиолоор уулзаад, атга эззгий аваад эргэхдээ эмээгийн сэтгэлийн зовуурийг мэдэрдэг, өвөөгийнхөө элгэнд наалдаад нөмөр нөөлгийг нь ухаардаг, Арилдий ахыг хараад цүнхээ шүүрэн сургууль руу жирийдэг, Барьд, Лууз мэтийг хараад бяцхан зүрхэндээ уур хилэн бадруулж явсан жаалхүү л хөдөөгийн тухай, ер бусын сайхан хүмүүсийн тухай, тэдний сэтгэл санааны агуу их ертөнцөөр уншигчдаа дагуулж чадна. Чи чаджээ.

Амьдралын жинхэнэ утга учир алдагдаж, хүн чанар гэдэг эрхэм зүйл нь хагасарч байгаа эдүгээ цагт чиний өгүүллэгүүд хүмүүст гэрэл гэгээг өгч чадна. Өгүүллэгийг чинь унших тусам хүнийг, тэр дундаа өтгөс буурлуудаа хайрлаж халамжлах, өргөн хүндэтгэх, өөрсдийгөө хянан байцааж, цагийн жам дагасан монгол хүний сэтгэл дэх хүн чанарын мөстлөгийг хэмхчин балбамаар. Цаг орой болжээ. Захидлаа дуусгаж амжсангүй. Хүндэтгэн ёслол. (Д.Галбаатар)

б. Цогцолбор бүрийн гол өгүүлбэрт тулгуурлан, эхийн гол санаа, сэдвийг тодорхойлоорой.

Эхийн сэдэв Яагаад?

Эхийн гол санаа Яагаад?





- в. “Давтаагүй хэдэн санаа” эхийг уншигчийн захидлын бүтэц, онцлогийн дагуу задалж, хүснэгтэд дутууг нөхөж, бичээрэй. Уншигчийн захидлын бүтэц, онцлогийн талаар ойлголтоо нэгтгэж, дүгнэж ярилцана уу.

	Агуулга	“Давтаагүй хэдэн санаа” - эхээс жишээ бичих
Эхлэл	Зохиогчийн ба номын нэрийн тухай товч танилцуулга бичих	
Үндсэн хэсэг	Уншсан номынхоо сэдэв, гол санааг дүгнэн бичих. Гэхдээ номын талаар бүгдийг ярих хэрэггүй. Гол санааг л дүгнэнэ	Чухам өнөө үед алдагдан буй монгол хүний сэтгэлийн дотоод сайхан чанарууд чиний өгүүллэгт нэн ултай, итгэл үнэмшилтэй байгаа нь баярлуулж байна. Ахуйн дүрслэл, аж байдлын (хөдөөгийн) хэвшлийг дүрийн сэтгэл зүйтэй хослуулан, чи дэндүү нямбай, дэндүү нарийн илэрхийлж... Энэ сэдэв жинхэнэ зохиолчийн тэр тусмаа сэтгэл зүйн чиглэлийг баримталдаг чиний хувьд зөв сонголт. Тэдний хувь тавилан заяа төөрөг бол чиний өгүүллэгийн амин сүнс, гол санаа, үндсэн зөрчил шүү дээ.
	Сэтгэгдлээ тайлбарлах Таалагдсан бол яагаад? Үгүй бол яагаад?	
	Зохиолоос хамгийн сонирхолтой нь юу байв? Энэ нь зохиолын баатар, үйл явдал, дүр дүрслэл, орчин гэх мэт аль нь ч байж болно. Хамгийн гол нь яагаад анхаарал татсан бэ? гэдгийг тайлбарлах	Үнэнийг хэлэхэд чиний зохиолыг их амтархан уншдаг хэрнээ “амттайн” учир шалтгаан юундаа байдгийг ялгаж чадахгүй байлаа. Чухам өнөө үед алдагдан буй монгол хүний сэтгэлийн дотоод сайхан чанарууд чиний өгүүллэгт нэн ултай, итгэл үнэмшилтэй байгаа нь баярлуулж байна. Тэгэхдээ бүр хуулчихсан юм шиг амьд тодорхой шүү. Энэ бол чиний зохиолын дүрийн үнэт чанар, давтагдашгүй шинж, эрэл нээлт нь мөн. Хот суурин, хөдөөгийн хүмүүсийн хооронд ер нь монгол хүний амьдрал, хүсэл мөрөөдөл, сэтгэл санаанд асар том зааг гарчээ. Энэ нь зохиолчийн арга барил үнэхээр шинэ болохыг харуулж байна.
Номын баатруудын тухай хэдэн үг хэлэх. Гол баатар, туслах дүрүүд нь хэн бэ? Аль дүр нь таалагдаж байна вэ? Яагаад? Баатруудын үйлдэлтэй санал нийлж байна уу? Эсвэл арай өөр бодолтой байна уу?		
Төгсгөл	Уншсан ном бүтээл чамд юуг ухааруулж, юунд сургасан болохыг дүгнэнх. Зохиолд хамгийн үнэтэй санаа нь юу байв?	Амьдралын жинхэнэ утга учир алдагдаж, хүн чанар гэдэг эрхэм зүйл нь хагасарч байгаа эдүгээ цагт чиний өгүүллэгүүд хүмүүст гэрэл гэгээг өгч чадна. Өгүүллэгийг чинь унших тусам хүнийг, тэр дундаа өтгөс буурлуудаа хайрлаж халамжлах, өргөн хүндэтгэх, өөрсдийгөө хянан байцааж цагийн жам дагасан монгол хүний сэтгэл дэх хүн чанарын мөстлөгийг хэмхчин балбамаар.

7

Эхээс зохиогчийн үзэл бодлыг олъё.

- а. Дараах өгүүлбэрийг анхааралтай уншаад, зохиогчийн үзэл бодол мөн эсэхийг батлаарай.
- б. Зохиогчийн үзэл бодол мөн эсэхийг өгүүлбэр дэх ямар үг, санаанаас үүдэн дүгнэснээ тайлбарлаарай.
 - ◆ Чухам өнөө үед алдагдан буй монгол хүний сэтгэлийн дотоод сайхан чанарууд чиний өгүүллэгт нэн ултай, итгэл үнэмшилтэй байгаа нь баярлуулж байна.
 - ◆ Хот суурин, хөдөөгийн хүмүүсийн хооронд, ер нь монгол хүний амьдрал, хүсэл мөрөөдөл, сэтгэл санаанд асар том зааг гарчээ.
 - ◆ Амьдралын жинхэнэ утга учир алдагдаж, хүн чанар гэдэг эрхэм зүйл нь хагасарч байгаа эдүгээ цагт чиний өгүүллэгүүд хүмүүст гэрэл гэгээг өгч чадна.
 - ◆ ...монгол хүний сэтгэл дэх хүн чанарын мөстлөг ...
- в. Дээрх өгүүлбэрүүдийн цөм өгүүлбэрийг ялган тэмдэглээрэй.
- г. Дээр тэмдэглэсэн цөм өгүүлбэрийн санааг нэг өгүүлбэрт хураах замаар зохиогчийн үзэл бодлын гол санааг бичээд, бусдадаа уншиж, харьцуулж ярилцаарай.

8

Үзэл бодлоо илэрхийлэх аргад суралцъя.

- а. Зохиогч үзэл бодлоо ямар баримт жишээнд үндэслэн илэрхийлсэн байна вэ? Дараах хүснэгтээс ажиглаарай.

	Үндэслэл	Зохиогчийн үзэл бодол
1	... хот суурингийн өвөрмөц ...амьдралд дассан уншигчдад чиний зохиол... залхаг уйтгартай амьдрал, соёлгүй бүдүүлэг орчин, хэтэрхий гэнэн цагаан сэтгэл, үлгэр домгийнх мэт ойлгогдохгүй... хүмүүсийн тухай мэт санагдаж болох юм.	... ер нь монгол хүний амьдрал, хүсэл мөрөөдөл, сэтгэл санаанд асар том зааг гарчээ.
2	◆ ... сайхан сэтгэлт өтгөстэй зөрчилдөж буй залуус ...	Чухам өнөө үед алдагдан буй монгол хүний сэтгэлийн дотоод сайхан чанарууд...
3	◆ “Мөндөл” хочит Ариуны эх хүүгээ хаяад хотод одсон.	Амьдралын жинхэнэ утга учир алдагдаж, хүн чанар гэдэг эрхэм зүйл нь хагасарч байгаа эдүгээ цагт ...
4	◆ Барьд, Лууз мэтийг хараад бяцхан зүрхэндээ уур хилэн бадруулж явсан жаалхүү лмонгол хүний сэтгэл дэх хүн чанарын мөстлөг ...



- б. Үзэл бодлоо баримтад үндэслэн илэрхийлэхийн учрыг бичнэ үү. Дараах баримтын төрлөөс зохиогч алийг нь ашигласан байна вэ? Эхээс жишээ хэлнэ үү.

Баримтад юу юу багтах вэ?

Баримт	Амьдралаар болон шинжлэх ухаанаар баталж нотолсон зүйл
Тоон мэдээлэл	Тоогоор илэрсэн баримт
Үйл явдал	Сонгож авсан жишээ, үйл явдал

- в. Үзэл бодол хөдөлшгүй баримт мөн үү? Мөн бол яагаад? Үгүй бол яагаад? Үзэл бодол, баримтын ялгааг ярилцаарай.
- г. Үзэл бодлоо илэрхийлэхдээ дараах бүтцийг ашиглавал үр дүнтэй байх эсэх талаар хүүхдүүдийн бичсэнтэй (дор байгаа) харьцуулан, хэлэлцээрэй.

1	Үзэл бодлоо бүрэн илэрхийлж чадах өгүүлбэр бич.
2	Баримтаар нотол.
3	Дүгнэ.

Жишээ нь: С.Эрдэнэ “Өвгөн шувуу” (Дорноговь аймаг, 9а анги, Д.Угтахжаргал)

1	Энэ бол монгол хүнд л байдаг байх гэмээр мундаг ухаан.
2	Хэчнээн сайхан салж болмооргүй ертөнц боловч Гээгтийн дуулдаг өвгөн шувуу буцах цаг болжээ. Жаран хэдэн жил дэлхийн тоос хөдөлгөж их юм үзлээ. Гомдол алга. Сайн ханьтай, голомт залгах хүүтэй, сайхан нөхөдтэй жаргаж явлаа. Ийм тийм юм дутуу дунд байсан гэж гажрах юм алга...
3	“Тэхийн зогсоол”-оос амьдарснаа эргээд харахад “харамсах юмгүй” байна гэдэг бахархал. Жав гуай яг л ингэж амьдарчээ.

Жишээ нь: С.Эрдэнэ “Өвгөн шувуу” (Увс аймаг, 9б анги, С.Оюунбилэг)

1	Нутгийн минь өвгөдийн нуруун дээр л нутаг орон минь явдаг байх.
2	Яг л уулс шиг ханхайсан, амьдралын ноён нуруутай, дээд сургууль төгсөөгүй ч, хэний ч өмнө толгой өндөр байж чаддаг сайхан өвгөд нутагт минь байдаг.
3	Тэд санаснаараа амьдраад, санаснаараа буцна. Гарцаагүй.



**Мэдрэмж, сэтгэгдэл,
үзэл бодлоо
илэрхийлье.**

- ◆ Асуудал дэвшүүлэн, хэлэлцэх
- Хэлэлцүүлэгт бэлтгэх
- Өөрийгөө сорих
- ◆ Уншсан номын талаарх сэтгэгдэл,
үзэл бодлоо илэрхийлэх



**Хамгийн сүүлд хэзээ, хэнийг ятгаж, үзэл бодлоо
зөвшөөрүүлсэн тухай ярилцаарай.**

- а. “Давтаагүй хэдэн санаа” захидал дахь уншигчийн дүгнэлтээс асуудал дэвшүүлэн, үзэл бодлоо илэрхийлж, хэлэлцүүлэг хийнэ үү.



Амьдралын жинхэнэ утга учир алдагдаж, хүн чанар гэдэг эрхэм зүйл нь хагасарч байгаа эдүгээ цагт чиний өгүүллэгүүд хүмүүст гэрэл гэгээг өгч чадна.

Өгүүллэгийг чинь унших тусам хүнийг, тэр дундаа өтгөс буурлуудаа хайрлаж халамжлах, өргөн хүндэтгэх, өөрсдийгөө хянан байцааж, цагийн жам дагасан монгол хүний сэтгэл дэх хүн чанарын мөстлөгийг хэмхчин балбамаар.



Хэлэлцүүлэгт бэлтгээрэй.

- ◆ Зохиогчийн дүгнэлтийг уншаад чамд ямар сэтгэгдэл төрж байна вэ?
- ◆ Дүгнэлтийн талаарх өөрийн байр суурь, үзэл бодлыг тодорхой илэрхийл. Өөрөөр хэлбэл, яг ямар санаа гаргаахад тодорхойл.
- ◆ Үзэл бодлоо хүлээн зөвшөөрүүлэхийн тулд бусдыг ятган үнэмшүүлэх шаардлагатайг анхаар.
- ◆ Тухайн сэдвийг аль талаас нь харж, хэлэлцүүлэгт оролцох гэж байгаагаас хамаараад, мэдээллээ цуглуул.
- ◆ Үзэл бодлоо хүлээн зөвшөөрүүлэх баримт жишээг жагсаан бич.
- ◆ Баримтад юу юу хамаардгийг өмнөх хуудсаас эргэн харна уу.
- ◆ Баримтаа үр дүнгээр нь эрэмбэл. Чи ямар баримт нотолгоог хамгийн чухал гэж үзэж байна вэ? Яагаад гэдгээ тайлбарлаарай.
- ◆ Үзэл бодолдоо хамгийн сайн дэмжлэг болох гол чухал нотолгоог хаана байрлуулахаа шийд. Бусдын туршлагаас харахад, ийм баримтыг хамгийн сүүлд байрлуулдаг жишээ бий.
- ◆ Баримтуудыг учир зүйн хувьд зөв холбовол үр дүнтэй болдог тул хэрхэн холбохоо сайтар бод, ноорогло.
- ◆ Баримт жишээ, үзэл бодлыг тань үнэхээр нотолж байна уу? гэдгийг хяна.
- ◆ Төгсгөлд нь санаагаа хураангуйлж дүгнээрэй.



Үзэл бодлоо оновчтой илэрхийлэхийн тулд дараах бүтцийг ашиглаарай.

1	Үзэл бодлоо бүрэн илэрхийлж чадах өгүүлбэр бич.
2	Баримтаар нотол.
3	Дүгнэ.

Үзэл бодлоо илэрхийлэхдээ дараах үгсээс сонгоорой.

- ◆ Миний туршлагаар...
- ◆ Миний үзэж байгаагаар...
- ◆ Миний бодоход...
- ◆ Онцолж хэлэхэд...
- ◆ Юу гэж хэлэх гээд байна вэ гэхээр...
- ◆ Миний хувьд ... гэдэг нь ойлгомжтой.
- ◆ Би ...үнэхээр итгэлтэй байна.
- ◆ Би ... гэдэгт эргэлзэхгүй байна.
- ◆ Би ... гэж л бодоод байна даа.
- ◆ Миний ойлгосноор...
- ◆ Хүмүүс ... гэж боддог.
- ◆ Зарим хүн... гэж хэлдэг.
- ◆ Ер нь ... гэж тооцдог.
- ◆ Баримтаас харахад... гэж болохоор байна.
- ◆ Харваас...
- ◆ Мэдээжийн...
- ◆ Миний олж мэдсэнээр...
- ◆ Би... гэж зөвлөх байна.
- ◆ Тэгэлгүй яах вэ.
- ◆ Яах аргагүй чиний зөв.
- ◆ Тийм ээ, би хүлээн зөвшөөрч байна.
- ◆ Сонин санаа байна.
- ◆ Санаа нийлж байна.
- ◆ Би ч адил.
- ◆ Яг миний бодож байсан зүйл байна.
- ◆ Яг зөв.
- ◆ Тэр чинь өөр хэрэг.
- ◆ Чамтай санал нийлэхгүй байна.
- ◆ Гэхдээ л ...
- ◆ Яг ч тийм биш л дээ.
- ◆ Эсрэгээрээ...
- ◆ Наадах чинь огт өөр зүйл.
- ◆ Тийм ээ.
- ◆ Энэ талаар би тийм ч итгэлтэй биш байна.
- ◆ ...гэж хэлэх үндэслэл алга.



Өөрийгөө сорьё.

	Шалгуур	Үнэлгээ
1	Үзэл бодлоо бүрэн илэрхийлж чадсан уу?	
2	Баримт жишээгээр санаагаа сайн дэмжиж, нотолж чадсан уу?	
3	Баримтаа учир зүйн хувьд зөв холбож, хэрэглэж чадсан уу?	
4	Үзэл бодлоо илэрхийлэхдээ загвар ашигласан уу?	
5	Чөлөөтэй ярилцаж, үзэл бодлоо хамгаалж чадсан уу?	
6	Бусдын үзэл бодолд хүндэтгэлтэй хандаж чадсан уу?	
7	Үзэл бодлоо нотлоход чиний тайлбар яриа оновчтой байж чадсан уу?	





**УНШСАН НОМЫН ТАЛААР СЭТГЭГДЭЛ,
ҮЗЭЛ БОДЛОО ИЛЭРХИЙЛЦГЭЭ.**

ЭХЛЭЛ

Зохиолчийн тухай

- ◆ Чи зохиолчийн тухай юу мэдэх вэ? Хамгийн чухал гэсэн мэдээллээ бичээд, түүнд юуны тул, ямар учраас талархсанаа бичээрэй.

Номын нэрийн тухай

- ◆ Чиний уншсан ном ямар нэртэй вэ? Унших сан гэсэн сонирхол төрүүлэхээр нэрлэсэн байна уу? Гэх мэт цөөн үгээр бичиж болно.

ҮНДСЭН ХЭСЭГ

- ◆ Чиний сонгосон ном юуны тухай өгүүлдэг вэ? Гол санаа нь юу вэ? Тэр нь юунд сургаж, юуг ухааруулсан бэ? (Номын талаар дахин дэлгэрэнгүй ярих хэрэггүй. Хамгийн гол санааг л тусгах.)
- ◆ Зохиол бүтээл чамд таалагдсан эсэх. Гэхдээ яагаад гэдгийг заавал нээж бичнэ. Зохиолын үйл явдал чамд ямар мэдрэмж, сэтгэгдэл төрүүлсэн бэ? Яагаад? (баяр хөөр, уйтгар гуниг, уур хилэн) Юугаараа чамайг догдлуулсан бэ?
- ◆ Анхаарал татсан онцгой хэдэн жишээг заавал дурдаарай. Энэ нь зохиолын баатар түүний үйл хэрэг, дүр дүрслэл, орчин гэх мэт аль нь ч байж болно. Хамгийн гол нь яагаад анхаарал татсан бэ? гэдэгт хариулахаа мартуузай.
- ◆ Чи баатруудын үйл хэрэгтэй санал нийлж байна уу?, эсвэл арай өөрөөр шийдэх байсан уу? Аль баатар нь чамд яагаад таалагдаж байна вэ?
- ◆ Чамд юуг бодуулж, ухааруулсан бэ?
- ◆ Зохиогчийн үзэл бодол чиний үзэл бодолтой нийлж байна уу? Үзэл бодлоо нотлох баримтыг сайн дурдаарай.
- ◆ Зохиолын талаарх үзэл бодлоо баталж нотолж бичээрэй.

ТӨГСГӨЛ ХЭСЭГ

- ◆ Уншсан ном бүтээл чамд юуг ухааруулж, юуг сургасан болохыг дүгнээрэй.
- ◆ Номын үнэ цэнтэй санааг дүгнэж бичээрэй.

Ноороглон бичих

Зохиолоос чиний санаанд үлдсэн, онцгой сэтгэгдэл төрүүлсэн ямар сонин содон үйл явдал болон үг хэллэг, дүрслэл байна, энэ нь чамд юу бодогдуулж, ямар дурсамжийг сэргээж байна гэх мэтээр санаанд буусан бүхнээ шууд буулгаж бичээрэй.

Аливааг бичихэд эхнээс нь эмх цэгцтэй бичнэ гэхээс илүү санаанд орсон бүхнээ бичээрэй. Цэгцэлж хэзээ ч амжина.

3 цогцолборт багтаан бичээрэй.

Зохиолын талаарх сэтгэгдэл, үзэл бодлоо тодорхой илэрхийлж бичсэн үү?

Сэтгэгдэл, үзэл бодлоо бүрэн илэрхийлж чадахаар үг сонгож бичсэн үү?

Номын үнэ цэнтэй талыг сэтгэлдээ хүртэл тайлбарлаж чадсан уу?

Зөв бичих, цэг цэглэл, найруулгын алдааг хянасан уу?

3

ТААМАГЛАЛ ДЭВШҮҮЛЭН ТАЙЛБАРЛАЯ



Эзэмших мэдлэг, чадвар

- ◆ Таамаглал дэвшүүлэн, баталж нотолсон эхийг уншиж ойлгоё.
- ◆ Таамаглал дэвшүүлэн, баталж нотолж, үгүйсгэж бичих аргад суралцъя.
- ◆ Асуудал дэвшүүлж, баримт, үзэл бодлыг хослуулан, санаагаа илэрхийлье.

Таамаглал дэвшүүлэн, баталж нотолсон эхийг уншиж ойлгоё.

- ♦ Ажиглалтаас үүдэн таамаглал дэвшүүлэх
- ♦ Үндэслэлтэй таамаглал дэвшүүлэх

I

1

Үндэслэлтэй таамаглал дэвшүүлэн, нотолж баталсан эхийг уншиж ойлгоё.

Таамаглахын тулд юунаас эхлэх вэ? Загварт байгаа үгсийг доорх бичил эхтэй холбосныг ойлгож ярилцана уу.



Хонь

... Одоогоос мянга таван зуу, түүнээс ч олон жилийн тэртээ монголчууд хониныхоо ачийг санаж, түүнд хөшөө босгодог болжээ... Хануй, Хүнүйн бэлчир дэх хөшөө дурсгалын цогцолборт төгрөг эвэртэй, хундан цагаан хонь оролцсон. Тэр нь одоо ч бий.

Хониндоо яагаад гантиг чулуун хөшөөг өвөг дээдэс босгодог байж вэ? Хонины толгой яагаад бурхдын өмнө, ихэс дээдсийн оршуулгын хойлгонд байдаг байж вэ?

Хонь бидний монголчуудын нууц шүтээн биш гэж үү? Хонь монголчууд бидний голомт унтрахгүй, ураг тасрахгүй явж ирсний нууц сахиул биш гэж үү?

Гэвч хонио, хоньчин монголчууд хэр мэддэг билээ.

Хонийг тэнэг юм уу гээд эрдэмтэд тал бүрээр судлаад үзтэл гайхмаар нээлт гарчээ. Америкийн Корнелийн их сургуулийн эрдэмтэд хонинд хичээл заахад 50 IQ хэмжээний оюуны чадавхтай хүнээс илүү сайн дүнтэй суралцах чадвартайгаа харуулжээ. Хонь бас өвс тэжээлийн өнгө, дүрс, хэлбэрийг сайн ялгаж чадах чадварыг уураг тархиндаа шингээсэн амьтан болох нь илэрчээ...



Сүүлийн жилүүдэд монголын хонин сүргийн тоо толгой буурч байгаа нь бүүр ч гайхмаар... Хонио бид “тэнгэр харуулж”, “буян” хийсээр байтал хонины тэнгэр биднийг хаяузай даа. Амон* тэнгэр минь!

(Л.Түдэв)

Ажиглалт

Асуулт

Таамаглал

Санал

Нотолгоо

Дүгнэлт

* Амон – эртний Мисир улс нарны тэнгэр Амон бурхныг хонин толгойтойгоор дүрсэлдэг байв



Ажиглалт, асуулт, таамаглал, санал, нотолгоо, дүгнэлтийг таамаглал дэвшүүлэн тайлбарласан эхэд утга санааны уялдаа холбоотой илэрхийлэн гаргах аргыг судалцгаая.

Бид таамаглал дэвшүүлэн бичих аргыг судлах гэж байна. Дээрх загварыг эргэж харъя. Таамаглал нь гуравдугаарт байна. Эхлээд **АЖИГЛАХ** нь чухал юм байна.

- ◆ Таамагламаар байгаа зүйл чинь юу байж болох вэ?
- ◆ Ямар нэг юм уу? хүн үү? үйл хэрэг үү?
- ◆ Өөр юу сонгож болох вэ?

Эхийг эхлэхдээ, таамаглахаар сонгож ажигласан зүйл, түүнээс төрсөн асуулт таамаглалаа бичнэ. Юу, юуг ажиглаж болох вэ? Бидний амьдралд эргэлзээтэй олон зүйл байдаг учраас юуг ч ажиглаж болно шүү дээ.


Жишээ нь: “Саравчлах” гэдэг үгийн тухай таамаглал дэвшүүлэхийн өмнө, юунаас үүдэж ажигласан тухайгаа сонирхолтой өгүүлсэн эрдэмтний тэмдэглэлийн хэсгийг уншъя.

Өнгөрсөн жилийн алтан намраар Японы Осака хотод нэг сар байх сайхан “завшаан” тохиож билээ. Бага хугацаанд ч гэсэн, Их наран улсад байхдаа янз бүрийн юм ажиглаж сонирхож явлаа. Нэг сонин зүйл бол хөгшин хөвөө, ахимаг, идэр залуу янз бүрийн насны япон хүмүүс гудамж талбайд ямар нэг юмыг “саравчлан” зогсох нь тун олон юм. Хачин юм, яг монгол хүн шиг.

Юу руу саравчлаад байгаа нь харин сайн ойлгогдохгүй байлаа. Өндөр, өндөр тэнгэр баганадсан байшингийн нэр хаягийг юм уу, завсар зайгүй нисэж бууж буй онгоцуудыг юм уу, аль эсвэл од эрхэс, нар сарыг ч юм уу? нэг л юмыг саравчлаад байх шиг... Тэг тэгсээр “саравчлах” -ын утга учир, монгол ухааны саравчлах сүүдэрлэх арга, ёс заншлын талаар нэг юм бичих санаа төрөгдөж байна аа.

Нүүдлийн соёл иргэншилт монголчуудынхаа “юуруу саравчилдаг?”, “яах гэж саравчилдаг”, “сар - вч” хийгээд “саравчлах” -ын талаар утга соёлын холбогдолтой ганц хоёр баримт бодлоо...

(Б.Пүрэв - Очир)



Энэ хэсгээс таамаглал дэвшүүлэн бичихийн өмнө юунаас, юуг, хэрхэн ажиглаж болдог жишээг харж болох юм байна. Ажигласан зүйлээ эхийн эхлэл хэсэгт сонирхолтой өгүүлж бас болох юм байна.

Монголчууд нүүдлийн ахуй, соёлтой учраас байгальтай харьцаж, байгалийн үзэгдлийн шинж, хувирал, давтамжийг ажиглаж, цаг улирлын байдлыг урьдчилан таамаглаж, ажил төрлөө зохицуулдаг уламжлалтай. Тухайлбал,

“Салхи ихтэй байна. Үхэр ууллах* нь гайгүй байна. Мичид марал орой хэвийж, үүр цайгаад байх боллоо. Ингээд бодохлоор өнтэй өвөл болж магадгүй. Харин хавар л зүтгүүдүү* болох байх.”

гэхэд тодорхой баримт, тухайлбал, байгалийн үзэгдэл, мал амьтны шинж байдлыг ажиглан, түүнд үндэслэж, өвөл, хавар ямар болохыг урьдчилж таамагласан байна.

Таамаглалын үндэс нь байгалийн үзэгдэл, мал амьтны шинж байдал, од мичдийн орчил, нар сарны явдал. Бодит байдал, баримтыг үндэслэж, таамагласан.

Одоо ажиглалтаас төрсөн асуулт таамаглалыг хэрхэн нотолж баталж бичсэнийг уншъя. Ямар нэг түүхэн зургийг ажиглаж болох юм.

Дараах зургийн түүхээс сэдэвлэн таамаглал дэвшүүлэн тайлбарласан эх хэрхэн бичсэнийг задалж үзье.



Улсын Драмын Эрдмийн Театр 1930 -аад оноос хойш бараг саяхан болтол буюу 2011 он хүртэл нум сум харваж буй хүний дүрстэй бэлгэ тэмдэг хэрэглэж байсныг үзэгч олон мэдэх байх. Энэхүү бэлгэ тэмдгийг анх ямар хүн зурсан юм бол?

- ◆ Нум сум харваж байгаа хүн бол монгол дээлтэй, монгол гуталтай, монгол малгайтай эрэгтэй хүн байна. Энэ бол монгол хүн байна.
- ◆ Бас морин хуур байна.
- ◆ Дугуй дүрсээр, магадгүй нарыг бэлгэдсэн байх. Монголчууд нарыг дээдлэн шүтдэг. Цай, сүүнийхээ дээжийг наранд өргөдөг. Эдгээрээс үзвэл, үүнийг монгол зураач зурсан бололтой.

Асуултаас олон янзын таамаглал төрнө. Таамаглахын тулд сонгосон зүйлээ олон талаас нь дахин сайтар ажиглана. Энэ зураг дээр юу юу байна вэ?

* ууллах – уул руу бэлчих, уул өөд явах

* зүтгүүдүү – хэцүү хатуу, урт, хахир хүйтэн



Одоо таамаглалаа нотлохын тулд эрэл хайгуул, судалгаа хийснээ илэрхийлнэ. Ямар ямар хүнтэй уулзаж, асууж, сурагласан байна вэ?

Мэдэж магадгүй гэсэн эрдэмтэн мэргэд, театрын ахмадуудаас бишгүйдээ асууж явлаа. Даанч тоймтой хариу хэлэх хүн олдоогүй юм. Харин театрын музейн дарга асан, музей судлаач Д.Цэдмаа “Чи Н.Цүлтэм гуайн дүрслэх урлагийн тухай номыг шүүгээд үзээрэй. Тэнд театрын логог хэн зурсан тухай нэг өгүүлбэр харсан санагдах юм” гэж хэлсэн сэн.

Тэр дагуу номын сангаас ардын зураач Н.Цүлтэмийн хэдэн номыг эргүүлж үзлээ. Гэтэл Н.Цүлтэм абугайн 1988 онд хэвлүүлсэн “Монголын уран зургийн хөгжиж ирсэн товч тойм” номын 78 дугаар талд эрлийг минь мухарлах нэг өгүүлбэр гарч ирж байна аа. Тэнд бичихдээ: “Гучаад оны эхээр Монголд ажиллаж байсан Нина Петровна Бехтеева Монголын орчин үеийн реалист театрын тайз чимэглэлийн урлаг үүсэн хөгжихөд зохих хувь нэмрээ оруулсан юм. Н.П.Бехтеева “Харц Дамдин, хатан Долгор”, “Учиртай гурван толгой” зэрэг монгол жүжгийн тайз засал, тэр үеийн монголчуудын аж байдлыг харуулсан уран зургууд зурж, мөн түүний “Хувьсгалт уран сайхныг олон түмэнд нэвтрүүлэе” гэсэн бичигтэй нум сум хөвчилж байгаа монгол хүний зураг нь одоо манай Нацагдоржийн нэрэмжит Улсын драмын академик* театрын эмблем* тэмдэг болсоор байна” гэжээ.

Судалгаа, эрэл хайгуул хийснээр, баримтаар нотолж байгаагаа харуулна. Баримт, нотолгоогоо хаанаас олсон байна вэ?

Үр дүн, дүгнэлт нь асуултын хариу байж чадаж байна уу?

Улсын Драмын Эрдмийн Театрын анхны бэлгэ тэмдгийг монгол зураач биш орос зураач, тэр тусмаа эмэгтэй хүн зурсан юм байна.


* академик - үүнийг “эрдмийн” хэмээн монголчилсон

* эмблема - орос хэлний “бэлгэ тэмдэг” гэсэн утгатай үг





Таамаглал дэвшүүлэн тайлбарласан эхэд таамаглалаа нотлохын тулд судалгаа хийж, баримтад тулгуурласнаа харуулах нь чухал юм байна.



Дээрх эхийг юугаар нь таамаглал дэвшүүлэн нотолж тайлбарласан эх болсон гэж үзэж байна вэ?



Асуулт таамаглал нь: Энэхүү бэлгэ тэмдгийг анх хэн гэдэг хүн зурсан юм бол? Монгол хүн зурсан байх.

Судалгаа нь: Эрдэмтэн мэргэд, театрын ахмадуудаас төдийгүй театрын музейн дарга асан, музей судлаач Д.Цэдмаагаас асуусан

Баримт нь: Н.Цүлтэм абугайн 1988 онд хэвлүүлсэн “Монголын уран зургийн хөгжиж ирсэн товч тойм” номын 78 дугаар талд ...

Нотолгоо нь: Н.П.Бехтеевагийн “Хувьсгалт уран сайхныг олон түмэнд нэвтрүүлэе” гэсэн бичигтэй, нум сум хөвчилж байгаа монгол хүний зураг нь одоо манай Нацагдоржийн нэрэмжит Улсын драмын академик театрын эмблем тэмдэг болсоор байна” гэсэн өгүүлбэр

Дүгнэлт нь: Театрын анхны бэлгэ тэмдгийг монгол хүн биш орос хүн зурсан юм байна.




Уран зураг ажиглаж таамаглая.


- ♦ Уран зураг дээр хэн, юу байна вэ? (ямар хүн, ямар амьтан, эд юмс, газар орон, хэлбэр, өнгө, хөдөлгөөн, дуу чимээ, чамд ойлгогдохгүй сонин дүрслэл гэх мэт бүгдийг)
- ♦ Зураач юу юуг, ямар утга илэрхийлэх гэж зурсан юм бол? Зургийг аль талаас нь эхэлж хармаар байна? Бусдын олж ажиглаагүй сонин зүйлийг гаргаж ирэхийг хичээ. Зураг дээр дүрсэлсэн юмс, өнгөний хослол, өвөрмөц дүрслэл г.м. “Нээрээ энэ ямар сонин юм бэ?” гэж бодогдохоор бичихийг хичээгээрэй.
- ♦ Шонгийн модны цуваа шулуун, зам муруй байгаагийн учир юу байж болох вэ?
- ♦ Морьтой хоёр хүн хаа хүрэхээр зорьж байгаа юм бол? г.м асуултыг өөртөө тавьж болно.

Ажигласнаа ямар үг, өгүүлбэрээр илэрхийлэх вэ?

Юуг ажиглах: Хоёр морьтой хүн цааш явж байна, эмэгтэй нь улаан алчууртай байна, зам дээр шалбааг ус тогтсон байна. Үүнийг ямар үг, өгүүлбэрээр илэрхийлэх вэ?



Нэг өгүүлбэрийг ажиглая. Зам дээр тогтсон шалбааг наранд хатаж амжаагүй байгаа нь саяхан, магадгүй, өчигдөр ч юм уу бороо оржээ.



Н.Цүлтэм “Зам” 1983 он



Зам

Монгол нутгийн жирийн нэгэн хөндий. Холын уулсын цаанаас урган улам л томорсоор наашлах цагаан үүлсийн зүг элдвийг хөөрөлдөх хоёр морьтой хүн зам даган улам цаашилсаар жижгэрэх бөгөөд бүсгүйн улаан алчуур тэнгэрийн цэнхэр өнгөн дээр бяцхан толбо мэт тодхон. Зургийн дороос хөдөөгийн зам ухасхийн гарч, тахиралдан мушгиралдсаар тэртээд сураг бараа тасарна.

Зам дээр тогтсон шалбааг наранд хатаж амжаагүй байгаа нь саяхан, магадгүй, өчигдөр ч юм уу бороо оржээ. Байгаль ертөнц жирийн боловч ер бусын үзэсгэлэнтэй агаад яльгүй нууцлаг. Алсыг зорьсон шонгийн мод замын дэргэдүүр шулуухан жирийлгэсээр зургийн гүн рүү шингэсэн үзэгдэнэ. Хөл дороос ээх зөөлөн шар зам бүхий хөдөө, нар, хур, агаар тэгш зуны дуниартсан тийм л нэг өдөр.

Зураач маань энэ л замаар давхиж явахдаа байгалийн тэрхүү сайхныг гайхан гэнэт зогтсаныг төсөөлөхөд амархан. Эргэн тойронд хөгжилтэй шулганах шувуудыг үргээхээс айсан мэт хөдөлгөөнгүй, тэртээд одох замын тухай гүн бодолд дарагдан зогсож байсан болов уу.

Алсад хөндөлсөх уулсын өтгөн хөх өнгөн дээр гараар баримгүй цагаан үүлс, хурц ногоон хөндийг зүссэн дулаахан шар зам, зам дээр тэнгэрийн бүдгэрсэн өнгөт шалбааг.

Энд байгаль дахь өнгө, дүрсийн үзэсгэлэнт зохицол нүд булааж, сэтгэл ганьхруулан хөдөөгийн зун хөх тэнгэр аялгуугаараа бүх л биеийг эзэмдэхийн ялдамд онгон байгаль, түүн дээр хүний гараар бий болсон шонгийн модны шулуухан цуваа хоёр эсрэг тэсрэг мэдрэмж төрүүлнэм.

Монголын нэгээхэн үеийг дүрсэлсэн энэхүү бүтээлээрээ алдарт зураачийн маань хэлэх гэсэн санаа нь чухам зам бөгөөд хөдөөгийн алс зэлүүд дэх айлд цахилгаан хүргэх, суурингаас сууринд, хотоос хөдөөд дэвшлийг хүргэж буй шонгийн мод, түүнийг бараадан тахиралдсаар одсон зам, хүний амьдралын зам, хотоос хөдөөд чиглэсэн хөгжлийн зам шулуун дардан биш болой.

Дээрх зурагт хэчнээн сайхан байгаль зурлаа ч илэрхийлж буй утга санаа нь чухам хүний амьдрал, түүний зам бөгөөд эцсийн эцэст хүний амьдралын зам хэцүү, хэзээ ч шулуун байдаггүйг хэлж амьдрал гэдэг нь хөгжил, хөдөлгөөн юм гэж хэлэх гэсэн л болов уу. (А.Ганбаатар)

- Уран зураг, тайлбар хоёртой чи санал нийлж байна уу?
- Чиний таамаглалын хариу эхэд байна уу?
- Чи зургаас хамгийн чухал зүйлийг ажиглаж чадсан байна уу?
- Таамаглаж тайлбарласантай санал зөрж байгаа хэсэг байна уу?
- Уран зургийн гол санааг аль догол мөрт, ямар өгүүлбэрээр илэрхийлсэн бэ?

Зөв бичье. Үндэсний бичгээр бичсэн үгсийг дараах үгтэй зөв харгалзуулаарай.

1.

2.

3.

а. жам

б. жим


в. зам



Гэрэл зураг ажиглан, таамаглаж бичье.

1948 он. Анх удаа зурагт (телевиз) харсан нь: Түүхэн гэрэл зургийг ажиглаарай. Зургийг төсөөлөн бодож, таамаглал дэвшүүлэн, асуултад хариулж бичнэ үү.

- ◆ Хүү, хэд орчим настай болохыг таамаглаарай.
- ◆ Хүүгийн хувцас, үс засалт, гадаад байдлаас үзвэл ямар таамаг дэвшүүлж болох вэ?
- ◆ Биеийн хөдөлгөөн, зогсож байгаа байдлаас зан араншинг тодорхойлж болох уу?
- ◆ Түүхэн он цагийн хувьд ямар үе байж магадгүй вэ?
- ◆ Хүүгийн харц юуг илэрхийлж байна вэ?
- ◆ Хүү юу бодож байгаа бол?
- ◆ Зургийн орчныг ажиглана уу. Ямар газар юм шиг байна?
- ◆ Ямар үндэстэн байж магадгүй вэ?
- ◆ Зургаас үүдэж чамд ямар бодол төрж байна. Сэтгэгдлээ илэрхийлнэ үү.



Үлгэрлэвэл: Хүүгийн зогсож буй газрын эргэн тойронд чийдэнгийн гэрэл гялбаж байхыг үзэхэд хэдийгээр энэ нь 1948 оны зураг боловч, амьдралын нөхцөл тийм ч тааруу биш болохыг илэрхийлж байгаа мэт. Байгаа газар нь нэгэн томоохон үйлчилгээний газар бололтой. гэх мэт



Ашиглаж болох таамаглах баймж үг:

- ◆ байж болох юм
- ◆ миний харж байгаагаар
- ◆ ... мэт, шиг
- ◆ байж магадгүй
- ◆ ... бололтой
- ◆ магадгүй бололтой г.м.

Тайлбарласан эхээс таамаглал дэвшүүлсэн ба нотолж баталсан хэсгийг ажиглан, ялгаж уншъя.

Ажиглалтаас төрсөн асуулт, асуултаас төрсөн таамаглал, таамаглалаас гарсан нотолгоог нэгэн эхэд яаж илэрхийлэх вэ? Эх хэлнийхээ сонин хачныг үндэслэлтэйгээр таамаглан тайлбарласныг ойлгож уншаарай.

- а. Доорх эхэд зохиогч ямар таамаг дэвшүүлэн, хэрхэн яаж баталсныг ойлгохын тулд дараах загварын дагуу задлаарай.

Ажиглалт	Эхийн хэддүгээр догол мөрт, ямар үг, өгүүлбэр?
Асуулт	Эхийн хэддүгээр догол мөрт, ямар үг, өгүүлбэр?
Таамаглал	Эхийн хэддүгээр догол мөрт, ямар үг, өгүүлбэр?
Санал	Эхийн хэддүгээр догол мөрт, ямар үг, өгүүлбэр?
Нотолгоо	Эхийн хэддүгээр догол мөрт, ямар үг, өгүүлбэр?
Дүгнэлт	Эхийн хэддүгээр догол мөрт, ямар үг, өгүүлбэр?
Баймж утга	Доогуур зурсан үг, өгүүлбэрийн утга?



“Сэгс цагаан богд” уу?, аль эсвэл “Сэгсэг цагаан богд” уу?

(Нэгэн газар усны нэрийн тухай)

[...] Энэ судалбар өгүүлэлдээ бид “Сэгс цагаан богд” уу? аль эсвэл “Сэгсэг цагаан богд” уу? гэсэн ац* асуултаар уулынхаа нэрийг сонирхож үзвэл, та бидний хэл соёлын боловсролд ач холбогдолтой юм гэж үзэв.

Монголын газар усны нэрийн сан, нэр томъёог судалсан, газар зүйн зураг зохиосон эрдэмтэн судлаачид бараг л цөм “Сэгс цагаан богд” уул гэж бичжээ. Бас уран зохиолын болон сэтгүүл зүй – нийтлэлийн олон бүтээлд “Сэгс цагаан богд” гэдгээр л бичсээр ирж. Тухайлбал: Зохиолч Д.Пүрэвдорж, Ш.Сүрэнжав, С.Удвал, С.Дашдэндэв, Т.Галсан, Д.Нямаа, С.Долд, Т.Очирхүү тэргүүтнээс өгсүүлээд,

* ац - хоёр талтай, эргэлзээтэй



Дандар баатрын дуртгалыг хүртэл сонирхоод үзэхүл, бүгд “сэгс ...” – ээр бичжээ. Жишээлбэл, “Атас цагаан богд” “Сэгс цагаан богд” – д ангуучилж явсан хүү, бараа хараа алдсан гэдэг юм хэмээн барин тавин ярьсан байжээ. (С.Эрдэнэ “Буцааж авах эрх” зохиолоос) г.м.

Гэтэл харин, Монгол улсын анхны ардын уран зохиолч, эрдэмтэн Ц.Дамдинсүрэн гуай л ганцаараа “Сэгсэг цагаан богд” гэж бичсэн нь бий. Эрдэмтэн – зохиолч, их бичгийн хүн – Дамдинсүрэн алдаж хэлмээргүй еэ. Энэ их эрдэмтний нэг гол онцлог бол мэдэж судалж байж бичдэг, мэдэхгүй зүйлийнхээ талаар ам нээдэггүй, барим тавим баримт мэдээлэлд шүтэж бичдэгт нь байдгийг олон зүйл баримт судалгаагаар нотолж болно доо. Ц.Дамдинсүрэн 1981 онд бичсэн “Мазаалайг эрсэн нь” гэдэг баримтат уран сайхны зохиолдоо: [...] Балсан тэргүүтэй шинжилгээний хүмүүс тоорой модны сүүдэрт, газрын том зураг дэлгээд, явах замаа төлөвлөн хэлэлцэж байлаа. Сая газарчнаар авсан, Норжай гэдэг ширвээ хар сахалтай, залирхаг эр чанга дуугаар, их мэдэмхий зааварлаж байна: - Мазаалайг үзье гэвэл, Сэгсэг цагаан богдод авирах хэрэгтэй. Загийн шандад харуулдан суух хэрэгтэй. Би замыг сайн мэднэ. Дугаржав бид хоёр хэдэн жил Сэгсэг цагаан богдод мал оторлож явахдаа, Загийн шандад мазаалайг олж үзсэн... Хоёр машиндаа долоон хүн суугаад, Сэгсэг цагаан богдыг чиглэн хөдлөв... Цааш нэлээд явтал говийн чимэг болсон Сэгсэг цагаан богд уул, мөнгөн дээвэртэй, хар хадан хэрэм шиг сүрлэг сайхан харагдана... Сэгсэг цагаан богдын мөнгөн оргил сэтгэлийг баясган сэрүү татна. [...] (Ц.Дамдинсүрэн “Бүрэн зохиол – 1” 1998) гэж бичсэн байдаг билээ.

Ц.Дамдинсүрэнгийн зохиолд ийнхүү “Сэгсэг цагаан богд” гэсэн бичлэг, хэлбэр анх гарчээ. Гэхдээ уншигчдад “сэгс”, “сэгсэг” гэдэг үгийн утга сайн ойлгогдохгүй байсаар өдгөөг хүрсэн юм шиг санагдана. Иймд “сэгсэг буюу сэгсгий” – г өөр ном зохиол, толь бичиг тэргүүтнээс нягталж үзэх шаардлага гарав. Монгол хэлний “сэгсэг” гэдэг үгийн гарвал, утга, түүний зөөж тээж ирсэн мэдээллийг сонирхож үзэв. “Монгол хэлний сувд эрх нэрт ховор үгийн толь” (Б.Амаржаргал, Л.Балдан, бусад, Уб., 1992 он) гэсэн нэг товч толь байдаг. Энэ толь “сэгсгий” (Утга нь: Хүүхдийн даахь; монгол бичгээр; “segsegei”) гэдэг үгийг тэмдэглэсэн ба “сэгс” (Утга нь: Өвсөөр хийсэн сав; монгол бичгээр; “segsu”) гэдэг үгээс ялгаж өгсөн байна аа. Ингээд бодохлоор, Ц.Дамдинсүрэн гуайн “Сэгсэг цагаан богд уул” гэсэн хувилбар нь уг гарвал утгаараа зөв хувилбар байж болох нь илүү магадлалтай болж байна. Учир нь, “сэгсгий” нь ярианы болон бичгийн хэлэнд үе – утгалбар хураагдаад, “сэгсэг” болсон, бүр улмаар “сэгс...” болсон байхыг үгүйсгэх аргагүй бөгөөд ийм зүй тогтол байгаа учир академич Ц.Дамдинсүрэнгийнхээр “сэгсэг...”, эсвэл “сэгсгий цагаан богд” гэж ярьж, бичиж, ойлгож хэрэглэвэл илүү утга төгөлдөр байж болох юм...

Өвлийн тасхийм цагт цасан мөсөөр молцоглоод, цагийн өнгийг илтгэж, цан хүүрэг цавцайсан тийм сайхан оргилтой, ийм сайхан ариун дагшин уулын сэрүү татсан мөнгөн дээвэр – зулайн дүр зургийг хүүхдийн даахины “сэвлэг – сэгсэг” буюу “сэгсгий” – тэй зүйрлэн нэрлэснээс утга шилжин үүссэн байж болох магадлалтай байна. Говийн тэр сайхан зулай цагаан уулын оргил тэргүүнд хангайн шинж бүрдэж, зун, намар, өвөл, хавар ээлжилдэг байж л дээ. Гэвч одоо байгаль, цаг агаарын хувирлаас болж, байдал төрх нь их л өөрчлөгджээ. Энэ бяцхан судалбарын эцэст эргэцүүлбээс, баян монголын өмнөд хэсгээр Баянхонгор нутаг усны маань урд захыг эмжин үргэлжлэх “Сэгсэг цагаан богд” гэсэн ертөнцийн нэгэн зураг байна аа.

(Б.Пүрэв – Очир)






б. Дараах гурван асуултад хариулж бичээд, дүгнэж ярилцана уу.

Зохиогч эхэд юуг таамагласан бэ?

Зохиогч эхэд юуг үгүйсгэсэн бэ?

Зохиогч эхэд юуг баталсан бэ?



- в. Доогуур зурж онцолсон үгс ямар утга илэрхийлж байна вэ?
- г. Маргаан зохиогоорой. Энэ эх нь бүхэлдээ “Таамагласан эх үү? Аль эсвэл баталсан эх үү?” Энэ хоёр асуудал дээр хоёр хэсэг болж хуваагдаад өөр өөрсдийн байр сууриа илэрхийлэхдээ эхийн доторх жишээ баримтуудаар нотолж ярина. (Үзэл бодлоо илэрхийлэхдээ жишээ баримт, нотолгоотой ярина. Яриаг үнэлэх шалгуур нь: Үзэл бодлоо илэрхийлэхдээ эхээс эшлэл, жишээ татан баталж ярьж буй эсэх)



Эхийг харьцуулъя.

Б.Пүрэв – Очирын “Сэгс цагаан богд” уу?, аль эсвэл “Сэгсэг цагаан богд” уу? гэсэн судалбар эсээ, Д.Нямаагийн “Сэгс цагаан богд” дурсамж эсээ хоёрыг харьцуулан уншаад, даалгаврыг гүйцэтгээрэй.

Сэгс цагаан богд

Анх дуулахад “Сэгс цагаан богд явах болов” гэсэн үг “Тэнгэрт гарах болов” гэсэн шиг дуулдаж билээ. Яах аргагүй, Сэгс цагаан богд хүрнэ гэдэг тэнгэрт хүрэхээс хол газар ажээ. Явсан хүн тэнгэрийн нэг сэжүүрт хүрч гэмээж нь энэ үлгэрийн сайхан уулыг тулж үзэх болно. Ямар ч уулыг голоос харах сайхан байдаг. Сэгс цагаан богд уул ч мөн тийм байлаа. Газрын хязгаараас түүний бараа нь харагдана. Газар тэнгэрийн хярхагт тунарсан цэнхэр униарын дунд танигдахтай үгүйтэй харагдах холын уул хэзээнээсээ нааш надад ямар нэг үлгэр домгийн орон шиг санагдах болсон юм. Таван настайдаа би Сүмийн гүний наадам гэгчийг үзжээ. Түүнээс миний санаанд юу ч үлдээгүй хэрнээ Сүм суваргын цэнхэр уул одоо хүртэл надад тов тодхон харагддаг юм. Ууланд би багын дуртай ажээ. Хүн нутгаа санахын адил бага насаа бас санадаг юм билээ. Тэгж, бага насаа санах өдөр талын тэр ганц цэнхэр уулыг би ахин дахин олж үздэг юм.

Нутгаа санана гэдэг ер нь, уулаа санана гэсэн үг биш байгаа даа.

Яагаад ч юм, би талын хүн хэрнээ уул санаж явдаг. Сэгс цагаан богдыг хэдэн нүүдлийн газраас хараад, би бага насаа дурсаж явлаа.

Тэр сайхан уулыг чиг баримжаа аван дөтөлж явахад бага нас руугаа ойртож явах шиг санагдсан. Эрүүл салхинд сэтгэл сэргээх юм бодож явахад газар амархан дөхдөг юм билээ. Нэг мэдэхнээ, бид газрын тэртээ хязгаараас бараа турууг нь харсан Сэгс цагаан богд уулынхаа хаяа хормойд ирсэн байв.

Намрын шөнийн тэргэл том саран Сэгс цагаан богдын сэрвээ дөрөөлж, аниргүй дүнхийх их уулын сүүдэр ар шилээ даран унажээ. Хэзээ ч бараа хараагүй говийн энэ буянтай сайхан уулын хормой дээр толгой тавьж нойрссон тэр шөнө сэрүүхэн байлаа. Уул амгалан нойрссон бололтой... Нэг сэрэхэд үүр цайжээ. Үүрийн шар



гэгээний наахнуур тэргүүн өргөн сүүхийлцэх догшин байцсын нэгэн дээр уулын янгир эврээ сэрийлгэн гарч ирэв. Тэр амьтан энэ сайхан хангайн эзэн нь гэсэн шиг бардамхан зогсоно. Омгорхож болох сайхан юм бүгд түүнд заяасан шиг байлаа. Хэрэв, уулын янгирын хөлөөр сул чулуу өнхөрч бодлыг минь гэнэт үргээгээгүй бол миний ярих юм дуусахгүй ч байж болох байсан. Яагаад гэвэл, энэ ууланд гайхах юм их ажээ. Намайг Сэгс цагаан богд явах болов гэхэд нэг нөхөр минь “Зүйтэй, уул үзэх хэрэгтэй” гэсэн билээ. Үнэхээр би уул үзэв. Үзэх үзэхдээ, хэзээ ч мартаж боломгүй үлгэрийн сайхан уул үзэв. Миний үзсэн тэр уулын хормойд тэнгэр дуусдаг юм билээ.

Би хөх тэнгэрийн нэг сэжүүрийг бас үзэв. Их уулыг холоос харах сайхан байдаг сан. Гэтэл хэзээ хойно холоос бодох ч бас сайхан юм.

(Д.Нямаа)

- а. Дараах хоёр эгнээ өгүүлбэрээс таамагласан баймж утгат үг, бүтээврийг ялгаж бичээд, утгыг тайлбарла. Хоёр хэсэг юугаараа ойролцоо байна вэ? Юугаараа өөр байна вэ?

<p>Хүүхдийн даахины “сэвлэг - сэгсэг” буюу “сэгсгий”-тэй зүйрлэн нэрлэснээс утга шилжин үүссэн байж болох магадлалтай байна.</p>	<p>Газрын хязгаараас түүний бараа нь харагдана. Газар тэнгэрийн хяргагт тунарсан цэнхэр униарын дунд танигдахтай үгүйтэй харагдах холын уул хэзээнээсээ нааш надад ямар нэг үлгэр домгийн орон шиг санагдах болсон юм.</p>
<p>Ингээд бодохлоор, Ц.Дамдинсүрэн гуайн “Сэгсэг цагаан богд уул” гэсэн хувилбар нь уг гарвал утгаараа зөв хувилбар байж болох нь илүү магадлалтай болж байна.</p>	<p>Нутгаа санана гэдэг ер нь, уулаа санана гэсэн үг биш байгаа даа.</p>
<p>.... Учир нь, “сэгсгий” нь ярианы болон бичгийн хэлэнд үе - утгалбар хураагдаад, “сэгсэг” болсон, бүр улмаар “сэгс...” болсон байхыг үгүйсгэх аргагүй бөгөөд ийм зүй тогтол байгаа учир академич Ц.Дамдинсүрэнгийнхээр “сэгсэг...”, эсвэл “сэгсгий цагаан богд” гэж ярьж, бичиж, ойлгож хэрэглэвэл илүү утга төгөлдөр байж болох юм.</p>	<p>Хэзээ ч бараа хараагүй говийн энэ буянтай сайхан уулын хормой дээр толгой тавьж нойрссон тэр шөнө сэрүүхэн байлаа. Уул амгалан нойрссон бололтой...</p>
<p>Энэ бяцхан судалбарын эцэст эргэцүүлбээс, баян монголын өмнөд хэсгээр Баянхонгор нутаг усны маань урд захыг эмжин үргэлжлэх “Сэгсэг цагаан богд” гэсэн ертөнцийн нэгэн зураг байна аа.</p>	<p>Үүрийн шар гэгээний наахнуур тэргүүн өргөн сүүхийлцэх догшин байцсын нэгэн дээр уулын янгир эврээ сэрийлгэн гарч ирэв. Тэр амьтан энэ сайхан хангайн эзэн нь гэсэн шиг бардамхан зогсоно. Омгорхож болох сайхан юм бүгд түүнд заяасан шиг байлаа.</p>

- б. Аль эгнээнд байгаа нь баримт нотолгоонд суурилсан, аль эгнээнд байгаа нь баримт бус өгүүлэгчийн сэтгэгдэлд суурилсан байна вэ? Жишээгээр батал.
- в. Баримтад тулгуурлан таамаглаж бичнэ гэж юу вэ? Аль нь үнэнд илүү ойр байж болох вэ? гэдгийг өөрийн үгээр бичнэ үү.





Шинжлэх ухааны хөгжлийн түвшинд үнэн эсэх нь тодорхойгүй байгаа бол түүнийг урьдчилсан санал буюу таамаглал гэнэ. Таамаглал нь хуучин ба шинэ мэдлэгийг холбож байдаг.



Ажиглалтаас үүдсэн таамаглалыг утгын уялдаатай илэрхийлье.

- а. Шүлгийн утга санааг зургаар илэрхийлбэл, доорх зургийн алиныг сонгомоор байна вэ?

Сэмхэн цагаан үүл

Их үдийн халуунд аахилан тэнгэрт зогсох
Ишгэн цагаан үүл хур дуудан майлна.
Ихэр хөх нуурын минь толионд
Ийш тийшээ хөвж, хөлхөж тоглоно.
Туулайчлан ирэх салхинд хөгжсөн ишгэн үүл
Тургилан дэгдэж, сүүлээ гондонуулан уул давна.
Сэмхэн цагаан бас нэгэн үүл нуураас гарч
Сүүдэр болон уул илж, хойноос нь дагана.
Хар, цагаан хоёр ишгэн үүл
Газар, тэнгэр хоёроор зэрэг тэнэнэ.

(Б.Лхагвасүрэн)



- б. Доорх өгүүлбэрүүдийг хүснэгтэд учир зүйн зөв дараалалд оруулж байрлуулаарай. Үүний тулд шүлгийн мөрийн дарааллыг харгалзаарай. Шүлгийг таамаглан тайлбарласан санаа дээрх хоёр зургийн алинтай тохирч байна вэ? Чиний санал нийлж байна уу?

Ажиглалт	Асуулт	Таамаглал Санал	Баримт, нотолгоо	Дүгнэлт
?	?	?	?	?
.....



- ◆ Хэрэв ийн үзээд лавшруулбал, ишиг нь нулимс биш биз? гэсэн бас нэг таамаглал гарч болох юм.
- ◆ Уг шүлгийн өгүүлэмжийг өнгөцхөн харвал, хаа нэгтээ байх, ихэр гэх ч юм уу, холбоо гэх ч юм уу нуурын дээгүүр хөнгөн сэвшээнд янз янзын хэлбэр дүрсээр хувиран хувилан, нүүж өнгөрөх үүлийг сүүдэртэй нь хамт илэрхийлсэн хавтгай зураг шиг зүйл санаанд амархан буух биз ээ.
- ◆ “Ихэр хөх нуур” гэдэг нь хаа нэгтээх холбоо нуурыг нэрлэж болох ч харин энд хүний нүдийг хэлж байгаа юм биш биз гэсэн нэг сэрэгдэл үүсэх боломжтой.
- ◆ “Их үдийн халуунд аахилан тэнгэрт зогсогч” нь баяр бахдал, уйтгар харууслын бодолд автсан нэгэн хэмээн гүтгэн ойлгож болно.
- ◆ Чингээд “газар, тэнгэр хоёроор зэрэг тэнэж байгаа хар, цагаан хоёр ишгэн үүл” бол “Их үдийн халуунд аахилан тэнгэрт зогсогч”-ийн туулсан амьдралынх нь сайн муу, сайхан муухай, баяр гуниг, жаргал зовлонгийн хувилгаан үр нь, дүр нь юм байна хэмээн “мушгин” хэтийдүүлж болох юм....
- ◆ Иймд зүйр цэцэн үг зэрэг зүйрлэсэн хэллэгээр илэрхийлэх утгыг тайлах аргыг шүлэг найрагт хэрэглэх бүрэн боломжтой гэж үзнэ.
- ◆ Монгол хэлэнд “хурган үүл” хэмээсэн адилтгал түгээмэл байдаг нь хурганы үсний аржгар буржгар байдалтай төслүү шинжээр нь ийн нэрийдсэн бололтой.
- ◆ Тэгвэл “Сэмхэн цагаан үүл” ямар онцлогтой юм бол?
- ◆ Энэ шүлэгт “ишгэн үүл” гэсэн нь үүлний хэлбэр дүрс маш амархан хувиран өөрчлөгдөхийг ишигний харайж дүүлэх, үсэрч цовхчих адтай хөдөлгөөнтэй нь зүйрлэн нэрлэжээ.
- ◆ “ишиг сүүлээ годгонуулан давж байгаа уул” нь хацрын хос товгорыг хэлж байгаа юм биш үү... (Ж.Баянсан)



Ойлголтоо нэгтгэе.

Гол санааг тодорхойлж ярилцаад, цэгийн оронд нөхөж, дүгнэлт гаргаарай.

Аливаа үл мэдэх юмаа хүн таамагладаг. Онъсогыг таана. Ирээдүйг таамаглана. Үл таних үзэгдлийг таамаглана. Үл таних хүнийг ч таамаглана. Таамаглалыг шалгаж үнэн зөв эсэхийг тогтоож болно. Тэгж тогтоох аргагүй бол таамаглал таамаг болж үлдэнэ. Таамаглал үнэн болно. Гэвч бас худлаа болно. Таамаглал үнэн худал хоёрын хооронд дүүжигнэж болно. Таамаглал бол шинжлэх ухааны оргилд авирах өндөр шатны анхных нь гишгүүр юм. (Л.Түдэв)

“Шинжлэх ухааны оргилд хүрэх анхны гишгүүр бол таамаглал юм” гэдгийн утга нь миний бодлоор байж магадгүй.



Таамаглаж тайлбарлах гэдэг нь ямар нэг асуудлын талаар тодорхой шинжилгээ, судалгааны үндсэн дээр учир зүйтэй таамаглал гаргахыг хэлнэ. Таамаглал нь ихэвчлэн үнэн юм уу, худал гэсэн хоёр хариун дээр тогтдог. Тиймээс, таамаглаж тайлбарлах нь ямар нэг судалгаа, эрэл хайгуулыг шаарддаг. Тэгэхлээр, баримтад тулгуурлан таамагладаг гэсэн үг. Бидний эргэн тойронд асар олон үйл явдал, сонирхолтой зүйлс оршиж байдаг. Тэдгээрийг ажигласнаасаа үүдэн ямар нэг юмыг шинжих, сонжих, эсвэл харьцуулах, жиших замаар мэдлэгээ цааш баяжуулан хөгжүүлж, бодож сэтгэж, шинэ санаа, шинэ бүтээл, онол дэвшүүлдэг байна.



10

Үндэслэл нотолгоог олъё.

Чиний бодлоор, аль хэсэгт таамаглалынхаа үндэслэл нотолгоог тодорхой бичсэн байна вэ? Нотолгоо гэж үзэж байгаа өгүүлбэрийг олж, тодруулна уу.

Одоогоос 2000-аад жилийн өмнө Монгол нутагт төвлөн амьдарч байсан Хүннү нарын үлдээсэн археологийн дурсгалыг ажиглавал, тэд булш бунхнаа язгууртны, жирийн иргэдийн хэмээн ангилдаг байсан байж болох юм. Урд талдаа үүдэвчтэй, гонзгой дөрвөлжин хэлбэрийн чулуун далан нь холоос байшингийн туурь мэт сүртэй харагдах нь язгууртны бунхан бололтой. Харин цагариг хэлбэр гаргаж чулуугаар тойруулсан нь жирийн хүмүүсийнх байх магадлалтай юм.

Гахайн гуя

Археологичид, По голын хөндий дэх Форцелло хотын туурийг ухаж судлаад, ан амьтны яс 50000 -ыг олжээ. Гэтэл тэдгээрийн доторх гахайн яснуудаас гуяны яс ховор байсан гэнэ. Тэгэхлээр Этрүүс* овгийнхон гахайн гуяыг хуйхлан утаад, хөрш кельтүүдэд* наймаалдаг байсан байж магадгүй.

11

Таамаглал дэвшүүлсэн аргыг ажиглая.

Бичил эхийг уншаад, доорх хүснэгтийн тайлбар гэсэн хэсэгт өгүүлбэрийг баримтаас үүдэн таамагласан уу?, эсвэл өгүүлэгч өөрийн санаагаар таамагласан уу? гэдгийг ялгаж тэмдэглээрэй.

“Тоорой модонд тогоруу эргэнэ.

Тоосны үзүүрээс хүү минь ирнэ” гэдэг дуу бол говийнхны гаргасан дуу байж таарна. Учир нь тоорой мод бол зөвхөн Алтайн цаадах говьд ургадаг, жинхэнэ говийн ургамал. Харин, тогоруу шувуу бол говьд байдаггүй, хээр талын амьтан болно. Гэвч халуун орноос сэрүүн орныг зорин нисэж ирэх замдаа тоорой модтой булаг шандын дээгүүр ганганан эргэж, түр зуур бууж амсхийдэг нь зайлшгүй. Тоорой мод ургасан газар заавал ус байна....

(Д.Цэвэгмид “Эргэн дурсахад”)

№	Өгөгдөл	Тайлбар
1	“Тоорой модонд тогоруу эргэнэ. Тоосны үзүүрээс хүү минь ирнэ” гэдэг дуу бол говийнхны гаргасан дуу байж таарна.	
2	Учир нь тоорой мод бол зөвхөн Алтайн цаадах говьд ургадаг, жинхэнэ говийн ургамал.	
3	Харин, тогоруу шувуу бол говьд байдаггүй, хээр талын амьтан болно.	
4	Гэвч халуун орноос сэрүүн орныг зорин нисэж ирэх замдаа тоорой модтой булаг шандын дээгүүр ганганан эргэж, түр зуур бууж амсхийдэг нь зайлшгүй.	
5	Тоорой мод ургасан газар заавал ус байна...	

* Этрүүс - МЭӨ VI зуунд хотжилт, соёл иргэншлийнхээ хөгжлийн оргилд хүрч хойд зүгт По голын хөндий хүртэл тэлж, Ромын эрхийг барьж байсан хүчирхэг ард түмний нэр

* Кельт - МЭӨ II - I зууны үед Европын нутгаар суурьшиж байсан энэтхэг – европ гаралтай эртний аймгийн нэр



Таамаглал дэвшүүлэн, баталж нотолж, үгүйсгэж бичих аргад суралцъя.

- ◆ Таамаглах, батлах, үгүйсгэх өгүүлбэр бичих
- ◆ Таамаглах баймж үг, бүтээврийг хэрэглэх
- ◆ Таамаглал дэвшүүлэн бичих



Хэл зүй, үгийн сан

12

Таамаглах баймж үг, бүтээврийг оновчтой хэрэглэе.

Дараах гурван хэсгийн утга санааны адил ба ялгаатай талыг венийн диаграммын загвараар илэрхийлнэ үү.

А

... Ингэхэд алтан хараацай яах гэж нислэгээрээ ертөнцийн тигийг тэнгэрт зурдаг байна аа. Өөр дүрс зураглан нисэж болох шүү дээ. Заавал тойрог татах мэт нисдэгийн учир юун.

Ертөнцтэй зохицон амьдарч байгаагийн илэрхийлэл юм болов уу. Бүх амьтдын явдал зам мөр тойрог байдаг юм биш байгаа.
(Д.Батбаяр)

Б

... Ингэхэд алтан хараацай яах гэж нислэгээрээ ертөнцийн тигийг тэнгэрт зурдаг байна аа. Өөр дүрс зураглан нисэж болох шүү дээ. Заавал тойрог татах мэт нисдэгийн учир юун.


Энэ бол ертөнцтэй зохицон амьдарч байгаагийн илэрхийлэл юм. Ерөөс, бүх амьтдын явдал зам мөр тойрог байдаг.

В

... Ингэхэд алтан хараацай яах гэж нислэгээрээ ертөнцийн тигийг тэнгэрт зурдаг байна аа. Өөр дүрс зураглан нисэж болох шүү дээ. Заавал тойрог татах мэт нисдэгийн учир юун.

Ертөнцтэй зохицон амьдарч байгаагийн илэрхийлэл байх. Үгүй ч байж магадгүй. Учир нь шувуу болгон ингэж тойрог татан нисдэггүй шүү дээ.

Адил ба ялгаатай тал



Таамаглах өгүүлбэр

Батлах өгүүлбэр

Үгүйсгэх өгүүлбэр

а. Өгүүлбэрүүдийг уншаарай, батлах ба үгүйсгэх утгаар нь ялгаарай. Баталж, үгүйсгэхэд хамгийн гол үүрэгтэй бүтээвэр аль нь вэ? Нэрлэнэ үү.

Зараа алим нөөцөлдөг.

Зараанд алим ямар ч хэрэггүй.

Зараа шавж хоолтон юм.

Зараа ургамлаар хооллодоггүй.


Зараа жимсээр хооллоно.

Зараа хоол тэжээл нөөцлөх хэрэггүй.

Зараа ичдэг амьтан.

б. Өгүүлбэрүүдийг таамаглах утгатай болгож хувиргана уу. 44 дүгээр хуудсанд байгаа баймж үгсээс тохирохыг ашиглаарай.

в. Эхийг дараах бүтэц дарааллын дагуу хувиргаж бичээрэй.



Зарааны араншин

Эртний Ромын байгаль судлаач Ахмад Плиний “Зараа алимьг өргөсөөрөө хатгаж, үүрэндээ зөөн аваачиж, өвлийн нөөцөө бэлтгэдэг” гэж бичжээ. Гэтэл зарааг сайн мэддэг амьтан судлаачид “Зараанд алим ямар ч хэрэггүй, шавж хоолтон учир ургамлаар хооллодоггүй, ичдэг тул өвөл ямар ч хүнс нөөцлөх шаардлага байдаггүй” гэж үздэг аж. Олон жилийн өмнө Британийн амьтан судлалын нэгэн сэтгүүлд



“Зараа заримдаа алим болон бусад жимсээр хооллохоос буцдаггүй” гэдгийг баталсан өгүүлэл нийтлэгдэж байжээ. Ялангуяа, залуу зараанууд янз бүрийн төрлийн хүчиллэг, эхүүн бодис, бүтээгдэхүүнд дуртай байдаг бөгөөд дутуу татсан тамхийг үсэндээ хатгах, бас кофены үр авахыг оролддог байна.

Иймд зараа хэдийгээр шавж идэштэн ч гэсэн хааяа ургамлаар хооллодог байж магадгүй.




14

Онъсогын хариуг таамаглаж бичье.

Онъсого нь:

*Усан тархитай юм.
Төмөр толгойтой юм.
Модон цээжтэй юм.
Ширмэн бөгстэй юм.
Гал сандалтай юм.*

Бичих үйлийн алхам нь:



а. Дээрх онъсогыг тонгоргон найруулж бичихэд утга санаа нь өөрчлөгдсөн үү? Товч тайлбар бичье. Тэгээд “Б” хэсэгт бичсэн онъсогыг тонгоргон хувиргаж бичээрэй.

А.

Усан тархитай юм.
Төмөр толгойтой юм.
Модон цээжтэй юм.
Ширмэн бөгстэй юм.
Гал сандалтай юм.



Тархи нь усан юм.
Толгой нь төмөр юм.
Цээж нь модон юм.
Бөгс нь ширэм юм.
Сандал нь гал юм.

Б.

Гарах нь газраас
Гайтах нь тэнгэрээс
Өтлөх нь бутанд
Үхэх нь жалганд
(Хамхуул)

15

Дараах оньсогыг батлах юм уу, үгүйсгэх өгүүлбэрээр дэлгэрүүлээд, шалтгааныг тайлбарлаж бичье.

Асуулт – Таамаглал	Батлах уу? Үгүйсгэх үү?	Шалтгаан нь
“Эрээн гэтэл бар биш Эвэртэй гэтэл буга биш Номтой гэтэл лам биш Лонхтой гэтэл архи биш” хэмээн зөгийг хэлсэн бололтой.	Батлах өгүүлбэр	Учир нь
“Зонховын зургаан зусаг ямаа Өвлийн шуурганд үхээгүй байж Зуны бороонд зуурч үхэв” гэсэн нь зусаг ямааг хэлсэн байж магадгүй.	Үгүйсгэх өгүүлбэр	Учир нь ...
“Бурхан хааны Буурал азарга янцгаахад Дархан хааны Далан байдас шээс алдана” гэхэд миний бодлоор, тэнгэр дуугарч, бороо орохыг дүрсэлсэн байна.	Батлах өгүүлбэр	Учир нь
“Довон дээрх Долоон өнгийн торгыг Чи ч авч чадахгүй Би ч авч чадахгүй” гэж долоон өнгийн цэцгийг хэлсэн байж магадгүй.	Үгүйсгэх өгүүлбэр	Учир нь
“Ухаагүй худгийн уудаггүй уснаас Ховоогоор биш саваагаар хутгаж Номчийн хүү тамчийн талд Тансаг эрдэнийн тариа цацна” гэж үзгээр бичихийг хэлсэн байх.	Батлах өгүүлбэр	Учир нь

16

Таамаглах баймж утгатай үгийг хэрхэн яаж ялгаатай хэрэглэх вэ?

а. Дараах эхээс таамагласан утгат үгийг ялгаж бичээрэй.

А. Дуунаас болов уу? (Эрдэмтэн зохиолч Л.Түдэвийн “Хувьсгал танаа өчье” романы гол дүр, нэрт дуучин Магсар хурцын Дугаржав хэлмэгдэн, шоронд хоригдсон шалтгаанаа олон янзаар таамаглан бодсон хэсгээс)

... Миний хийсэн юман дотор дуу л голдууг хэн эс андах билээ. Хувьсгалын өмнөхөөс эхлээд хорь гаруй жилд бараг л зуу гаруй дуунд ая хийж, нэлээдийг үг, аятай нь зохиосон байх. Ая дангаас нь ч яриа гарахгүй биз. Харин үгнээс нь өө



сэв олдох л байлгүй. Төмөр лимбээ барьж, Цэвээн гуайнд очдог тэр өдөр л хамаг юм эхэлсэн. Харин миний бичүүлсэн нь хорин гурван оноос эхэлсэн болохоор тэр үеийн янз бүрийн дуу орсон байж мэднэ. Тийм дууны утга нь одоо цагт их л хуучирч, шинэ үеийн бодлогод таарахааргүй болсон ч байж мэдэх юм.

Өөрийн зохиосон дуунуудын тухайд бол хамгаалах хэлэх үг олдох байлгүй. Дуу намайг аварч байсан удаа олон бий. Алдаршуулж байсан цаг ч нэг биш. Тэгэхлээр дууны буянаар өдий зэрэгтэй яваагаа чамлах юун билээ. Дууны тухай сэжигтэй юм бодвол надад ёстой нүгэл болно. Хүн ер нь дордоод ирэхээрээ хамгийн ариун нандин болгоноо ч хардаж сэрдэж мэдэх нь ээ!

Б. Монгол бичиг хэдийд үүссэн бэ?

Зарим эрдэмтэн монгол бичгийн хэлийг дөнгөж XIII зууны эхээр анх үүсэн бүрэлдсэн байж магадгүй хэмээн үздэг. Энэ нь Чингис хаан Наймантай байлдаж байх үед Найманы Тататунгаа гэгч хүнээс нэгэн бичигтэй тамга олж, түүгээр бичиг үсэг заалгасан тухай домгоос үүдэлтэй. Чингис хаан Наймантай байлдсан тэр түүхэн үйл явдал нь 1204 онд болсон гэдэг. Энэхүү домгийн мэдээ нь монголчууд анх бичиг үсэгтэй болсныг хэлсэн хэрэг биш бололтой. Харин, тэр үеийн олон монгол аймгийн хэрэглэж байсан өөр өөр бичиг үсгийн дотроос уйгур бичгийг сонгон авч, нийт монгол аймгууд хэрэглэх болсон түүхэн үйл явдлыг өгүүлсэн байж болох юм. Ингэхлээр, монгол бичгийн хэл анх үүсэн бүрэлдсэн цаг үе бол үүнээс бүр өмнө IX-X зуун хэмээн үзэж болно.

б. Хүснэгтэд бичсэн шинжийг ашиглан, доорх өгүүлбэрийн цэгийн оронд нөхөж, дүгнэлт гаргана уу. Эхийн шинжүүд нь:

	А эх	Б эх
Зохиогчийн зорилго нь	Өгүүлэгч хувийн үзэл бодлоо илэрхийлэх	Танин мэдүүлэх
Эхийн төрөл нь	Уран зохиолын найруулга	Шинжлэх ухааны найруулга
Хэддүгээр биеэс өгүүлсэн	Нэгдүгээр биеэс	Гуравдугаар биеэс

А хэсгийг өгүүлэгчийн зорилго нь учраас төрлийн эх байна. Энэ эхийг дүгээр биеэс өгүүлсэн найруулгад хамаарах эх байна. Б хэсгийг өгүүлэгчийн зорилго нь учраас төрлийн эх байна. Энэ нь найруулгад хамаарах эх байна. Тэгэхлээр дүгээр биеэс өгүүлж байгаа төрлийн эхэд таамагласан баймж утгат гэх мэт үг нь өгүүлэгчийн сэтгэл хөдлөлийг илэрхийлж байгаа бол тухай өгүүлж байгаа төрлийн эхэд таамагласан баймж утгат гэх мэт үг өгүүлэгчийн сэтгэл хөдлөлийг илэрхийлээгүй байна. Тиймээс таамагласан баймж үгийг хоёр төрлийн эхэд ялгаатай хэрэглэх ёстой юм байна.



Дараах өгүүлбэрийн цэгийн оронд дор өгсөн ойролцоо баймж утгат үгээс оновчтой сонгож, аль болох олон янзаар хувиргана уу.

Үлгэрлэвэл: Өнтэй өвөл	болох ШИНЖТЭЙ.	болох юм байх.
	болох маягтай.	болохоос зайлахгүй.
	болох янзтай.	болж таарна.
	болох болов уу.	болж мэднэ.
	болох бололтой.	болж мэдэх юм.
	болох байдалтай.	болох учиртай.
	болох байлгүй.	болох төлөвтэй.
	болмоор дог.	магадгүй.
	болмоор ч юм шиг.	болох ч юм бил үү.
	болох юм шиг байна.	

- Өглөөний тунгалаг агаарт айлуудын яндангийн утаа эгц дээш олгойдно. Сайхан өдөр (Ж.Г)
 - Ертөнц анх үүсэхдээ битүү хар тоосонцор, хуйларсан хар долгионоос үүссэн гэдэг бөгөөд анхдагч хар өнгө улмаар сийрэгжин агаар тогтон бусад эрхсийн нөлөөгөөр наран ивээлт цацрагаа манай гараг дэлхийд цацруулснаар хар өнгө улмаар уусан арилж, бусад өнгө үүсжээ гэж (Д.Б)
 - “Эрийн яс хээр, агтны яс аянд” гэдэг нь монгол ардын домог үлгэр, баатарлагийн туульс зэрэгт эх нутаг, эрх жаргалынхаа төлөө аюулт мангас, атаат дайсны эсрэг эрийн сайн эрс нь хүлэг сайн морио унаж, эр эмээ үзэлцэн, эрсэлдэн тэмцэлдэхдээ энэ биеэ алдаж, эмээлт хүлгээсээ хагацахыг эрэлхэг баатарлаг үйлсийн шинж хэмээн ухаарах ёстой хэмээн үздэг байснаас уг сурвалжтай хэллэг (Ж.Б)
- б. Цэгийн оронд баймж үгийн жишээ аль болох олныг бичээд, яагаад? гэдэгт өөрийн бодлоор хариулна уу.

Өгүүлэгчийн хувийн үзэл бодолд тулгуурласан ярианы хэлний таамагласан үг	Шинжлэх ухааны мэдлэгт суурилсан бичгийн хэлний таамагласан үг
.....
Яагаад ?	Яагаад?



Монгол хэлэнд түгээмэл хэрэглэдэг таамаглах баймж үг:

Бололтой, магадгүй, байж магад, байж мэднэ, боломжтой, бололцоотой, юм биш байгаа, янзтай, шинжтэй, янз нь, миний бодлоор, энэ янзаар бол, царай нь, ... царайтай, байдалтай, төлөвтэй, болов уу, юм болов уу, байж болох юм, байх, маягтай, мэдэшгүй, гэж үзэж болох юм, байж болно, болов уу хэмээн санана, тэр байх, тийм байдаг байх, ёстой болов уу?, тэр биз, биз... , тийм ч юм шиг, байж ч болзошгүй г.м.



18

Цэг цэглэлийг хэрхэн зөв хэрэглэх вэ?

32 дугаар хуудас 6 дугаар дасгал Б.Пүрэв - Очирын “Сэгс цагаан богд” уу?, аль эсвэл “Сэгсэг цагаан богд” уу? эхийг дахин унш. Дараах цэг тэмдэг эхэд ямар утга, үүрэгтэй байгааг тус бүрд нь нэрлэж, тайлбарлана уу.

№	Цэг тэмдэг	Хэрэглэсэн цэг тэмдгийг нэрлэж бичнэ үү.	Ямар утга, үүрэгтэй байна вэ?
1.	Үлгэрлэвэл: (:?)	Давхар цэг	Ямар нэгэн зүйлийг тодотгох, тоочих, эш татахад хэрэглэнэ.
2.	“Сэгс цагаан богд” уу?, аль эсвэл “Сэгсэг цагаан богд” уу?		
3	“Сэгс цагаан богд”		
4	“сэгс ...”		
5	Эрдэмтэн – зохиолч, их бичгийн хүн – Дамдинсүрэн алдаж хэлмээргүй еэ.		
6	“Мазаалайг эрсэн нь” гэдэг баримтат уран сайхны зохиолдоо: [...]		
7	зааварлаж байна: - Мазаалайг үзье гэвэл		
8	сэрүү татна. [...] (Ц.Дамдинсүрэн “Бүрэн зохиол – 1” 1998)		
9	(Утга нь: Хүүхдийн даахь; монгол бичгээр; “segsegei”)		
10	“тэмээ сөглөх” – ийн		
11	нийгэм – соёлын тал		
12	(Утга нь: Өвсөөр хийсэн сав; монгол бичгээр; “segsu”)		
13	мөнгөн дээвэр – зулайн		
14	“сэвлэг – сэгсэг”		
15	“сэгсгий” – тэй		
16	зун, намар, өвөл, хавар		
17	“барин тавин ярьсан” “барим тавим баримт” гэсэн холбоо үгнээ байгаа төгсгөлийн “н, м” бүтээврийг нэрлээд, ялгааг хэлнэ үү.		



Үгийн утгын тайлбар: зүсэм – мал, амьтны зүс

Агуулга нь	Юуны тухай бичих гэж байна вэ?
Бор өнгөний бэлгэдлийн тухай ямар асуулт гаргамаар байна вэ?	
Асуултаас ямар асуудал дэвшүүлмээр байна вэ?	
Нотлох баримтаа хаанаас хайх вэ?	
Ямар баримт жишээнд суурилан нотлох вэ?	
Чи өөрийнхөө үзэл бодлыг аль хэсэгт байрлуулах вэ?	
Дүгнэлт хэсэгтээ юуны тухай өгүүлэх вэ?	

Бичихийн өмнө: Дараах холбоо үгэнд байгаа “бор” хэмээх үг өнгө заасан уу? эсвэл өөр утга илэрхийлсэн үү? гэдгийг эргэцүүлэн бодъё.





Бие дааж бичье.

Бор зүсмийн бэлгэдэл

Монгол шидэт үлгэр, баатарлаг туулийн зарим баатрууд нисдэг бор морьтой байх нь нэлээд элбэг. Халх ардын туулийн баатар нэгэн зуун тавин таван насыг насалсан хөгшин Луу мэргэн хаан “Уурга хуйваар барьдаггүй, алтан шар хазаараар даллаж, хурайлж барьдаг, жигүүртэй бор морин хүлэгтэй байдаг бөгөөд хол ойрын дайнд эцэж үзээгүй нисдэг хүлэг байдаг билээ.

Харин халх туулийн баатар Алтай гургалдай хааны хүлэглэдэг хүлэг нь ах дүү хоёр бор морь билээ. Эл хоёрын ах бор морь нь хэдийбээр нисдэг хүлэг хэмээн дурдаагүй боловч аяар холын газраас зулын цагаан өвс болоод хийсээд гадаа ирдэг нь жигүүрлэн нисэхийг улбарих*, хувилах өгүүлэмжээр төлөөлүүлэн дүрсэлсэн гэлтэй.

Гэтэл монгол шидэт үлгэрийн баатар Болдоггүй (Бор) Боролзой өвгөн долоон бор хоньтой, нисдэг, нисдэггүй бор морьтой, нисдэг бор морио гэрийнхээ баруун талд уядаг, нисдэггүй бор морио зүүн талдаа аргамждаг байжээ. Ингээд нисдэг бор мориороо “Хурмаст тэнгэрийн хон хэрээ, хоёр чоно, хоёр лууг гүйцэж очоод шийтгэж орхидог удвистай билээ.

Дархад бөөгийн “Зөнөг хайрхан”-ы түүхт домогт Зөнөг хайрхан нэг нисдэг бор морьтой болоод хүрэхгүй газаргүй. Тэр морио унаад алга болоод байхлаар эмгэн нь хардаад, нэгэн шөнө уяан дээрээ гөлөм нь даржигнан дуугарч байхлаар нь сөхөж харсанд хойшоогоо жигүүрлэсэн, хоёр их далавчтай морь байсанд түүнийг нь огтолж хаяснаас болоод Зөнөг хайрхан унаагүй болж явгарчихсан юм гэж өгүүлдэг.

(С.Дулам)

Даалгавар

Бичихийн өмнө

Яагаад “Миний цагаан хүү” гэхгүй “Миний бор хүү” гэдэг юм бол? Яагаад “Эмээгийн цоохор авдар” гэхгүй “Эмээгийн бор авдар” гэдэг юм бол?

Монгол ардын үлгэрт яагаад “Хамуутай хар даага” гэхгүй “Хамуутай бор даага” гэдэг юм бол? гэх зэргээр эргэцүүлэн бодоорой.

Үг хэллэгийн утгыг интернэтээс хайж, ахмад хүмүүс, багш нараасаа асууж бяцхан судалгаа хийж олоорой.

Ийнхүү үлгэр, тууль, домгийн баатрууд ямар учраас чухам нисдэг бор зүсмийн (нисдэг хээр, зээрд, хөх бус) морьтой байна вэ?” гэсэн асуултад хариулахдаа үндэслэлтэй таамаглал дэвшүүлж бичнэ үү?

Боржигоны бор тал
Ээжийн бор аяга
Миний бор хүү
Эмээгийн бор авдар
Бор борын бялзуухай
Хамуутай бор даага

* улбарих - хувилах



Асуудал дэвшүүлэн баримт, үзэл бодлыг хослуулан, санаагаа илэрхийлье.

- ◆ Асуудал дэвшүүлэх
- ◆ Таамаглал дэвшүүлэн, үзэл бодлоо илэрхийлэх
- ◆ Өөрийгөө сорих



Тайлбарлахыг хүсэж байгаа буюу дэвшүүлэх асуудлаа шийдэх:



1
Асуудал, асуулт хоёр адил уу? Асуудал дэвшүүлнэ гэж юу гэсэн үг вэ?

2
Жишээлбэл, Манай монгол хэлэнд эргэлзээтэй, сонин асуудал олон байдаг шүү дээ.




3
Аан, нээрээ тийм байна. Монгол хэл хэдэн үсэгтэй вэ? гэвэл асуулт, “Цонх” гэдэг үг уугуул монгол үг биш бололтой” гэвэл асуудал болох юм байна.

4
Тэгвэл, асуудал гэдэг нь эргэлзээтэй юмыг таамаглаж бодохоос эхлэх юм байна даа. Жишээ нь: “Нэг ангийн хүүхдүүд бие биедээ хүчтэй нөлөөлдөг байж болно” гэвэл асуудал.



Асуудлыг хаанаас хайх вэ? Тухайлбал:





Асуудал хэрхэн бий болох вэ?
Асуудлыг яаж дэвшүүлэх вэ?

БАЙГАЛЬ, НИЙГЭМ, ЮМС ҮЗЭГДЛЭЭС – АСУУЛТ - АСУУЛТААС таамаглал дэвшүүлсэн асуудал бий болно. Жишээ нь :

Асуулт	Дэвшүүлсэн асуудал нь
Орчин үед хүмүүс номтой хэрхэн харьцаж байна вэ?	Хүн номоос татгалзах ёсгүй. Ном биднийг хүмүүжүүлдэг, оюун ухааны тэжээл болдог.
Орчин үеийн хүмүүс хэр уншдаг вэ?	Хэрэв хүн уншихаа боливол амьдралын оюун санааны үндсээ алдана гэсэн үг.
Хөгжил дэвшлийн ололт амжилт хүнд хэрхэн нөлөөлж байна вэ?	Шинжлэх ухаан, техникийн ололт амжилт номыг үгүй хийж байна. Компьютерээр номыг солих ёсгүй.
Ертөнц дэх хүний амьдралын үндэс нь юу вэ?	Хүний оршихуйн үндэс нь оюун санааны үндэс юм. Бид номоос татгалзаж байгаа нь сэтгэл санаагаа хуурч байгаа хэрэг юм.

Одоо эдгээрээс таамаглал дэвшүүлэх боломжтой асуудал байна уу? гэдэгт дүн шинжилгээ хийе.

Таамаглал нь эргэлзээтэй асуудлаас үүснэ.

Жишээ нь: “Хэрэв хүн уншихаа боливол амьдралын оюун санааны үндсээ алдана” гэсэн асуудлыг нөгөө талаас “Хэрэв хүн уншихаа боливол амьдралын оюун санааны үндсээ алдахгүй ч байж болно” гэвэл алдаатай таамаглал болно. Учир нь энэ бол үгүйсгэх, эсвэл өөрөөр үзэх тийм ч боломжтой эргэлзээтэй асуудал биш байна. Яагаад гэвэл, уншихаа болих нь хүнийг сэтгэхээ боль гэсэнтэй адил зүйл гэдэг нь хүн төрөлхтний амьдралын түүхээр батлагдсан ойлголт шүү дээ.

Эсвэл “Нар яагаад жаргадаг вэ?” гэдэг асуултаас ямар нэг таамаг төрөх боломжгүй юм. Учир нь аль хэдийнээ шинжлэх ухаан нотолсон асуудал. Харин “Шинжлэх ухаан, техникийн ололт амжилт номыг үгүй хийж байна. Компьютерээр номыг солих ёсгүй” гэсэн асуудлыг “Шинжлэх ухаан, техникийн ололт амжилт номыг үгүй хийнэ гэдэг нь эргэлзээтэй дүгнэлт. Номыг цахим хэлбэрт шилжүүлэх нь үр дүнтэй арга байж болох юм” гэвэл аль ч талаас нотолж болох боломжтой асуудал болно.


Тэгэхлээр таамаглах асуудал бол **ЧИНЙ ХУВЬД ҮЛ МЭДЭХ, ЭРГЭЛЗЭЭТЭЙ, СОНИРХОЛ ТАТСАН** асуудал л байх юм байна.

Тиймээс **ТААМАГЛАЛ ДЭВШҮҮЛЭХ АСУУДЛАА ЗӨВ СОНГОЖ СУРЪЯ.**



Таамаглаж бичихэд юуг анхаарах вэ?

- ♦ Таамаглах гэж байгаа зүйлийнхээ тухай ном, сонин, интернэт гэх мэтээс уншиж судлан, бага ч гэсэн мэдлэг, мэдээлэлтэй болсон байна.
- ♦ Баримт нотолгоонд тулгуурлан таамаглана.
- ♦ Үзэл бодол нь ул суурьтай дүгнэлт шинжтэй байдаг тул уран сайхны сэтгэл хөдлөлийн үг хэллэг бага байна.
- ♦ Гэхдээ сонирхолтой болгох, өөрийн үзэл бодлыг илэрхийлэхэд зарим үед сэтгэгдэл мэдрэмж илэрхийлсэн үгс, уран дүрслэлийг ашиглаж болно.



Хэрэв асуудал дэвшүүлсэн бол үзэл бодлоо илэрхийлж, түүнийгээ баримтаар нотолж дүгнэлт гаргана. Үзэл бодлоо хэчнээн ч өгүүлбэрээр дэлгэрүүлэн илэрхийлж болно. Ажигласан зүйлээ юу гэж үзэж, түүнд хэрхэн хандаж байгаа нь хамгаас чухал юм.

Загварыг ажиглаарай.



Асуудал гэдэг нь одоогийн бодит байдал, хүрэхийг хүсэж байгаа зорилго хоёрын хооронд үүсэж байгаа нөхцөл байдал юм. Жишээлбэл: Байгаль дэлхийгээ сүйтгэж байгаа хүний буруу үйл ажиллагаа нь одоогийн бодит байдал. Хүн төрөлхтний зорилго нь байгаль дэлхийгээ хайрлаж, онгон хэвээр хадгалж үлдэх. Энэ хоёрын дундаас үүсэж буй нөхцөл байдал буюу асуудал нь байгалиа хэрхэн цэвэр ариунаар хадгалж үлдэх вэ? гэдэг нь юм.





21

Үзэл бодлоо илэрхийлье.

Таамаглал дэвшүүлэн жишээ баримтаар батлахын сацуу үзэл бодлоо илэрхийлэн бичих нь чухал.

Дараах хэсгийн асуултаас өөрийн үзэл бодлоор таамаглал дэвшүүлж, дүгнэлт гаргана уу? Дээрх (44-р хуудасны) баймж утгат үгээс сонгон хэрэглээрэй.

а. Хөдөө би цэцгэн дунд өссөн билээ. Сэвсгэр цагаан цасан бүрхүүл адил толгойтой өндөр ургасан өвсийг авч, амандаа хийгээд “бээ-бэн баабан” гэж олонтоо хэлэхлээр өнөөх өвсний иш аман дотор дугуйран эргэлдэж, хүн гараараа зориуд имрэн эвхсэн мэт дугуй болдог. Энэ бол мөнөөх “бээбэн – баабан” нэртэй цэцгэн өвс юм. Бус өвсийг амандаа хийж дуугарахад, эргэлдэн дугуйрах байтугай эвхрэн нугарах ч үгүй. Харин “бээбэн – баабан” яагаад ингэдэг юм бол? гэж би гайхдаг сан.

(Д.Баттогтох)



Энэ мэт олон янзын өвс ургамал, шавж амьтныг хүүхдүүд эрхлүүлэн наадах явцдаа уран холбоо шүлэг хэлнэ, уралдаж тэмцэлдэнэ, энэ явцдаа байгаль ургамал амьтныг таньж мэднэ. Энэ амьтны нэрийг би бодохдоо




“Бээбэн – баабан гэдэг үгэнд хэдэнтээ орсон “б” авианы онцлог шинжид тулгуурлан түүний учрыг тайлбарлавал,

б. Шавж амьтныг хүртэл тоглоом болгон зугаацан, өдрийн уртыг хөдөө хээр өнгөрүүлдэг сэн. “Өргөө маани” нэртэй цох хорхойн чинээ биетэй, нуруу биеэрээ олон жижиг, өнгө өнгийн толботой, удаан хөдөлгөөнтэй амьтан. Энэ амьтны сонин нь гэвэл ямагт өөдөө асан авирч явна. Гарын алган дээрээ тавиад “Өргөө маани өөдөө дээшээ” гэхээр хүний хэл мэддэг амьтан шиг зогсож байснаа өөдөө алгуур өгсөөд ирнэ. Гараа уруугаа унжуулахад уруудахгүй мөн эргээд өгсөж эхэлнэ. Ингэж их нааддаг сан. Говьчууд “нүүдгий” гэж нэрлэдэг. “Нүүдгий нүүдгий нүүгээрэй” гэхэд мөн л дээш нүүж өгсөнө дөө. Энэ амьтныг яагаад “өргөө маани”, “нүүдгий” гэж нэрлэсэн юм бол хэмээн бодоход бас л сонин таамаг төрнө... (Д.Баттогтох “Эсээ бичих эрдэм” Уб., 2006)



а. Бичих төлөвлөгөө гаргая.

Эхийг дараах асуулт төлөвлөгөөний дарааллаар бичье.



б. Зураг ба тайлбарыг ажиглая.

Баримтаас үүдэн таван асуулт бичнэ. Жишээ нь: Нүүдлийн шувууд яаж холын аяныг ажралгүй туулж ирдэг юм бол? Шувууд хүнээс илүү ухаантай юу? г.м. аль болох эргэлзээ төрөх сонирхолтой асуулт бичихийг хичээнэ. Асуултуудаас хамгийн оновчтой нэгийг сонгож, таамаглал дэвшүүлнэ. Үлгэрлэвэл: Нүүдлийн шувууд өөртөө тохирсон ямар нэг хөдөлмөрийн хуваарьтай байх магадлалтай. Түүчээ шувуу хамгийн сайн удирдагч байж магадгүй. г.м. Дэвшүүлсэн асуудлаа, өөрийн үзэл бодлоор дэлгэрүүлэн, баталж нотолж бичихдээ зураг ба эхийг ашиглаарай.

АНУ – ын Шинжлэх ухааны үндэсний хүрээлэнгийн гаргасан судалгаа	
Байрлалаа байнга солих нь шувуу бүрд амрах боломж олгодог.	
Нүүдлийн шувууд түүчээ шувууг даган салхины урсгал сөрж нисдэг.	Түүчээ шувуу хамгийн их ажилтай.
	Нэг эгнээний шувууд далавчаа ижил хэмнэлтэй дэвж, бага хүч зарцуулдгийг тогтоожээ.



Шувууд байрлалаасаа хамааран далавчаа өөр хэмнэлээр дэвэх бөгөөд хоёр дахь эгнээний шувуу түүчээ шувуунаас өөр хэмнэлээр дэвдэг.



- в. Дараах эхийг уншаад, төгсгөлийн дөрвөн мөрийг таамаглан, нөхөж бичнэ үү.

Зэрлэг галуу

Зэрлэг галуунууд хамгийн зөв газар, хамгийн богино хугацаанд, хохирол багатай нүүдэллэдэг шувуу. Зэрлэг галуунууд нүүдэллэхдээ хэлбэртэй зэллэдэг. Тэргүүлэгч галуу нисэхдээ далавчаа байнга дээш нь өргөж, өөрийг нь даган нисэж буй бусдадаа хүч нэмдэг. Хамгийн урд нисдэг учраас хэсэг хугацааны дараа ядарна. Ядарсан галуу үүргээ өөрийнхөө ард нисэж яваа өөр галуунд шилжүүлж өгөөд өөрөө сүргийнхээ хамгийн хойно очдог. Ингэснээр дараагийнх нь бусдыгаа удирдан нисэх хэрэгтэй болно.

Зэрлэг галуу миний хамгийн хайртай шувуу. Яагаад гэж үү?

- учраас
-учраас
-учраас
-учраас

Та нар юу гэж бодож байна? Тэднийг хайрладаг минь зөв үү? (Исмаил Боз)

- г. Дээрх баримт мэдээлэл ба “Зэрлэг галуу” эхийг харьцуулан ажиглаад, адил ба ялгаатай талыг гаргана уу.



Таамаглал дэвшүүлсэн эх зохиоё.

“Монголын Нууц Товчоо” зохиолын 78-р зүйлд: “Нялх үрээ гилэн (хөөн) ядаж, нядлан идэх нүгэлт ангир мэт” гэсэн хэллэг буй. Нээрэн, ангир зулзагаа иддэг гэж үү? Монголчууд ангирыг лам шувуу гэдэг. Ламын орхимж мэт улбар шар өнгөтэй тул тийнхүү нэрлэсэн ажээ. Бодоод байхад, төрүүлсэн үр зулзагаа иддэг тийм муухай амьтан энэ ертөнцөд үгүй. Хүүхдүүд ээ, та нар юу гэж бодож байна вэ? Энэ талаар ярилцаж, таамаглал дэвшүүлсэн өгүүлбэр аль болох олныг бичээрэй.



Тэгээд таамаглалынхаа үнэн, худлыг батлахын тулд Ж.Мягмарсүрэнгийн бичсэн “Унагаа зуусан хулан буюу амьтдын тухай өгүүллэгүүд” номоос “Зулзагаа идэгч ангир мэт” хэмээх өгүүллэгийг (112-113-р тал) уншаад, төрсөн сэтгэгдлээ таамаглалтайгаа холбон, сонирхолтой эх зохион бичиж, найз нөхөд, гэр бүлийнхэндээ уншиж өгөөрэй. Уншигчийн анхаарлыг татахын тулд гарчиг нь ямар байвал зохимжтой вэ?

Эрдэмтэн зохиолч Ц.Дамдинсүрэнгийн “Хоцрогдсон эмгэнийг сурвалжилсан тэмдэглэл” (1974) өгүүллэгийг олж уншаарай. Зохиолын баатар Лоовой гуайг “Хоцрогдсон эмгэн” хэмээн нэрлэсний учрыг, зохиолчийн зорилгоос үүдэн таамаглан тайлбарлаж бичнэ үү. Ингэхдээ өгүүллэгийн доторх дүр дүрслэл болон Лоовой гуайн ярианаас эшлэл жишээ татан баталж, нотлон үндэслэлтэй таамаглал дэвшүүлээрэй.

Бичихдээ сонгон, ашиглаж болох үгс:

- ◆ ... сонин байж болох юм.
- ◆ ... болсон гэж үзэж болно.
- ◆ ... хэмээн үзэж байна.
- ◆ ... хүн байсан бололтой.
- ◆ ... зохиолчийн өвөрмөц шийдэл гэмээр байна.
- ◆ ... уран болсон шиг.
- ◆ ... надад санагдлаа.
- ◆ ... юм шиг санагддаг.
- ◆ ... ыг (ийг) ажиглаж, ыг (ийг) ухаарч бичсэн бололтой. г.м.

Бичих зүйлийнхээ талаар санаа авахын тулд, эрдэмтэн Б.Пүрэв – Очирын “Сайн үйлсийг бүтээж салаа замаар явсан эрдэмтэн – зохиолч” УБ., 2008 номын 145 – 146 дугаар талыг уншвал илүү сайн.

“... Дэлхийн ойр орчим дахь гараг эрхэс дээр амьдрал байна уу? гэдгийг бид хамгийн түрүүн эрдэг. Биднийхээр амьдрал байна уу гэдэг нь амьтан, ургамал байна уу, агаар байна уу, ус байна уу л гэсэн үг. Амьдралын тухай бидний ойлголт энэ. Энэ ойлголтоороо бид өөр гараг эрхсээс хорхой, шавж, өвс, ургамал, бичил биет, бичил ургамлыг эрдэг. **Харамсалтай нь, бид эрснээ хэзээ ч олохгүй байж мэднэ. Дэлхийгээс өөр гараг эрхэс өөр амьдралтай байж мэднэ...**” (Д.Батбаяр) гэснийг үгүйсгэн таамаглаж бичнэ үү.

Үгүйсгэнэ гэдэг нь энэхүү эхийн санаатай санал нийлэхгүй байгаагаа илэрхийлнэ гэсэн үг. Ингэхийн тулд, эхлээд эхээс ялгасан хэсгийг үгүйсгэн хувиргаад үзье.

Харамсалтай нь, бид эрснээ хэзээ ч олохгүй байж мэднэ. Дэлхийгээс өөр гараг эрхэс өөр амьдралтай байж мэднэ...

Үгүйсгэсэн таамаглал ?

Үүний дараа ТААМАГЛАЛ – САНАЛ – БАТАЛГАА – ДҮГНЭЛТ – ийг эрэлхийлж бичнэ үү.



Бүтээлч даалгавар

Таамаглал дэвшүүлэн тайлбарлаж бичихдээ дараах алхмыг баримтална.

1 дүгээр алхам: Судалж үзэж, таамаглал дэвшүүлэхээр сонирхож байгаа асуудал юм уу, аль эсвэл асуултаа бичнэ. Жишээ нь: Энх тайван, амар амгалан амьдрал гэж юу болох тухай бичмээр байж болно.

2 дугаар алхам: Юуг тайлбарламаар байгааг олж тогтоох.

3 дугаар алхам: Мэдээлэл цуглуулах.

4 дүгээр алхам: Цуглуулсан мэдээллүүдээ задлан шинжилж, хооронд нь харьцуулах.

5 дугаар алхам: Олсон баримт мэдээлэлдээ тулгуурлан, хамгийн оновчтой, учир шалтгаантай байж болох таамаглалыг гаргаж ирэх.

6 дугаар алхам: Сайтар нягтлах, өөрчлөх зүйл байна уу? Уншигчийн зүгээс санал нийлмээргүй зүйл байна уу?

Тухайлбал: Зохиолчийн амьдрал, уран бүтээлийг шинжлэн судлаад, өөрийн үзэл бодлын үүднээс таамаглал дэвшүүлсэн тайлбар бичиж болно.



Зөвхөн чиний хувьд бодож олсон өвөрмөц асуудлыг олон зүйл баримт эсвэл уншиж байгаа эхийн дотроос яаж гаргах вэ?

Халх голын дайн хэзээ болсон бэ? Дайн анх яаж эхэлсэн бэ? Дайныг ямар хүн өдөөдөг юм бол? Энх амгалан амьдралаас ямар хүн татгалздаг юм бол? гэвэл асуудал биш асуулт болно. “Энх амгалан амьдрал тийм ч хямд үнээр бий болдоггүй бололтой”, “Энх тайван, амар амгалан байх гэдгийг “Өрөөлийг зовоовол, өөрөө зовно доо хө” хэмээн ардын дуугаар дамжуулан өгүүлсэн мэт” гэвэл асуудал болно.

Олон янзын баримт мэдээллийн дундаас чамд юу бодогдож байна вэ? Шийдмээр, эргэцүүлж бодмоор ямар асуудал байна вэ? гэдгийг л олж гаргах хэрэгтэй юм. Тэр бол аль болох ангийнхан чинь бодож олоогүй, ажиглаж хараагүй нээрээ ямар сонин юм бэ гэж бодогдохоор, зөвхөн чиний өвөрмөц, ул суурьтай санаа байвал хамгийн сайн асуудал болно. Түүнийгээ чи бичиж байгаа эхийнхээ гол санаагаар дамжуулж илэрхийлнэ. Жишээ нь. “Би ээждээ хайртай” гэвэл асуудал мөн үү? гэдэг эргэлзээтэй. Хүн бүр л хэлдэг, хүн бүрийн цээжинд байдаг үг. Харин “Эхийн санаа үрд, үрийн санаа ууланд гэдэг үг ан гөрөө, зугаа цэнгэл хөөцөлдөхөөс бусдыг умартсан хүний хэрэг явдлаас үүдэн гарсан бололтой” гэх юм уу, эсвэл

“Ээждээ ганц сайхан хувцас хийгээд өгье.

Дараа мөнгөтэй болохоор...

Ээждээ амттай юм худалдан авч өгье.

Дараа ажилд орохоор...

Ээжийгээ нисэх онгоцонд суулгаж үзүүлье.

Дараа баян болохоор ...

Бага залуу байхад ээждээ хийж өгмөөр зүйл их байсан. Тэр нь дандаа “дараа” - аар дуусдаг байсан ч, хүсэл мөрөөдөлтэй, хөөр баяр, аз жаргалтай байлаа. Тэр үед би мэддэггүй байлаа. “Дараа” гэж байдаггүй гэдгийг” гэснээс үүдэн “Дараа” гэж үнэхээр байдаг уу? гэсэн асуулт тавиад, “Ээжтэй хүнд “Дараа” гэж байдаггүйг мэддэг хүн хэр олон бол? Бараг л байхгүй болов уу” гэвэл асуудал болно. Үүнийгээ өөрийн үзэл бодол, эсвэл амьдралын жишээгээр нотлох шаардлагатай болно.





ТААМАГЛАЛ ДЭВШҮҮЛЭН ҮЗЭЛ БОДЛОО ИЛЭРХИЙЛБЕ.

Баримт мэдээлэл ба уран зохиол, түүхэн хэрэг явдлаас үүдэн асуудал дэвшүүлээд, түүнийгээ шийдвэрлэх арга замыг олъё.

1 дүгээр алхам: Судалж үзэж, таамаглал дэвшүүлэхээр сонирхож байгаа асуудал юм уу, аль эсвэл асуултаа бэлтгэнэ. Жишээ нь: “Энх тайван, амар амгалан амьдрал гэж юу болох тухай”, аль эсвэл “Хөгжих гэж юу вэ?” гэдэгт хариулт хайж бичмээр байж болно.

Бичихийн өмнө дараах найраглалын хэсгийг уншаад, тэртээ 1939 оны Халх голын дайн дуусахад эх орныхоо төлөө амь биеэ зориулсан хэчнээн дайчин залуугийн хэчнээн гэр бүл өнчрөн үлдэж, тэдэнд ямар их уй гашуу авчирсныг, хүнд хэцүү цагт эх орноо хамгаалахаар цэл залуугаараа дайнд мордсон эр цэргийн дүр төрх, тэдний ар гэрийг төсөөлөн бодоорой.

“Хөх даалимбан тэрлэг” найраглалын хэсгээс

Цэрэг эрсийн улаан тоос
Цэцгэн дундуур татаад явсан юм.
Цээжин дотор хагацал орхиод
Цэнхэр уулсыг даваад явсан юм.
Олон эрчүүл дуугаа дуулаад
Онгон талаар давхиад явсан юм.
Орон гэртээ зайгаа орхиод
Одтой адил харваад явсан юм.
Сарних тоосны нэгэн үзүүрт
Саруул нүдээ би чилээж
Санаа алдан сүүгээ өргөн
Сар шиг мэлтрэн гаднаа үлдсэн юм ...
Цэрэг эрсийн улаан тоос
Цэцгэн дундуур татаад ирлээ.
Цээжин дотор учрал зарлаад
Цэнхэр уулсыг даваад ирлээ.
Олон эрчүүл дайснаа дараад
Онгон талаар давхиад ирлээ.
Орон гэртээ зайгаа эзлээд
Одтой адил харваад ирлээ.
Халагдаж ирэх цэргийн сургаар
Хадам аав сумын төв рүү
Унаа, хөтлөө хоёр морьтой
Улсын түрүүнд давхиад явчлаа.
Хөөрөн сэнсрэх сэтгэл гэдэг
Хөл газар хүрэхгүй дэрвэж
Хөв чийгий нь эгшээн тавихаар
Хөх даалимбан тэрлэгээ гаргалаа...
Тэгтэл ... нар шингэсэн хойно

Тэртээгээс хадам аав ганцаар
Эмээлтэй морь хөтөлсөн чигээр
Эргэж ирээд уяан дээр буулаа.
Гэр лүүгээ нэг явах гэснээ
Гэнэтхэн зог тусаж зогссоноо
Хонгор морины эмээлийг авч
Хоёр бүүргэнд хазаарыг сойлоо.
Үеийг эзэлсэн буурал хайлаас
Үндэс тасран гуйвалж байх шиг
Сүртэй өвгөн эмээл тэвэрсээр
Сүүдэр шиг нааш айсуй харагдлаа.
Гэнэтхэн миний дотор палхийж
Гэртээ орж гэрэл барилаа.
Айсан туулай шиг дүрлийн гайхаж
Аавын өөдөөс дуугүй ширтлээ.
Аав ч бас таг дуугүй
Асга царай нь тас харанхуйлж
Төөрсөн гар нь эмээлээ алдахуй
Төмөр дөрөө нь ёолон харшлаа.
Хөл доорх газар дайвж
Хөх ногоон улаанаар эргэж
Хүний орчлонд барьц алдахдаа
Хүүгээ л би тэврэн авлаа.
Эрлэг дайны хүйтэн савар
Эвдэрсэн сэтгэл тэмтрэх цагт
Ямар их хүнд үнээр
Ялалт ирснийг бид мэдлээ...

(Д.Пүрэвдорж)

Гэртээ: Төрийн шагналт, ардын уран зохиолч Д.Пүрэвдоржийн “Хөх даалимбан тэрлэг” найраглалыг бүрэн эхээр нь уншаад, “Хөх даалимбан тэрлэг” хэмээн нэрлэсний учрыг таамаглан тайлбарлаж бичээрэй.



2 дугаар алхам: Юуг тайлбарламаар байгааг олж тогтооё.

1939 оны Халх голын дайны тухай үйл явдлаас бидэнд мэдэхгүй зүйл их байна. Эндээс ямар нэгэн асуудал дэвшүүлэн таамагласан эх бичиж болох юм. Юуг таамаглах вэ? Эргэцүүлэн бодъё.

3 дугаар алхам: Мэдээлэл цуглуулъя. Гэрэл зургуудыг ажиглая. Бас бодит баримт, болсон явдлын жишээг уншиж, гэрэл зурагтай харьцуулъя. Холбогдолтой өөр жишээ хайж олъё.



§ 1939 оны 5 дугаар сарын 11-нд Номун хан, Бүрдэн Овооны чиглэлээр Япон-Манж-гогийн миномёт, пулемётоор дэмжүүлсэн 200 цэрэг бүхий салбарууд хилээс дотогш холгүй зайд орших Байтагт манханд үүрэг гүйцэтгэж байсан 10 хүний бүрэлдэхүүнтэй хилийн харуул руу дайрсныг Халхын голын дайн буюу зарлаагүй дайны эхлэл хэмээн тооцдог.

(С.Амарсанаа нар "Түүх IX" УБ, 2015, сурах бичгээс)

§ 1939 оны Халхын голын дайн, 1941-1945 оны Орос, Германы дайн, 1945 оны чөлөөлөх дайнд оролцож явсан ахмад дайчин Б.Лааган гуайн ярилцлагаас:

Сэтгүүлч: - Та хэдэн онд цэрэгт татагдсан бэ? Энх цагт аж төрж буй залууст газар нутгийнхаа төлөө тэмцсэн ахмад дайчдын үг юу юунаас ч илүү үнэтэй гэж бодож байна?

Б.Лааган*: - 1939 он хүртэл мал маллаж байгаад, хаваржаанаасаа цэрэгт татагдаж, эжийдээ нэг үнсүүлээд л мордсон. Ээж Жургаа маань хойноос сүү өргөөд хоцорч билээ.

Халх гол хавийн газар чинь нэг метр гүн хар шороотой, үржил шимтэй. Тийм

* Б.Лааган - Монголын нэртэй агрономич, эрдэмтэн, төрийн соёрхолт. Дэлхий нийтэд алдаршсан хүн.



болохоор газар нутгаа хайрлах хэрэгтэй. Дайнаас би юу сурсан бэ гэхээр цэрэг хүн буудаж сурах хэрэгтэй. Мэргэн байх. Хоёрт, зэвсгээ бүрэн эзэмшиж, хайрлаж хамгаалах. Гуравт, цэргийн сахилга батыг хатуу сахих ёстой. Бид сахилга бат сайтай, эх орноо хамгаалах тэсвэр хатуужилтай байсан. Хүнд бэрх цаг үе байсан болохоор л эрх чөлөө олдсон юм шүү гэдгийг залуучууд ухаарч яваасай. Дайнд ялахад хувь нэмрээ оруулсан олон баатрыг мартаж болохгүй. Дахиж дайн битгий болоосой. Чөлөөлөх дайнд ялалт байгуулснаар Монгол улсыг тусгаар улс гэдгийг дэлхий дахин хүлээн зөвшөөрсөн юм шүү.

Сэтгүүлч: - *Та манай сонины уншигчдад тэр аймшигтай дайны талаарх дурсамжаа хуваалцана уу. Өдгөө залуучууд, хүүхдүүд энэ тухай бараг л мэдэхгүй болж. Дайн байлдаан гэхээр хүмүүс тэр бүр сайн төсөөлдөггүй. Кинонд гардаг шиг л хурдан өнөөрдөг гэж боддог. Бодит байдал дээр ямар байв?*

Б.Лааган: - Орос, Германы дайны үед нуувчинд буугаа бариад, буудахад бэлэн дээш өргөөд, шинелиэ нөмрөөд л хононо шүү дээ. Өдөр бол гайгүй байснаа яг нар шингээд ирэхээр л Германы онгоц бөмбөгдөж эхэлнэ. Тэгээд бөмбөгдөөд дуусахаар нь бид нуувчнаас гараад, буу засах ажилдаа орно.

§ Чөлөөлөх дайны гал дунд халуун амь, бүлээн цусаа хайрлалгүй баатарлагаар тэмцэж явсан олон арван дайчин эрсийн дотроос Л.Аюуш, С.Дампил, Д.Данзанванчиг, М.Жанчив, Д.Нянтайсүрэн, Т.Дүүдэй нарын баатрууд төрсөн билээ. Өнөөдөр ч БНХАУ-ын Хэбэй мужийн Жанбэй хотын Жанчхүүгийн даваан дээр ялалтын төлөө амиа өргөсөн орос, монгол дайчдын хөшөө сүндэрлэн буй.

§ Халхын голын дайнд Монголын талаас морьт дивиз тав, моторжуулсан хуягт болон нисэх бригад тус бүр нэг, их буу, хуягтын хэд хэдэн дивизион, хангалт үйлчилгээний тусгай анги салбарууд, ЗХУ-ын талаас мотобуудлагын дивиз* гурав, моторжуулсан хуягт бригад тус бүр гурав, танкийн бригад хоёр, их бууны хороо дөрөв, нисэх хороо зургаа, тусгай анги салбарууд оролцож, манай орны хил хязгаар, улс орны тусгаар тогтнолыг хамгаалахад үнэлж баршгүй үүрэг гүйцэтгэсэн байдаг.

(С.Амарсанаа нар “Түүх IX” УБ, 2015, сурах бичгээс)



Баримт ашиглахдаа: Мэргэжлийн үг, нэр томъёог хэрхэн ойлгож хэрэглэх вэ?

Жишээлбэл:

“Монголын ардын хувьсгалт цэрэг 1930 онд ЗХУ-аас БА-27 хуягт* машин эхлээд 6, дараа нь 2-ыг авснаар өмнө нь байсан 3 хуягтын хамт анхны хуягт дивизионыг* бүрдүүлжээ. Халх голын дайны үед зөвхөн 6, 8 дугаар морьт дивиз* хуягт дивизионтой* байсан бөгөөд тэдгээрийг зөвлөлтийн цэргийн командлалын* зүгээс Монголын ардын армийн* байлдааны хамгийн өндөр чадвартай анги гэж үнэлдэг байсан юм билээ” гэсэн мэдээлэлд бидний мэдэхгүй үг хэд хэд байна.

Интернэтээс, тайлбар толиос мэдэхгүй үгийн утгыг хайж олох хэрэгтэй юм байна. Дайн тулалдааны тухай баримт учир цэргийн холбогдолтой нэр томъёо их байна. Энэ үйл явдал 80-аад жилийн өмнө болж байсан учир тэр цаг үед хэрэглэж байсан үг хэллэг одоо хуучирсан байна. Тэгэхлээр аливаа мэдээллийг уншихдаа, ямар цаг үеийнх вэ?, хэдэн жилийн өмнөх вэ? гэдгийг бодож тунгааж унших хэрэгтэй юм байна. Тэгээд ямар цаг үеийн үйл явдал вэ? гэдгээс шалтгаалан бичиж байгаа эхдээ тэр үеийн үгийн сангаас сонгож ашиглавал илүү сонирхолтой болох юм байна. Тухайлбал: 1939 оны дайн тэртээ 80-аад жилийн өмнөх цэрэг, дайны үйл явдал учраас

- ◆ Хуягт машин, хуягт танк
- ◆ Дивизион
- ◆ Командлал
- ◆ Морьт дивиз гэх мэт үгийг хэрэглэсэн юм байна.



Нэр томъёоны тайлбар:

- * окоп - газар доорх нуувч
- * мотобуудлагын дивиз - дугуйт техник бүхий хуурай замын цэргийн нэгтгэл анги
- * хуягт машин, хуягт танк - сумнаас хамгаалах болд төмрөөр хуягласан цэрэг дайны зориулалттай техник
- * дивизион - цэргийн нэгтгэл анги
- * морьт дивиз - морин цэргийн нэгтгэл анги
- * командлал - бүх цэргийг захирах удирдлага
- * Монгол ардын арми - улсын зэвсэгт хүчний нийт бүрэлдэхүүн

4 дүгээр алхам: Дээрх баримт мэдээллийг харьцуулан эргэцүүлье.

1939 он. Одоогоос хэдэн жилийн өмнөх явдал вэ? Тэр үед дэлхийн олон оронд дайн дэгдсэн үе байж. Зураг дээр дайны хүнд хэцүү үе, дайнд амь үрэгдсэн баатруудад зориулан Халх голын хөвөөнд босгосон хөшөө дурсгалын цогцолбор байна. Лааган гуайн яриа бас бодит түүхийг өгүүлж байна. Миний бичих сэдэвт аль мэдээлэл нь хэрэг болох вэ? Аль мэдээлэл нь миний анхаарлыг татаж байна вэ? Дайнд оролцсон ахмад хүний яриаг уншихад юу нь сонирхолтой, бас эргэлзээтэй байна вэ?

5 дугаар алхам: Юуг онцолж таамаглал гаргаж болох вэ? Олсон баримт мэдээлэлд тулгуурлан хамгийн оновчтой, учир шалтгаантай байж болох таамаглалыг гаргаж ирье. Дараах шүлгийн дүрслэлийг эргэцүүлье.

Дайн

Дайн - Хүнгүй гэр
 Гэргүй хүн
 Дайн - Хөлгүй бие
 Биегүй хөл
 Дайн - Эргүй эхнэр
 Эхнэргүй эр
 Дайн - Аавгүй хүү
 Хүүгүй аав
 Дайн - Малгүй бэлчээр
 Бэлчээргүй мал
 Дайн - Дарийн утаа
 Тахал зовлон

Дайныг бид хазаарлана.

Дахин бид гаргуулахгүй.

(Д.Гомбожав)


Асуудал дэвшүүлэн, үзэл бодлоо үндэслэлтэй илэрхийлье.

Энэ дайнд өвөг дээдэс маань эх орон, газар нутгаа үр хойч бидэндээ үлдээхийн төлөө халуун амиа зориулан, бүлээн цусаа урсган тулалдсан юм байна.

“Хөгжил гэж юу вэ?”, “Ялалт хямд үнээр ирдэг зүйл мөн үү?” “Хөгжих гэдэг нь өнгөрсөн түүхээ март гэсэн үг юм уу?”, “Тайван амгалан, аз жаргалтай амьдрал гэж юу вэ?” гэсэн асуултуудаас “Халхын голын дайнд оролцож явсан залуус, өнөөгийн залуусаас илүү хатуужилтай байсан ч байж магадгүй”, “Халхын голын дайны түүх нь залуу үеийнхэн бидэнд энх тайван амьдрал ямар их үнэ цэнтэй болохыг ухааруулж байна” гэсэн асуудлаас сонгох уу? Эсвэл өөрөө дээрх баримтуудыг ажиглаад, асуудлаа дэвшүүлэх үү? Халх голын дайны үйл явц ба үүнээс гарсан үр дагавар юу байсан тухай үзэл бодлоо илэрхийлнэ. Тохирох баримтыг нотолгоо болгон ашиглаад, дүгнэлт гаргаж болох юм байна.



Бичихдээ дараах бүтэц, төлөвлөгөөг баримтална.



БИЧИХ ДАРААЛАЛ



ТӨЛӨВЛӨХ

- ◆ Бичих зорилго, уншигчаа тодорхойлох
- ◆ Сэдвээ сонгож, хүрээ хязгаарыг нь тогтоох
- ◆ Сонгосон сэдвийг тоочимж, хүүрнэмж, тайлбарламжийн алинаар нь бичихийг сайтар бодох
- ◆ Бичих өнцөг, өнгө аяс, хандлагаа олох
- ◆ Мэдээлэл цуглуулах, ангилах, эрэмбэлэн цэгцлэх



- ◆ Юуны тухай бичих вэ?
- ◆ Ямар сэдвээр бичих гэж байна вэ?
- ◆ Бичих зүйлийн хэмжээ, зорилгоос ерөнхий сэдэв, дэд сэдэв ялгардаг.

Сэдэв нь: Ерөнхий, өргөн хүрээтэй.

Дэд сэдэв нь: Тодорхой, явцуу хязгаарлагдмал агуулгатай байдаг.

- ◆ Яагаад бичих гэж байна вэ?
- ◆ Хэнд зориулж бичих вэ?
- ◆ Ямар гол санааг илэрхийлэх вэ?

НООРОГЛОХ БА ЗАСВАРЛАХ

- ◆ Төлөвлөгөөгөө баримталж бичнэ. Өөр зүйл рүү анхаарлаа сарниулахыг тэвч.
- ◆ Цаасны хоёр талаар нэлээд зай үлдээж бичнэ. Хожим санаанд орсон зүйлээ тэр зайнд тэмдэглэнэ.
- ◆ Мөрийн хооронд зайтай бичнэ. Дараа нь янз бүрийн засвар хийхэд тохиромжтой байдаг.
- ◆ Гаргацтай, эмх цэгцтэй бичнэ.


Ингээд эхний нооргийг бич. Анхны нооргийг бичээд, төлөвлөгөөтэй харьцуулж, дахин унш. Тэгээд засварлана. Хэрэв компьютерээр бичсэн бол хэвлээд уншаарай.



ХЯНАЛТ БА ЭЦСИЙН ХУВИЛБАР

Дахин нэг хяна. Яарч болохгүй. Догол мөр, үг үсэг, найруулгын алдааг шалга. Засварыг хаана, хэрхэн оруулснаа өмнөх ноорогтой тулгаж, дахин нэг хяна. Анхны нооргийг хуулж бичихдээ үг үсэг гээсэн байж болзошгүй тул нягт нямбай ажиллаарай. Ер нь анхнаасаа л гаргацтай, эмх цэгцтэй бичиж сурах нь чухал юм.

Бичихдээ дараах шалгуурыг баримтална.



Сурагч Батын бичсэн эхэд дэвшүүлсэн асуудал, баримтаас үүдсэн үзэл бодол, таамаглал, цаашид хэрэгжүүлэх санаа, үнэлэлт дүгнэлт бүгд багтаж байгаа эсэхийг ажиглаж ярилцаарай.

Хөгжил гэж ер нь юу юм бэ? Би хөгжлийг ихэнхдээ, өндөр хурдны интернэт, ухаалаг гар утас, өндөр өндөр шилэн барилга гэх мэт эд зүйлсийн хөгжлөөр төсөөлдөг байв. Гэтэл, хөгжлийг бид эд хөрөнгөөр хэмжиж болохгүй нь бололтой. Дайнд оролцож явсан, ахмад дайчин Б.Лааган гуайн “Бөмбөгөнд олон хүн амь үрэгдсэн дээ. Үхсэнийг нь нэг тийш, амьдыг нь нэг тийш болгож байлаа. Үнэндээ, хэдэн хүн үхэв гэж тоолох хүн ч байгаагүй ээ. Өлсөж үхнэ, өвчнөөр үхнэ, ядарч үхнэ...” хэмээн өгүүлснийг уншаад, өнөөдрийн бидний аз жаргалыг дайны гал, дарийн утаан дунд цусаа асгаруулж, хөлсөө дуслуулан байж авчирсан ахмад дайчдаа мартаж болохгүйг ухаарлаа.

“Халх голын хөвөөнд ерэн баатар төржээ.

Халх голын хөрсөнд ерэн баатар нойрсжээ.

Хан тэнгэрт цоройж, ерэн хөшөө гэрэлтжээ.

Хөшөө тийш очих ардын зам баларсангүй.

Хөсрийн өвс ургааж, аглагшиж ер битүүрсэнгүй...” хэмээн яруу найрагч, ардын уран зохиолч Ш.Сүрэнжав гуайн шүлэглэсэн нь жинхэнэ баатруудын гавьяаг зүрх сэтгэлээрээ мэдэрсэн найрагчийн чин зүрхний үг юм. Жил бүр ялалтын баяр тэмдэглэдэг. Миний бодлоор, энэ баяраар хойч залуу үедээ дайн ямар хор уршигтайг ойлгуулах ажил хийж, энх тайван амьдралыг амиараа сольж авчирсан ахмад үеийнхний алдар гавьяаг сурталчлах хэрэгтэй юм байна. Эх түүхээ мэдэхгүй, эх орон минь ямар их үнээр үр хойч бидэндээ ирснийг оюун ухаандаа шингээж ойлгохгүйгээр зөвхөн эд хөрөнгийг шүтсэнээр жинхэнэ өндөр хөгжилтэй орон болж чадахгүй ч байж болох юм байна.



1 дүгээр биеэс өгүүлснийг 3 дугаар биеэс өгүүлснээр хувиргаж, өөрийн үгээр хурааж бичихдээ учир шалтгааныг таамаглаж тайлбарлана уу. Өөр цаг үед холбогдох эхийн үгийн санг хэрхэн ойлгох вэ?

- ◆ Эхийгуншихдаа, утгыгнь тайлбарласан доорх үгсийг анхаарч ажиглаарай.
- ◆ Сэтгүүлчийн асуултад хариулсан хэсгийг “Чацарганы хаан Лааган” гэсэн гарчгийн дор “Сонирхлоо дагавал амжилтад хүрэх үү?” гэсэн асуултаас асуудал дэвшүүлж, түүнийгээ эхэд байгаа баримтаар нотолж, үзэл бодлоо илэрхийлж бичихдээ 1 дүгээр биеэс өгүүлснийг 3 дугаар биеэс өгүүлж байгаагаар хувиргаж бичнэ үү. Бичихдээ шалтгаан, үрийн холбоотой, таамаглал дэвшүүлсэн утгат өгүүлбэр аль болох олныг ашиглахыг хичээгээрэй.

1 дүгээр биеэс “Би” хэмээн өгүүлснийг 3 дугаар биеэс “Тэр” болгож бичвэл өгүүлэгч нь чи өөрөө болно. Өгүүлбэрийн өгүүлэхүүн болон бусад гишүүд хувирна. Үлгэрлэвэл: “Би 1947 он хүртэл хороондоо алба хааж байгаад, өөрийн хүсэлтээр халагдсан” гэдгийг “Тэрээр 1947 он хүртэл хороондоо алба хааж байгаад, өөрийн хүсэлтээр халагдсан байна” гэх мэтээр хувиргаж бичнэ.

Асуулт: Дайн дуусахад 24 настай залуу эрийн өмнө энх тайван, амар амгалан амьдрал алгаа дэлгэн угтсан байх?

Хариулт: 1947 он хүртэл хороондоо алба хааж байгаад, өөрийн хүсэлтээр халагдаж, Намын дээд сургуульд* суралцсан. 1950 онд төгсөөд аймгийн намын хорооны хоёрдугаар нарийн бичгийн даргаар* томилогдсон. Удалгүй нэгдүгээр нарийн бичгийн дарга* бол гэхээр нь татгалзлаа. Учир нь би дэлхийн 2 дугаар дайны үед л чацаргана тарих мөрөөдөлтэй болчихсон байсан. ЗХУ* -д дайны үеэр дээ, нэг голын хөвөөнд чацаргана ургасан харагдана. Идсэн чинь үнэхээр сайхан амттай. Нутагтаа жирийн юм шиг санагдаж байсан жимсний амт харь газар дайны үед идээд үзэхэд үнэхээр өөр санагдаж байгаа юм. Ядарсан хүнийг сэргээдэг жимс бол чацаргана юм гэж тэгэхэд л ойлгож, ургуулах хүсэлтэй болсон. Ингээд Москвад К.А.Тимирязевийн нэрэмжит ХАА -н академид* явуулж өгөөч гэсэн хүсэлт гаргасан. Зөвшөөрсөнгүй. Би болохоор намын ажил хийснээс жимс жимсгэнэ таривал эх орондоо илүү хэрэгтэй гэж мэдээд байдаг. Дөрвөн удаа өргөдөл явуулж байж, нэг юм зөвшөөрүүлж дөнгөсөн. 1961 онд Жимс жимсгэнийн салбарын агрономич* диплом аваад төгсөж ирсэн. Увс аймагт ажиллаж байхдаа чацарганы гурван сорт* гаргаж, эрдмийн зэрэг хамгаалсан. Нэг шинэ сорт гаргахад доод тал нь арван жилийн хөдөлмөр. “Тэс”, “Улаангом”, “Чандмань” гурван сорт шинээр гаргаснаа үрээр суулгадаг болгож, Улаангомд 500 га-д чацарганы цэцэрлэг байгуулж, чацарганаар шарз, дарс, тос, ундаа хийдэг цех хүртэл байгуулсан.

* Намын дээд сургууль - одоогийн “Удирдлагын академи”

* нэгдүгээр нарийн бичгийн дарга, хоёрдугаар нарийн бичгийн дарга - аймаг, орон нутгийн засаг захиргааны нэг ба хоёрдугаар дэсийн удирдах албаны хүнийг ийнхүү нэрийддэг байв.

* ЗХУ - одоогийн ОХУ-ыг “Зөвлөлт Холбоот Улс” хэмээн нэрлэдэг байв.

* академи - дээд сургууль

* агрономич - газар тариалангийн мэргэжилтэн.

* сорт - ургамлын төрөл.



Асуулт: Таны чацаргана сансарт ниссэн гэж сонссон юм байна.

Хариулт: Тийм ээ. 1981 онд Ж.Гүррагчаа баатар сансарт нисэхдээ манай сортын чацарганаар шахмал хүнс, ундаа хийгээд авч явсан гэсэн. Дараа нь Ж. Гүррагчаа, В.А. Жанибеков хоёр манай аймагт зорин ирж, надтай уулзаж байлаа. Надад “Бид хоёр таны жимсийг сансрын уудамд идэж, ууж байлаа. Баярлалаа. Та ёстой “Чацарганы хаан Лааган” юм байна гэж хэлж байлаа.

Үгийн утгад ажиглалт хийх: Тайлбарласан үгсийн утгыг мэдээд, эхэд яагаад утгыг мэдэхгүй үг хэллэг олон байгаагийн учрыг тайлбарлана уу. Эдгээр үгийн орчин цагийн нэрлэлтийг олж мэднэ үү. Одоо үед нэрлэсэн юмс нь байна уу?



Өөрийгөө сорьё.

ТААМАГЛАЛ ДЭВШҮҮЛЭН ТАЙЛБАРЛАЯ сэдвийн хүрээнд юуг мэдэж, юуг чаддаг болсон бэ?

Тулгуур үгс:

- Эргэлзээ, тээнэгэлзэл, асуулт
- Асуулт – Зөв оновчтой таамаглал
- Дэвшүүлсэн асуудал
- Таамаглалаа баримт жишээгээр нотлох, үгүйсгэх
- Үзэл бодлоо илэрхийлэх
- Таамаглах, батлах, үгүйсгэх өгүүлбэр
- Үр дүн, дүгнэлт



Дараах эхийг уншаад, доорх сорилго асуултад хариулна уу.

Дараах гурван зүйлд ижил төстэй шинж байна уу? Ажигласны дараа эхийг уншаарай.



Ямаан бүрээ: Далайн ямар нэгэн зүйл амьтны яс, дотроо хөндий, гадна тал нь арзгар, үлээвэл орхирч дуугарна.



... “Ямаан бүрээ” гэсэн адилтгалд бүрээ үлээхэд гарах дуу чимээ, ямаа орилоход гарах дуу чимээ хоёрыг холбохдоо “гэнэт ян хийн, яхир, нарийн сонсогдох” зөвхөн тэр шинжийг л онцолсон бололтой. Түүнээс биш ямаа бол бод мал биш, бог мал болохоор “хонин бүрээ” гэсэн ч болох юм гэж санахын ч хэрэггүй. Өөрөөр хэлбэл, ямаа хонь хоёр хоёулаа майлдаг боловч, ямаа бол “муухай орилдог”, хонь бол ингэж “муухай орилдоггүй” гэдэг танил ойлголт л “ямаан бүрээ” гэж байхаас биш, “хонин бүрээ” гэсэн адилтгал байх боломжгүй болгочихдог шиг байна. Монголд саяхнаас троллейбус гэдэг нэг зүйлийн унаа хэрэглэгдэх болсны дараахан түүнийг хүүхэд, залуучууд “ямаан тэрэг” гэж нэрийдсэн нь хэдийгээр хошигносон, ёжилсон аястай ч гэсэн санаандгүй үүссэн адилтгал биш юм. Дээр дүүжилсэн цахилгааны утсанд авалцаж, троллейбусыг хөдөлгөдөг, орой дээврээс нь арагш налсхийн гарсан хоёр багананцар, үнэндээ, ямааны эврийг санагдуулам байсан нь ийм дүрслэн адилтгахын бодит шалтаг шалтгаан болсон хэрэг биз ээ. Энэ бол ямааны эврийн дүрс хэлбэрийг л онцолж, адилтгалын махбодыг шингээсэн гэж үзэлтэй байна.


Гэтэл “ямаан омог” гэхлээр “ялихгүй юманд гэнэт дүрсхийн омогшивч, мөдхөн тэрхэн зуураа намждаг омог” (ааш араншин) – ийг тодорхойлон адилтгасан нэрлэлт юм. Ийн адилтгасны учрыг нягталбал, монгол хүний сэтгэлгээгээр “ямаа бол хонийг бодоход янгууч, тэсвэр тэвчээр муутай амьтан” гэж ойлгож ухаарсан төдийгүй, бас түүний нь “таашаахгүй” байдаг үнэлэмжтэй цаагуураа холбоотой байна уу гэлтэй...

(Ж.Баянсан)

№	Асуулт даалгавар	Зөв хариултыг дэвтэртээ бичнэ.	ОНО
1	Таамаглал дэвшүүлэхийн тулд олж ажигласан зүйл нь юу вэ?		2
2	Таамаглал дэвшүүлсэн өгүүлбэрүүдийг олж тэмдэглэнэ үү.		2
3	Таамаглах ба үгүйсгэх утгат баймж үг, бүтээврийг олж бичнэ үү.		3
4	Таамаглахдаа юу юуг, хэдэн талаас нь ажиглав? Оюуны зураглал хийгээрэй.		3
5	Таамаглал дэвшүүлэхдээ юуг юутай харьцуулсан бэ?		2
6	Эхийн гол санааг өөрийн үгээр тодорхойлно уу.		3
7	Таамаглалаа баталж нотолсон өгүүлбэрийн жишээг олно уу.		2
8	Үгүйсгэсэн утгатай өгүүлбэрийн жишээг олно уу.		2
9	Дараах өгүүлбэр ба үгсэд байгаа цэг цэглэлийг нэрлэж, ямар үүрэгтэйг товч бичнэ үү. - “гэнэт ян хийн, яхир, нарийн сонсогдох” - “хонин бүрээ” - “ямаан омог” - (ааш араншин)		4
10	Дүгнэлт өгүүлбэрийг олно уу.		2
11	Эхийг дуурайлган “Үхрийн нүд” “Үхэр чулуу” гэсэн нийлмэл үгийн утгыг ажиглан ярилцаж, таамаглал дэвшүүлж бичнэ үү.		5

4

УЧИР ШАЛТГААНЫГ ТАЙЛБАРЛАЯ



Эзэмших мэдлэг, чадвар

- ◆ Шалтгаан, үр дагаврын холбоо хамаарал, баримт ба үзэл бодлыг задлан шинжилье.
- ◆ Нийлмэл өгүүлбэрийг холбон найруулах аргад суралцъя.
- ◆ Асуудал дэвшүүлэн, үзэл бодлоо илэрхийлэхдээ шалтгаан, үр дагаврын холбоог үндэслэл нотолгоотой гаргая.

Шалтгаан, үр дагаврын холбоо хамаарал, баримт, үзэл бодлыг задлан шинжилье.

- ◆ Шалтгаан, үр дагаврын холбоог ялган таних
- ◆ Шалтгаан, үр дагаврын холбоо бүхий эхийг задлан тайлбарлах
- ◆ Зохиогч санаагаа илэрхийлсэн аргыг судалж унших

I



Яагаад

Өдөр яагаад од харагддаггүй юм бэ?
Өвөө надад хэлээд өгөөч.
Эрдэм сурах яагаад хэрэгтэй юм бэ?
Ээж ээ, надад хэлээд өгөөч.
Яагаад өдөр шөнө болдог юм бэ?
Яриад өгөөч надад, эмээ
Яагаад гэсэн хүүхдийн асуултыг
Яршигтай юм гэж бүү бодоорой.
“Яагаад”-аас хүүхдийн танин мэдэхүй
эхэлдэг болохоор
Яг үнэнээр нь хариулахыг хичээгээрэй.
Ямар учиртайг нь тайлбарлаад өгөөрэй.
Хүүхэд, “яагаад” гэсэн асуултаараа
Хорвоотой танилцаж байгаа нь тэр буй.
(Г.Дагва)

Тийм ээ, ертөнц яаж бий болсон, навч яагаад унадаг, яагаад цунами болдог, яагаад газар хөдөлж, галт уул дэлбэрдэг, яагаад ус, амьтан, ургамал үгүй болдог, цонх цантахаараа яагаад цасан хээтэй байдаг, ямар учраас сарны ганцхан тал нь харагддаг вэ, яагаад манан татдаг вэ, тэнгэр яагаад хөх байдаг, од яагаад өдөр харагддаггүй, нар сар яагаад хиртдэг, далайн ус яагаад давстай байдаг, яагаад ном унших ёстой юм бол, сайн муу хоёр яагаад хамт байдаг, бүх гараг эрхэс яагаад бөөрөнхий харагддаг вэ, яагаад, яагаад, яагаад?....


Ертөнцийн юмс үзэгдэл бүхэнд үүсэх, орших, мөхөж байх үйл явц мөнхийн үргэлжилнэ. Өөрөөр хэлбэл, үүсэх шалтгаан-түүний үр дагавар, оршихын шалтгаан-түүний үр дагавар, мөхөхийн шалтгаан-түүний үр дагавар нь салшгүй холбоотой ойлголт ажээ. Тиймээс байгаль, нийгмийн үзэгдэл юмсын уялдаа холбоо, учир шалтгааныг тайлж мэдэхийн тулд ЯАГААД? гэсэн түмэн асуулт гарч ирдэг.

“Шалтгаан учир гэгчид нэг л зүйл зайлшгүй. Түүнд үр дагавар байх ёстой” гэж гүн ухаантан Д.Юм хэлжээ.



1

Тайлбарласан эхийг ажиглая.



Навч яагаад унадаг вэ?



Намар нарны илч буурч, хүйтэн сэрүүн болоход навчийг нь ногоон өнгөтэй болгодог

мөхлөг задардаг.

Навчны эсийн дотор улаан шар өнгөтэй будагч бодис үлдсэнээс навч улайх, шарлах зэргээр хувирна.

Хүйтрэхэд ургамал хөрснөөс авах ус нь багасна. Түүнчлэн навч хөгширдөг.

Энэ үед навчны эсэд ургамлын амьдралд хэрэггүй эрдэс давс их хэмжээгээр хуримтлагдсанаас навч унадаг.

(Д.Базаррагчаа)

Шалтгаан - намар

- ◆ Нарны илч буурна.
- ◆ Хүйтэн сэрүүн болно.

Үйл явц

- ◆ Мөхлөг задарна.
- ◆ Навч улайна.
- ◆ Навч шарлана.
- ◆ Навч хөгширнө.
- ◆ Эрдэс давс хуримтлагдана.

Үр дагавар – Навч унадаг.

Шалтгаан ба үр дагавар



2

Шалтгаан, үр дагаврын холбоог таних дадлага хийе.

а. Өөртөө байгаа мэдээллээ ашиглаж, дараах асуултад хариулт бичээрэй. Чиний хариулт шалтгаан, үрийн аль нь байх вэ?




Чихэвчээр хөгжим сонсохыг аав ээж, багш нар яагаад хориглоод байгаа юм бол?

◆ Зам хөндлөн гарах үед машины дохио сонсохгүй, аюултай шүү дээ.

◆
◆



Ой хээр аялал зугаалгаар явахдаа ундааны шил, лааз зэргийг хаяж орхихгүй байхыг “Онцгой Байдлын Ерөнхий Газар” -аас анхаарууллаа. Байгальд шингэдэггүй гэдгийг ч мэднэ, Гэтэл гал түймэр гарах шалтгааны нэг болдог гэж байна. Яагаад?




◆
◆

б. Аль загвар нь өгүүлбэрийн бүтцэд тохирч байна вэ?

Архи нь бат үгсийг задруулдаг, бардам дээрэнгүйг төрүүлдэг, чухал үгсийг цуцалдаг, цуглагсдыг тэмцүүлдэг, оюун билгийг мартуулдаг, олсон зөөснийг баруулдаг, бэх зөвлөлийг сарниулдаг, бие махбодыг доройтуулдаг идээ мөний тул урьдаас сэргийлэн айж цээрлэвэл зохимуй.

(Ч.Бат-Очир, “Мандах нарны туяа” сургаалаас)


Загвар 1



Загвар 2



Загвар 3





Юунаас ямар үр дагавар гарсныг уншиж ойлгоё.

Эхийг уншихын өмнө: “Худгийн инженер устах аюулд хүрлээ” гэсэн өгүүлбэр ямар утга санаатай байж болох вэ? Таамаглал дэвшүүлж, байж болох хувилбарыг гаргана уу. Одоо эхийг анхааралтай уншаарай.

Говийн худгийн инженер устах аюулд хүрлээ.

Говийнхон бэлчээр сүйтгэдэг гээд хуланг адлах нь бий. Байгаль дээр илүү үйл байдаггүй хойно хуланд сайн чанар бий байх. Орчны өвс ургамлыг үндсээр нь иддэг гээд малчид хуланг адалдаг. Гэтэл муу хэлүүлээд байгаа хулан нь тэдний алдуул малыг усалж, цангаж үхэх аюулаас авардаг. Хулан бол говийн инженер юм.

Энэ амьтан газар доорх усны түвшин гадаргууд хаана ойрхон байгааг гайхалтай мэдэрч, хурц туурайгаараа цавчиж, ус гаргана. Энэ бол хулангийн худаг. Эл усаар махчин шувууд, үнэг чоно гээд говийн амьтад болон алдуул мал ундаалдаг. Товчхондоо бусдыг ундаалагч гайхалтай амьтан. Түүнчлэн говьд ургадаг шүүслэг, хортой баглуур хэмээх ургамал бий. Энэ ургамлаар ганцхан хулан хооллодог. Тэгэхлээр хулан тэгж адлуулахаар хэрэггүй амьтан биш байгаа биз.



Хулан бол адууны өвөгт багтдаг зэрлэг илжиг. Манайхаас гадна Африкийн Саванна, Туркмен, Афганистан, Иран, Пакистан зэрэг улсад цөөн тоогоор байдаг. Дэлхий дээрх нийт хулангийн 70 орчим хувь нь манайд байдаг. Тиймээс Монгол бол дэлхийн хувьд хулангийн цөм нутаг юм...Хулангийн хамгийн чухал идээшил нутагт нь Монголын байгалийн баялгийн үүц задарсан. Нэг ёсондоо хувь тавилангийн хувьд азгүй амьтан юм л даа. Хулангийн нутагладаг газар дэд бүтэц



ихээр хөгжиж байна. 2000-аад оны эхэн үед Дорноговийн Хатанбулаг, Хөвсгөл сум, Өмнөговийн Номгон сум, Борзонгийн говь, Зурамтай уул, Ноён сум зэрэг газар хулангийн сүрэг байсан ч өнөөдөр үзэгдэхээ больсон. Энэ нь нэг талаасаа хатуу хучилттай зам, цахилгаан дамжуулах шугам, ус татах хоолой зэрэг бүтээн байгуулалт нь хулангийн чөлөөтэй шилжиж, бэлчээр усаа сонгох хөдөлгөөнийг нь хязгаарласан, нөгөө талаас уул уурхай дэд бүтэц хөгжсөн газруудад хүний суурьшил эрс нэмэгдсэн. Өмнөговийн Цогтцэций сум гэхэд 3000 орчим хүн амтай байснаа хэдхэн жилийн дотор 10 гаруй мянга болтлоо өссөн. Хүний суурьшил нэмэгдсэнээр хууль бус ан ихэссэн. Мөн уур амьсгалын өөрчлөлтөөс хамааран говийн задгай ус хомсдож, булаг шанд нь ширгэж, ургамлын гарц муудсан. Энэ мэт хавсарсан шалтгаан хулангийн тоо толгойд нөлөөлж байна.

Хулангийн сүргийн чөлөөтэй шилжих хөдөлгөөнийг нь зам тавиад хуваачихаар биологийн хувьд маш сөрөг үр дагавартай. Амьтад үржлээр дамжуулж, генийн олон янз байдал, амьдрах чадвараа хадгалж, эрүүл үр удам үлдээдэг. Гэтэл бүтээн байгуулалтаар үржилд орох боломжийг нь хязгаарлачихаар генетикийн олон янзын хомсдолд орж байна гэсэн үг. Энэ үйл явц удаан үргэлжилснээр аажимдаа хоорондоо үржилд орж, орчны нөхцөлийг даван туулах чадвар, мэнд үлдэх чадвар, үр төл үлдээх байдал нь муудна. Хулан агнахыг хориглож болно. Гэтэл генетикийн хомсдолоос шалтгаалан, энэ амьтан аажимдаа биологийнхоо үйл явцаар эрс цөөрч, устгах аюултай. ...

Улаан номд орсон амьтнаа хамгаалах чиглэлээр манайх ажил хийж байгаа гэхэд хэцүү. Төрийн зүгээс хулангийн идээшил газруудыг тусгай хамгаалалтад авсан явдал нь энэ чиглэлээр хийсэн ганц ажил нь. ... Ер нь хууль бус агнууртай тэмцэх ажил чамлалттай байгаа.

Монголд 20 мянга орчим хулан байна. Тэгвэл Дундговийн Эрдэнэдалай сум саяхан 20000 адууны баяр хийсэн. Нэг сум гэдэг чинь жижигхэн газар. Нэг сумын адууны тоотой тэнцүү хулан улсын хэмжээнд байна гэсэн үг. Хэрэв өнөөдөр хамгаалах арга хэмжээ авахгүй, энэ янзаараа байвал хулан маргааш гэхэд байхгүй болно. Дэд бүтэц, эдийн засгийн хөгжил хүнд хэрэгтэй ч бид байгалийг бодож хөгжих ёстой.

Хулан гэдэг гайхалтай амьтан.

(Д.Дайрийжав)

Зөв бичье:

- ♦ “хулан” гэсэн үгэнд -ийн, -аас, -аар бүтээврийг залгахад авианы ямар хувирал болох вэ?
- ♦ “цөөрч” гэсэн үгийн язгуурыг олоод, авианы ямар хувирал гарсныг хэлнэ үү.
- ♦ “ургамлын” гэсэн үгэнд эгшиг авиаг хураасан байна. Учрыг хэлнэ үү.
- ♦ “мянга” гэсэн үгийн “я” авианы үүрэг аль нь вэ?

а. эгшигжүүлэх

б. зөөлрүүлэх

в. ялгах

- ♦ “ан, агнах, агнуур” гэсэн үг нэг язгууртай төрөл үг мөн үү.
- ♦ “10 гаруй мянга, 20 мянга орчим” гэсэн тооны нэрд ямар ялгаа ба ижил зүйл байна вэ?



Уншсаны дараа

- Таамаглал чинь зөв байсан уу? Яагаад?
- Баг болж, нэг нэг цогцолборыг сонгож, даалгаврыг гүйцэтгээрэй.

Үлгэрлэвэл:

Говийнхон бэлчээр сүйтгэдэг гээд хуланг адлах нь бий. Байгаль дээр илүү үйл байдаггүй хойно хуланд сайн чанар бий байх. Орчны өвс ургамлыг үндсээр нь иддэг гээд малчид хуланг адалдаг. Гэтэл муу хэлүүлээд байгаа хулан нь тэдний алдуул малыг усалж, цангаж үхэх аюулаас авардаг. Хулан бол говийн инженер юм.

Шалтгаан нь:

Орчны өвс ургамлыг үндсээр нь идэж, говийн бэлчээр сүйтгэдэг.

Үр нь: Малчид хуланг адалдаг.

Өгүүлэгчийн үзэл бодол, дүгнэлт:

Гэтэл муу хэлүүлээд байгаа хулан нь тэдний алдуул малыг усалж, цангаж үхэх аюулаас авардаг. Хулан бол говийн инженер юм.

Гол санаа нь:

Хулан ашигтай амьтан юм!

1-р баг:

“Хулан тэгж адлуулахаар хэрэггүй амьтан биш” гэж хэлсний учрыг бичээрэй.

-
-
-
-

Энэ амьтан газар доорх усны түвшин гадаргууд хаана ойрхон байгааг гайхалтай мэдэрч, хурц туурайгаараа цавчиж, ус гаргана. Энэ бол хулангийн худаг. Эл усаар махчин шувууд, үнэг чоно гээд говийн амьтад болон алдуул мал ундаалдаг. Товчхондоо, бусдыг ундаалагч гайхалтай амьтан. Түүнчлэн говьд ургадаг шүүслэг, хортой баглуур хэмээх ургамал бий. Энэ ургамлаар ганцхан хулан хооллодог. Тэгэхлээр хулан тэгж адлуулахаар хэрэггүй амьтан биш байгаа биз.

2-р баг:

Үр нь: 3-р догол мөрд “Энэ мэт хавсарсан шалтгаан хулангийн тоо толгойд нөлөөлж байна.” гэжээ. Эдгээр шалтгааныг тоочин бичнэ үү.

-
-
-
-
-

3-р баг

4-р догол мөрийн, хулан биологийнхоо үйл явцаар цөөрч, устгах аюултай гэдэг таамаглалд хүргэсэн мэдээллээс дараах загварт тохирох жишээг бичнэ үү.



4-р баг

“Хулан гэдэг гайхалтай амьтан” гэсэн зохиогчийн үнэлэмжийг батлах үг хэллэгийг ялгаж бичнэ үү..

Даалгавраа нэгтгэж, СОНС-НЭГТГЭ-ДҮГНЭ аргаар хэлэлцүүлэг хийе.

- Сонс:** Багуудын хийсэн даалгавар, үр дүнг анхааралтай сонсоно.
- Нэгтгэ:** Багууд хийсэн даалгавраа бусадтай харьцуулаад, “Говийн худгийн инженер устгах аюулд хүрлээ” гэсэн санаанд нэгтгэнэ.
- Дүгнэ:** Баримт ба учир шалтгаан-үрийн харьцаанаас зохиогчийн дэвшүүлсэн асуудлыг олно.

Гэртээ: Дараах хураангуй мэдээ нь үр дүнг өгүүлжээ. Тэгвэл шалтгааныг нь бичнэ үү.

Үлгэрлэвэл:

“Тамхины ишгүй Улаанбаатар” хөдөлгөөн өрнүүлж эхэллээ.

Шалтгаан нь: - Өнөөдөр нийт хүн амын 27.1% нь тамхи татдаг.
- Уушгины хавдрын 90% нь тамхинаас үүдэлтэй.

- Бартаат замын уралдааны орлогыг мазаалай хамгаалахад зарцуулна.
- Зөвшөөрөлгүй уурхайнуудаас болж Налайх дүүрэгт гэр хорооллын айлын газарт цууралт үүсжээ.
- Хөрсний бохирдлыг бууруулах төслийг Баянзүрх, Чингэлтэй дүүрэгт эхлүүлнэ.
- Мазаалай баавгайг хамгаалах, олон улсад сурталчлахын тулд Монгол банк нийгмийн хариуцлагынхаа хүрээнд “Мазаалай” нэртэй мөнгөн зоос цутгуулж, олон улсын цуглуулагчдад санал болголоо. Уг зоосыг 999-ийн сорьц бүхий цэвэр мөнгөөр 38.61 мм-ийн диаметртай цутгасан ажээ.



4

Эхийг уншиж, задлан тайлбарлая.

- а. Эхийн гарчгийг уншаад, юуны тухай болохыг төсөөлж байна уу? Байж болох хувилбарыг жагсаан бичээрэй.
- б. Одоо эхийг анхааралтай уншиж, даалгаврыг хийнэ үү.

Ус урсахыг харахаас гол харлана.

.... Ус бараадах, бүр их ус бараадах амьдрал одоо ч эрхэм асуудал хэвээрээ байдаг. Өнөөдөр хүмүүсийг түгшээж буй айдсын тэргүүн эгнээнд усны хомсдол гээч асуудал явж байна. Дэлхий дээрх хуурайшил, ган, зуд, цөлжилтийн цаад нууц ноён тун ялдамхан мяралзан цэлэлзэх нь аймшгийн киноны гол баатрыг санагдуулна.

Усны эхэнд суугаад, голын урсгалыг ажиглаж байхад мөнхийн хөдөлгүүр гэгчээр өдөржин шөнөжин, өвөлжин зунжин шоржигноно. Ус мөрөн байнга л ийм байх юм шиг хэн хүнгүй боддог байлаа. Дуулдаг байлаа. Шүлэг бичлээ. Тэгээд одоо хартал дуу шүлэгт орсон гол ус маань урсаад дуусчихжээ. Улаан цутгалангийн хүрхрээ гэхэд *уйлах нулимс нь* хүртэл ширгэж, тоос манарна. Ус газрын өөд урсахгүйгээс хойш манай орны нутаг дэвсгэр дээр удаан тогтох үндэслэл байхгүй. Одоо улам ширгэж *хатангиршаад* байгаа үлдсэн хэдэн гол маань урсаад дуусчих юм биш байгаа гэж бодохоос дотор муухайрч, *гол харлаад байх юм*.

Хойд ба Номхон далайд дусал нэмэр болж мөрөн гол минь очдог.

Хариуд нь тэндээс *тэвэр үүл* ч нүүж ирэхээ больчихлоо. Өөрөөр хэлбэл, манай экспортын гарз нээгдээстэй, импортын орлого хаагдаастай....

Туул голын усыг нэмэгдүүлэх ямар ч боломж байхгүй. Уул овоо тахих нь өөрийнхөө сэтгэлийг хуурч байгаа болохоос лус савдагт тэр *авлига* очдоггүй юм.

Төв Азийн өндөрлөг бүс дэх чийг нь явуулын олз омгон дээр тулгуурладаг. Хаа нэгтэйгээс ирсэн тэнэмэл үүлийг Хордил Сарьдагийн орой дороос нь ярж, бороо цасыг нь сулладаг. Үүлнээс буусан хур уулын жалгаар уруудан, томогдон сүлжигдэхийг бид гол горхи ... хэмээдэг.



Устайгаа ширгэсэн амьдрал





Монгол дахь голууд дотроос ганцхан Эгийн гол л Хөвсгөл гэдэг далай ээжийгээ хөхдөг. Бусад нь бүгд уежны хүүхдүүд. Тийм байгаа биз дээ. Угж алга болмогц Бадын гол, Цэнхэрийн гол, Тогосын гол гэсэн нэрс нь хоосон жалган дээр тавьсан гүүрний хаяг болчихсон.

Байдал улам таагүй тал руугаа явж байгаа нэг аюул бол гол мөрний ус нэмэгдэж мэдэхээр байна. Мухар олгой гэдсэндээ хагараад өвдөхөө больчихлоо гэдэг шиг өндөр уулын нуур цөөрөм эрэг саваа дүүргэн халих гэж байна. Энэ бол гадаргын ус нь шавхарч дуусаад эцсийн араандаа орж, гүнд байдаг мөнх цэвдэг хайлж буйн шинж. Мөнх цэвдэг хайлаад дуусчихвал манай орны нутаг дэвсгэр Сахарын цөлөрхүү болох төрхөндөө эргэлт буцалтгүй явна. Дахиад мөнх цэвдэг болон гүний ус хуримтлагдан бий болохыг хүний хэд хэдэн үе үзэхээргүй их хугацаа, хүлээлт юм даа.

Тэгэхээр ус голоо хамгаалах нь эх орноо дайснаас хамгаалахаас илүү чухал асуудал болчхоод байна. Эх орноо хамгаалахын тулд зарцуулсан сүүлчийн дусал цусны найрлагын 99 хувь нь ус л байдаг шүү дээ.

Энэ жил улсын тэргүүний тариаланч цол авсан Баянхонгор аймгийн Бууцагаан хэмээх говийн сумын ногоочин Д.Батгэрэлийнд тэр жил очиж билээ. Тэднийх их олон жилийн өмнөөс л тариа ногоо эрхэлдэг айл байсан. Сар шинийн өмнө тэргүүний тариаланч болсныг дуулаад нүдээ олсон шагнал болж гэж бодож байв. Энэ айлын байшингийн дээврүүд нь хавтгай өргөн талбайтай, тэгээд цорготой, цорго нь явсаар байгаад том усан санд холбоостой байсан сан. Говь хээрт хаа нэгтэй галзуу юм шиг ордог хурын усыг тэднийх ийн тосож аваад, хожим бага багаар нь талбайдаа цацаж ургацаа ургуулдаг юм билээ. Хэдхэн байшингийн дээврээс авсан ус дараагийн бороог иртэл элбэг хүрдэг тухай ярьж байсан.

Ноднин Алтайн цаад говь дахь Эхийн голд явж байлаа. Эргэн тойрон ус байтугай үүл заяалгүй арван хэдэн жил болчихдог цөлийн ангамал хөрсөнд томоо гэгчийн сайхан нуур цэлэлзэж байх юм. Нуурыг тойроод ой шугуй найган ганхаж, өвс халиуран, тариа ногоо тарьжээ. Үдэш нь тэнгэр бүрхэж, удалгүй шиврээ бороо намиран, солонго татна. Эхийн голоос гараад нэг километр явахад хязгааргүй хайрган цөл үргэлжилнэ. Эндхийн нуур яагаад говийн агроу хуурай дээр ширгэхгүй байгаад байдаг юм бол гэж асуутал тэд хонхор газар гялгар цаас дэвсчихсэн юм билээ. Байгальд хог болоод байгаа гялгар ууттай адил нийлэг эд хямдхан бүтээгдэхүүн. Түүнийг нааж зүйсээр байгаад хонхрыг битүүлчихдэг юм байна. Тэгэхээр хонхрын ус доошоогоо үл ширгэх бөгөөд бороо цасны ус нэмэрлэн улам арвижна. Мал ороод цоолчихгүй бол хэдэн зуун жил гээгүй байгаа даа, мөд ялзардаггүй гэнэ шүү. Очоод, нуурын хөвөөний элсийг яраад үзтэл дор нь гялгар уут дэвсээтэй байв.

... Зарим газар ус нь ихдээд, заримд нь болохоор сох дутаагаад энэ тэнгэр хангай бүр уймарчихсан цаг үед бид амьдарч байна. Удтал хүлээсэн бороо нэг л өдөр палхийтэл орж, үер усны гамшиг тарьж өгөөд арилна. Бороо ирж л таараа. Ирсэн дээр нь дор бүрнээ хувин ч болтугай тосон авч үлдэх асуудал бол амьдралаас урган гарч буй проблем* болжээ.

Төр сүүлчийн мөнгөө шавхаж байж усан сан байгуулахгүй бол Монгол орон цангахаар болчихлоо. Хүмүүс яагаад үүнийг анзаарахгүй байна вэ? Хүмүүс тоомжиргүй байгаа болохоор төр засгийн анхаарал усан дээр төвлөрч өгөхгүй

* проблема – асуудал (орос хэлний үг)



5

Шалтгаан ба үр дагаврын хамаарлыг тогтооё.

- а. Аливаа асуудал үүсэх шалтгаан, шалтгаанаас үүдэлтэй үр дагавар байдаг. “Ус урсахыг харахаас гол харлана” эхээс шалтгаан, үр дагаврын холбоо хамаарлыг тогтооё. Зарим хэсгийг нөхөж гүйцээгээрэй. Үлгэрлэвэл:

Шалтгаан	Үр дагавар
... усны хомсдол	- Өнөөдөр хүмүүсийг түгшээж байна. - Хуурайшил, ган, зуд, цөлжилт
.....	хэдэн гол маань урсаад дуусчих юм биш байгаа
.....	... дотор муухайрч, гол харлаад байх юм.
Угж алга болмогц...
.....	... өндөр уулын нуур цөөрөм эрэг саваа дүүргэн халих гэж байна.
Мөнх цэвдэг хайлаад дуусчихвал...
.....	... ус голоо хамгаалах нь илүү чухал асуудал болчихоод байна.
.....	... улсын тэргүүний тариаланч цол авсан...
.....	Алтайн цаад говь дахь Эхийн голд Эргэн тойрон ус байтугай үүл заяалгүй арван хэдэн жил болчихдог цөлийн ангамал хөрсөнд томоо гэгчийн сайхан нуур цэлэлзэж байх юм.
Монгол орон цангахаар болчихлоо.
.....	Төр засгийн анхаарал усан дээр төвлөрч өгөхгүй байна.



б. Өмнөх даалгаврын үр дагаврыг доорх загварт ялгаж бүлэглээд, учрыг тайлбарлана уу.

←
ээрэг үр дүн
→

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

в. Зохиогч юуны учир дотор муухайрч, гол харлаад байна гэсэн бэ? Үүний шалтгааныг олж бичээрэй.

.....

.....

.....

- г. Эхэд онцолсон үг хэллэгээр уншигчдад юу мэдүүлэхийг зорьж байна вэ?
- д. Ус голоо хамгаалахын чухлыг зохиогч юутай зүйрлэв? “Эх орноо хамгаалахын тулд зарцуулсан сүүлчийн дусал цусны найрлагын 99 хувь нь ус л байдаг шүү дээ” гэдгээр зохиогч юу сануулж байна вэ?
- е. “Гол харлах” гэдэг өвөрмөц хэлцийг ойролцоо үг хэллэгээр солин найруулж бичээрэй.
- ё. Дараах даалгаварт эхээс жишээ олж бичээрэй.

<div style="border: 1px solid orange; border-radius: 10px; padding: 5px; display: inline-block;"> Зохиогчийн үзэл бодол </div>	<div style="border: 1px solid orange; border-radius: 10px; padding: 5px; display: inline-block;"> Баримт </div>	<div style="border: 1px solid orange; border-radius: 10px; padding: 5px; display: inline-block;"> Зохиогчийн үг хэллэг </div>
<p>.....</p> <p>.....</p> <p>.....</p>	<p>.....</p> <p>.....</p> <p>.....</p>	<p>.....</p> <p>.....</p> <p>.....</p>



Тайлбарлан бичих нь мэдээллийг ойлгуулах зорилгоор бичсэн бичвэр юм. Тайлбарлах юмс үзэгдэл, үйл явдлаас шалтгаалаад, тохирсон тайлбарлах аргыг хэрэглэнэ. Тайлбарласан эхэд өгүүлж буй зүйлийн ухагдахууныг маш тодорхой хүргэхийн тулд тодорхойлох, ангилах, задлан шинжлэх, харьцуулах, тоочих, учир шалтгаан, үр дагаврыг илрүүлэх зэрэг аргыг хэрэглэдэг.

Монгол давсны гайхамшиг

Эртний нууруудын булан тохойд үүсэж тунасан хуримтлалыг чулуун давс буюу жамц давс гэдэг. Жамц давс нь одоогоос 400 сая жилийн өмнө манай гарагт үүссэн гэж эрдэмтэд тогтоожээ. Манай орны баруун хязгаар Увс, Говь-Алтай, Ховд аймгийн нутагт л бий.



Шүдэн уул



Жамц давс

Увс аймгийн Шүдэн уулын жамц давс дэлхийн хуурай газар ургадаг цөөхөн давсны ордны нэг бөгөөд хэдэн сая жилийн өмнө тэнгисийн ёроолд ургасан гэж үздэг ба тэнгисийн ус газарт ширгэхэд хатуужин үлдсэн давсан уул юм. Давсны давхаргын зузаан 9-50 метр, нийт нөөц 73.2 сая тонн, янз бүрийн өвчин анагаах чадалтай, химийн болон үйлдвэрийн ямар ч найрлагагүй, байгалийн цэвэр бүтээгдэхүүн.

Жамц давсанд байдаг элементүүд нь хүний биед хэрэгтэй кальци, кали, хүхэр, натри, төмөр, иод зэрэг бодисыг агуулдаг.


Энэхүү давс чухам юугаараа гайхамшигтай юм бэ?

- ◆ Хүний дотоод эрхтэн цөсийг цэвэршүүлдэг.
- ◆ Шүд өвдөхөд зуувал өвчнийг түргэн намдаана.
- ◆ Элдэв яр шархыг хатааж эдгээдэг.
- ◆ Даралт ихсэхэд хөөрлийг нь дардаг.
- ◆ Жамц давсыг долооход хоолны шингэц сайжирна.
- ◆ Хоолой, буйл өвдөхөд өдөрт 3-аас доошгүй удаа тогтмол зайлна.
- ◆ Жамц давстай ваннтай усанд орвол таны биеийн арьс эрдэс баялгаар тэтгэгдэж, зөөлөн булбарай болохоос гадна биеийн био энерги тань идэвхжиж, ядаргаа тайлагдан, тайвширна.
- ◆ Үе мөч өвдөх болон гэмтлээс болж хавдаж, өвчин орсон үед жамц давстай өтгөн цайгаар жин тавьж, боож хоноход хаван бууж, өвчин намддаг.
- ◆ Хоолны хордлогын үед буцалсан бүлээн усанд чангахан найруулж 1 минутын зайтай хоолны жижиг халбагаар уух зэргээр олон өвчнийг илааршуулна.

(Интернэтээс авав)



- а. Эхийн өгүүлбэрүүд баталсан утгатай байна, яагаад?
- б. Юмс үзэгдлийн шалтгаан, үрийн хамаарлыг олж нэрлэнэ үү.
- в. Дараах өгүүлбэрүүдийг нэг өгүүлбэрт хураан найруулж бичнэ үү.
 - ♦ Жамц давс нь өвчин анагаах чадалтай.
 - ♦ Химийн болон үйлдвэрийн ямар ч найрлагагүй, байгалийн цэвэр бүтээгдэхүүн.
 - ♦ Жамц давсанд байдаг элементүүд нь хүний биед хэрэгтэй кальци, кали, хүхэр, натри, төмөр, иод хэмээх бодисыг агуулдаг.
- г. Дараах загварыг ажиглаарай. 4 өгүүлбэрийг утгаар нь ерөнхийгөөс тусгай руу нь дараалуулж, загварт тохируулъя гэвэл яаж байрлуулах вэ?.



1. Шүдэн уулын давсны давхаргын зузаан 9-50 метр, нийт нөөц 73.2 сая тонн.
2. Манай орны баруун хязгаар Увс, Говь-Алтай, Ховд аймгийн нутагт л бий.
3. Увс аймгийн Шүдэн уулын жамц давс.
4. Эртний нууруудын булан тохойд үүсэж тунасан хуримтлалыг чулуун давс буюу жамц давс гэдэг.

- ♦ “Бодол санаа тоон шинжтэй. Тоо бол хэлбэр болоод санааг захирагч юм” гэсэн И.Ньютоны санааг Э.Мулдашев “Бурхдын хотын эрэлд” (УБ,2010) номдоо

9999 км – дэлхийн хагас тойргийн хэмжээний тал нь буюу 90 градус

6666 км – дэлхийн хагас тойргийн гуравны нэг буюу 60 градус
(Кайлас уулаас хойд туйл хүртэлх зай)

4999 км – дэлхийн хагас тойргийн дарөвний нэг буюу 45 градус
(Пасхи арлаас Мексикийн пирамид хүртэлх зай)

3333 км – дэлхийн хагас тойргийн зургааны нэг буюу 30 градус
(Мексикийн пирамидаас Чөтгөрийн цамхаг хүртэлх зай)

1666 км – дэлхийн хагас тойргийн арван хоёрны нэг буюу 15 градус
(Чөтгөрийн цамхагаас АНУ дахь “6666” цэг хүртэлх зай)

гэж тооцоолсон

- а. Дээрх тоон мэдээллийг ерөнхийгөөс тусгай руу нь дараалуулж байрлуулахад ямар үг, хэллэгийг онцлох вэ?
- б. Дээрх мэдээлэл та нарын сонирхлыг татаж байна уу? Яагаад?



Асуудал

Ургамал ч гэсэн амьдрах эрхтэй. Ургамал бол амьд амьтан, экосистемийн оршихуйн үндэс юм.

Баримт, нотолгоо

- ◆ Монгол орны нэн ховор ургамлын 11% нь устаж болзошгүй, 3% нь эмзэг, 6% нь ховордож байгаа, 18% нь устаж байгааг “Монгол улсын хөгжлийн урт хугацааны бодлого” баримт бичигт дурджээ.
- ◆ Малын хэт өсөлт
- ◆ Ургамлын гаралтай бүтээгдэхүүн: Их тайга цай...
- ◆ Нэгэн эмийн компани Хөвсгөл аймгийн Улаан - Уул сумаас эмийн үйлдвэртээ Ванжингарав, Жавхаалаг башир зэрэг эмийн ховор ургамлыг хуурайгаар нь тус бүр тонныг бэлтгүүлж байжээ. Тухайн ургамлаас 10-15 тонныг нойтноор нь түүж байж, 2 тонн болно гэсэн үг шүү дээ.

Зохиогчийн үзэл

Нэг амьтан хөнөөхөд ямар хохиролтой байдаг шиг нэг цэцэг таслахад экологийн хувьд мөн тийм уршигтай. Ургамал олон төрлөөрөө байж гэмээ нь бэлчээрийн мал тарга хүч сайтай, ан амьтад унаган төрхөөрөө байна.

Тэгэхлээр ургамлын төрөл зүйлийг хайрлан хамгаалж байж л сая цэнгэг ус, цэвэр агаар, нарны орон болсон эх дэлхийгээ ногоон байлгаж, ан амьтдаа хамгаалж, өөрсдөө эрүүлжиж, үр хойчийнхоо өмнө нүүр бардам байх эрхтэй болно.

Миний дүгнэлт

Ямар шалтгаанаас үүдэлтэй, ямар үр дагаврууд гарч болох талаар бодлоо илэрхийлж бичээрэй.

.....

.....

.....

.....



Мэдээллийг уншиж, асуудал дэвшүүлэн ярилцъя.

а. Дараах мэдээллүүдийг сайтар анхаарч уншаарай.



Уур амьсгалын өөрчлөлт нь хүн амын шилжилт хөдөлгөөнийг эрчимжүүлж, улс хоорондын зөрчил, дайн тулаанд ч хүргэж болзошгүйг эрдэмтэд анхааруулах болжээ. (Сониноос)

б. Доорх загварт тохирох жишээг олж бичээрэй.

Баримт
Асуудал
Шалтгаан, үр
Үзэл бодол

в. “Дэлхийн дулаарал” сэдвээр ярилцаж, эх бичих төлөвлөгөө гаргана уу.



Нийлмэл өгүүлбэрийг холбон найруулах аргад суралцъя.

- ◆ Нийлмэл өгүүлбэр бүтээх аргыг мэдэх
- ◆ Өгүүлбэрийг шалтгаан, орон, цаг, зорилгын утгаар холбох аргатай танилцах
- ◆ Өгүүлбэрийг хувиргах, найруулах, бүтээх

Хэл зүй

Шалтгаан, орон, цаг, зорилгын утгат нийлмэл өгүүлбэрийг холбох аргыг мэдэх, хэрэглэх, хувиргах, бүтээх чадварт суралцъя.

А. ШАЛТГААНЫ УТГАТ НИЙЛМЭЛ ӨГҮҮЛБЭР:



I. Дараах өгүүлбэрээс шалтгааны утгат өгүүлбэрийг ялгаарай.

Үлгэрлэвэл:

Эх нь хээр алаг бол

Унага нь шийр алаг гэсэн хэлцийн “бол” хэмээх холбоос нь

дараагийн үйлийн болзол, шалтгааны утга илтгэж байгаа бөгөөд мал амьтны өнгө зүс, хэлбэр галбир, ааш аяг нь үр төлдөө удамшдагийг таньж мэдсэнээс үүдэж, хүний зан төрх нь эцэг эх, удам судраасаа шалтгаалдаг гэсэн гол утгыг илэрхийлж байна.

1. Эх нь булингартай бол адаг нь булингартай. (МАЗ)
2. Адуунд азаргагүй бол сүрэг болж чадахгүй. (МАЗ)
3. Бодончар мунхагийг бядуу гэж урагт үл тооцож, хувь эс өгөв. (МНТ)
4. Гэмгүй даруу зантайд нь
Гэр хүн хоёрт ойр байдагт нь
Гэрэлт цагаан тагтаанд хүн дуртай. (Д.С)

II. Шалтгааны утгат өгүүлбэрийн холбоосыг ойролцоо бүтээврээр солин найруулж, хувиргана уу. Ялгаа байгаа эсэхийг ажиглаарай.

Үлгэрлэвэл:

Үрийн сайнаар ургаж

Үндэсний муугаар ховхорлоо гэсэн өгүүлбэрийн “Үр нь

сайн. Үндэс нь муу” гэх хоёр өгүүлбэр нь ямар учраас?, яагаад? гэх асуултад хариулагдаж, гол өгүүлбэрийнхээ “ургаж, ховхорлоо” гэсэн хоёр үйл өгүүлэхүүнд захирагдсан шалтгааны утгат өгүүлбэр болжээ. Үүнийг

- Үр нь сайн **учраас** ургаж
Үндэс нь муу **учраас** ховхорлоо.
- Үр нь сайн **бол** ургаж
Үндэс муу **бол** ховхорно.
- Үр нь сайн **байвал** ургаж
Үндэс муу **байвал** ховхорно.

- Үр нь сайн **байснаас** ургаж
Үндэс муу **байснаас** ховхорно.
- Үрийн **сайнаас** ургаж
Үндэсний **муугаас** ховхорлоо.
гэх мэт ойролцоо утгат
бүтээврээр хувиргаж болно.



1. Балай их уувал өвчин биш үү
Балмад их согтвол галзуу биш үү
(“Чингисийн есөн өрлөгтэй өнчин хүүгийн сэцэлсэн шастир” зохиолоос)
 2. Нэгд, гэрийн газар гачигдалтай
Хоёрт, цэрэгт удаан жил суусан
Гуравт, цэргийн зовлон их тул
Долингор оргохоор шийдэв. (Ц.Д)
 3. Баячууд болоод эзэн хаад гүн ухаантнуудад хүндэтгэл үзүүлснээрээ өөртөө ч тэр,
тэдэнд ч нэр төр нэмдэг. Харин гүн ухаантнууд баячуудын өмнө бөхөлзсөнөөрөө
тэдэнд алдар хүнд нэмэхгүйн дээр өөрийнхөө нэр төрийг үгүй хийдэг. (Плутарх)
 4. Эх орноо гэх элэггүй хүн энэрэхүйн сурвалжид сэтгэл эс баригдсаны учир
юуг ч эс хайрлана (Д.У)
 5. Бурхандаа итгэсээр өвчинд баригдах
Бухандаа итгэсээр үнээгээ хусраах. (МАЗ)
- III. Дараах энгийн өгүүлбэрүүдийг –бал⁴, -вал⁴, учраас, тул, -аар⁴, - аас⁴, яагаад гэвэл, -хлаар⁴ зэрэг бүтээврээр холбож, шалтгаан, үрийн харьцаатай нийлмэл өгүүлбэр бүтээнэ үү.
Үлгэрлэвэл: **Усанд ирэх үед хар сүүлт орсон байна. Хавтгайнууд санаа зоволгүйгээр усаа уудаг** гэсэн өгүүлбэрийг –вал бүтээврээр холбож, нийлмэл бүтээе. Усанд ирэх үед хар сүүлт орсон байвал^{шалтгаан} хавтгайнууд санаа зоволгүйгээр усаа уудаг.
1. Хуванцар саванд химийн бодис агуулагддаг. Амьтны дотор эрхтэн, арьс үс болон хүний мэдрэлийн эсийг гэмтээдэг.
 2. Малын хөлд талхлагдана. Хөрс дагтаршина. Ургамал сийрэгжинэ.
 3. Үлийн цагаан оготно бидний дайсан биш ээ. Хөрсийг бэлчээрийн доройтолд оруулахгүй сийрэгжүүлнэ.
 4. Нуурын хөвөөнөө фосфоритын орд ашиглаж байна. Хөвсгөл нуур бохирдоно.

Б. ОРНЫ УТГАТ НИЙЛМЭЛ ӨГҮҮЛБЭР:



Эхний үйл явдал болсон орон зайд нөгөө үйл явдал болохыг заасан утгат өгүүлбэрийг **ОРНЫ УТГАТ НИЙЛМЭЛ ӨГҮҮЛБЭР** гэнэ. Жишээлбэл:



I. **Би өчигдрийн та нарын түүснээс^{орон} жимс түүлээ.** (Ш.Л)

гэхэд нэг газраас жимс түүсэн нь давтагдан дараалсан үйл явдал болж, зөвхөн болсон цагаараа уг хоёр үйл явдал ялгарч байна. Энэ мэтээр дараах өгүүлбэрийг тайлбарлаарай.

1. Өвсний толгой намилзан халиурахын дундуур
Түүний гэрийн утаа цэнхэрлэн холдоно. (Д.Н)
2. Нарт энэ ертөнцөд ургамал дэлгэрсний дотор
Навч цэцэг хоёрын уран нарийн нь жигтэйхэн. (Ц.Д)
3. Алс газар эрдэм сурахаар очих замд
Намрын салхи өмнөөс сэргигнэнэ. (Д.Н)



- II. а. Орны утгатай дараах үгийг ашиглан, нийлмэл өгүүлбэр бүтээгээрэй.
цаана, наана, дэргэд, хажууд, хооронд, дунд, урдуур, хойгуур, цаагуур, хажуугаар, өмнүүр, зүг, дотор, дагуу,
Жишээлбэл: Бүгдээрээ нисэх онгоцны буусан зүг орон гүйдэн очив. (Ш.Л)
гэхэд “онгоц буух, хүүхдүүд гүйдэн очих” хоёр үйл явдал нэг орноо болж байна.
- б. Гишүүн өгүүлбэрийн өгүүлэхүүн нь ямар нөхцөлөөр хэлбэржсэнийг ажиглаж, ямар асуултад хариулагдаж буйг тайлбарлаарай.

В. ЦАГИЙН УТГАТ НИЙЛМЭЛ ӨГҮҮЛБЭР:



Гол өгүүлбэрийн үйл явдлын цагийн дарааллыг илтгэж, хэзээ?, хэдийд?, хэзээнээс?, хэдий үеэс? зэрэг асуултад хариулагдах гишүүн өгүүлбэрийг ЦАГИЙН УТГАТ НИЙЛМЭЛ ӨГҮҮЛБЭР гэнэ.

Хэлбэржих нь	Холбох нь	Жишээ нь
1. Гишүүн өгүүлбэрийн өгүүлэхүүн нь үйлийн холбох нөхцөлөөр хэлбэржинэ.	- магц ⁴ , - хлаар ⁴ , - нгуут ² , - тал ⁴ , -д	Мал төллөж дууса <u>хлаар</u> хэзээ? тэд буцна.
2. Цагаар тодотгон холбох нөхцөлтэй өгүүлэхүүний дараа бие даасан үг туслах үүргээр орно.	-ын өмнө, дараа, хойно, цагт, үед, -тай зэрэг, урьд,	Өнчин цагаан ботго нь өвс ногоо гандаад <u>ирэхийн цагт</u> хэдийд? өөрийн хайрт эхийг санав. (ААЗ)



1. Дараах энгийн өгүүлбэрийг цагийн утгат нийлмэл өгүүлбэр болгон хувиргахдаа дээрх бүтээврийг ашиглаарай.

1. Үүрийн цагаан гэгээ тусна. Хөхөө шувуу урьхнаар донгодно. (Д.Н)
2. Удалгүй дүгрэг том нар мандан гарч ирнэ. Баруун ба хойд уулын оройд гэрэл тусав. (Д.Н)
3. Адуугаа усанд оруулаад, унасан морио услав. Хүйтэн усаар нүүр гараа угаана. (Д.Н)
4. Цогт хүү уяан дээрээ очиж, мориноосоо буув. Эцгийн дэргэд очив. Эцэг нь “За, адуугаа сайн манав уу?” гэв. (Д.Н)

Г. ЗОРИЛГЫН УТГАТ НИЙЛМЭЛ ӨГҮҮЛБЭР:

Эрдэм номыг сурахаар
Энхрий хүү чинь мордож байна. (З.Д)

Нийлмэл өгүүлбэрийн “...сурахаар” гэсэн өгүүлэхүүн нь “мордож байна” гэсэн өгүүлэхүүний зорилгыг илтгэжээ.



Дараах өгүүлбэрүүдийг ажиглаад, гишүүн өгүүлбэрийн өгүүлэхүүнд асуулт тавьж, ямар ямар бүтээврүүд зорилгын утгатай нийлмэл өгүүлбэр бүтээснийг тайлбарлаарай.



1. Монгол хүн хоточ нохойгоо хүнгэнэсэн сайхан дуутай болгохын тулд бага байхад нь түүхий уушиг залгиулан, хоолойг нь уужруулдаг. (С.Н)
2. Сүрлэг том харагдуулахын тулд сүүлний нь угийн арьсанд шар тос түрхэж, саглагар том сүүлтэй болгодог. (С.Н)
3. Ус нь намайг угаах гэж
Эрэг дээгүүрээ цоройж
Эх орон над руу ирсэн... (Б.Л)
4. Анаж занаж дайсан хүүгий нь хороохоор иржээ.
Ачтай эх нь үрээ нүднийхээ цэцгийг нуужээ... (Т.Г)



Шалтгааны утгат гишүүн өгүүлбэр
Орны утгат гишүүн өгүүлбэр
Цагийн утгат гишүүн өгүүлбэр
Зорилгын утгат гишүүн өгүүлбэр

Гол өгүүлбэрийнхээ үйл
өгүүлэхүүнд захирагдана.



Дараах өгүүлбэрийн бүтэц, утгыг ажиглан, даалгаврыг гүйцэтгээрэй.

№	ӨГҮҮЛБЭРҮҮД НЬ	Даалгавар нь
1	Эйнштейн 16 настайдаа нэгэн өдөр “Гэрлийн цацрагтай адилхан хурдаар зэрэгцэн гүйвэл яах бол” гэж гэнэт бодсон гэдэг. Их эрдэмтэн энэ бодлоо биелүүлэхийн тулд 10 гаруй жил хөдөлмөрлөж, суут нээлт болгож чаджээ.	Онцолсон өгүүлбэрийн утгыг тодорхойлоорой
2	1581 оны нэг өглөө Пиза дахь сүмд хүмүүс мөргөл үйлдэж байхад Галилей, таазанд өлгөөтэй байсан дэн савлахыг хараад сууж байв. Тэгээд дэн ижил хугацаанд урагш хойш хөдлөхөд, хурд ба савлах зай нь багасаж байгааг анзаарав. “Энгийн дүүжингийн дүрэм” гэж нэрлэгдсэн хуулийг Галилей сүмийн дэнгийн хөдөлгөөнөөс улбаалан нээсэн байна.	Аль аль өгүүлбэр нь цагийн утга илтгэж байна вэ?
3	Манай улсад 2 өдөр бороо ороход л 10 орчим мянган шоо метр ус хий дэмий урсаж өнгөрдөг. 2 өдрийн борооны усыг нөөцөлж чадвал Эрдэнэт үйлдвэрийн нэг жилийн усны хэрэглээтэй тэнцэх усыг, 3 хоног бол Оюу толгойн нэг жилийн усны нөөцийг хуримтлуулж авах боломжтой.	Өгүүлбэрүүдэд ямар хувиргал хийвэл зорилгын утгат нийлмэл өгүүлбэр бүтэх вэ?
4	Австралийн эрдэмтэн Робин Уоррен, Барри Маршалл нар хүний ходоодны салслаг бүрхэвчний гадаргуугаас “Хеликобактер пилори” гэдэг бактерийг олж нээсэн байна. Тэгээд, стресс юм уу хурц хоол биш, харин энэ бактери ходоодны үрэвсэл, ходоодны шарх үүсэх шалтгаан болдог гэсэн таамаглал дэвшүүлж, баталжээ.	Өгүүлбэрийг ашиглан, орны утгат нийлмэл өгүүлбэр бүтээгээрэй.

Дараах нийлмэл өгүүлбэрийг утгаар нь зөв харгалзуулаарай.

1. Алтай, Хангайгаа чөлөөлөхөөр, албат иргэдээ суллахаар, атаатан дайснаа сөнөөхөөр ах дүү хоёр мордов гэнэ. *(Алтай хайлах)*
2. ... Хус мод жигдлэн ургасны дундуур сажлан авирч Бэрх эгцийг, оройн нар уулын толгойд давав. *(Д.Н)*
3. Цэцэг хагдрах гэж ургаж, ургахын тулд хагдарна... *(Дан.Н)*
4. Сайн эрдмийг сурахын урьд Савын гурван гэмийг тэвч. *(Т.Г)*
 - а. Цагийн утгат нийлмэл өгүүлбэр
 - б. Зорилгын утгат нийлмэл өгүүлбэр
 - в. Шалтгааны утгат нийлмэл өгүүлбэр
 - г. Орны утгат нийлмэл өгүүлбэр

Аяллын тэмдэглэлийг уншиж, задлан шинжилье.

Франц Август Ларсон (1870-1957)

Шведийн худалдаачин Франц Август Ларсон Монголд тун олон жил амьдарсан нэгэн. Тэрбээр худалдаа наймаа эрхлэн, улмаар манай улсын гадаад харилцаанд гүүр болж байсан хүн. Түүнд Богд хаан гүн цол шагнасан тул түүхэнд Монгол гүн Ларсон хэмээн алдаршсан ажээ. Ф.А.Ларсон нь Богд хаан, Жалханз хутагт Дамдинбазар, Чин ван Ханддорж, Б.Цэрэндорж зэрэг Монгол төрийн зүтгэлтнүүдтэй ойр дотно явж байжээ.



“Ард түмэн” бүлгээс

Зуны нэгэн өглөө би замаар явж байгаад нөхөөстэй хувцастай, араг үүрч, савар барин, аргал түүж яваа хижээл насны нэгэн авгайтай тааралдлаа. Монголын хойд, дорно хэсгийн их ойтой газраас бусад бүх газарт цорын ганц түлш нь аргал билээ. Аргал үнэргүй шатна. Дорхноо асаж, илчтэй гал дүрэлзэнэ. Тэгээд ч утаа май багатай. Харин, аргал түүх гэдэг бол газар ширтсэн төвөгтэй ажил. Юм бүхэнд морь унахыг чухалчилдаг оронд зайлшгүй явган явах шаардлагатай ажил.

Сайхан морь унан яваа надад хог шороотой араг үүрээд, аргал түүж яваа энэ эмэгтэй өрөвдөлтэй харагдлаа. Ийнхүү, арай ядан түүсэн аргалынхаа хэдийг нь ноёндоо өгдөг бол хэмээн бодов. Нөгөө эмгэн намайг харснаа цэх шулуун зогсоод, яг л хатан хүн шиг ихэмсгээр гэдийн байж надаас:

Чи гаднын хүн байна. Хаанаас ирсэн бэ, хүү минь? Аян замдаа сайн явж ирэв үү? гэхэд, би товчхон хариулбал, эмгэн их л өрөвдөнгүйгээр:

Жишээ	Шалтгаан	Үр дагавар
<p>Шидийг олоод нисэхийг шахав Шидэмсээр боолгоод үхэхийг шахав. (МАЗ)</p> <p>Урьд нэгэн өвгөн, залуутай хамт холын аянд явжээ. Залуу нь шөнө болгон тэмээгээ манадаг байж. Нэгэн шөнө залуу нь: - Би нойрондоо дийлдэх нь, яадаг билээ? гэхэд өвгөн ухаан сийлж, - Чи далан тэмээгээ долоон гадсанд сондгой тоогоор уяад, унт даа гэжээ. Залуу шөнөжин оролдоод барсангүй. Нэг мэдэхэд үүр цайж байсан гэнэ. (МАЗ)</p>	<p>Шидийг ол Шидэмсээр боолго</p>	<p>нисэхийг шахав үхэхийг шахав.</p>
<p>Өвчин бага боловч үхлийн шалтгаан Буян бага ч болов туслахын шалтгаан Гал бага ч болов түлэхийн шалтгаан Нүгэлт нөхөр хол ч болов хорлохын шалтгаан... (Д.Равжаа)</p>		
<p>Эзэн муутын хороо хүйтэн Ээж муутын хоол хүйтэн Эв муутын санаа хүйтэн (Ертөнцийн гурав)</p>		
<p>Гурван “ганц”... Ухаантай хүн тэнэг хүндээ санаа зовохоо болих ганц нөхцөл: Сэтгэлийн гэгээг хураах. Ухаантай хүн тэнэг хүндээ тусалж чадахаа болих ганц нөхцөл: Хоёулаа авсанд зэрэгцээд хэвтэх. Ухаантай хүн тэнэг хүнтэйгээ ав адилхан болох ганц нөхцөл: Дэлхий эргэхээ зогсох. (Д.Урианхай)</p>		
<p>Хөрөнгө хураах нэг зовлон Хадгалж харах түмэн зовлон Орлогоо базаах нэг зовлон Гаргаж зовох буман зовлон Зовлон зүдүүрийн эх - эд хогшил Шаналал жигшүүрийн охь - сан хөмрөг (Сургаалаас)</p>		
<p>... Бичиг зохиохууд үг үсгийг ёсоор эс найруулбаас Билгүүн сайн эрдэмтэн авч сонжуурлагдахын гэмт ... (Агваандандар)</p>		



17

Хүүрнэн бичсэн эхээс шалтгаан, үр дагаврыг ялгая.

Эхийг уншаад, ишигний үйлийн дарааллыг задлан шинжлээрэй.

Халтар ишиг

Янгирын ишиг бол тэгэхгүй дээ.

Яагаад?

Хар хүйтнээр гарч осгосон нэг муу нударга шиг халтар ишгийг халуун тогоон дотор хөмөрч байж мал болгосноос хойш тэр гэр амьтай болсон юм.

Шалтгаан уу, үр дагавар уу.

Шалтгааны утгатай өгүүлбэр байна уу.

“Халтар ишиг сав л хийвэл илүү гэрт орчихсон цагааны шар шүүс залгилж байна. Сахал нь хуурай явах цаг цөөн.

Тэр сүүлдээ бүр хэтрээд, их гэрт орчихсон авдрын арсланг “мөргөх” байрын зогсдог боллоо.

Үр дагаврыг илтгэсэн өгүүлбэр мөн үү.

“болохоор” гэсэн холбох үг ямар утга, үүрэгтэй вэ?

Бид ч багаас нь эрхлүүлчихсэн юм болохоор нэг их нүд үзүүрлэн хөөж туудаггүй байв.

Тэгтэл харин “мань эр” нэг өдөр бүр давран, тахилын цөгцтэй сүүг маань татаж асгачхаад, бас болоогүй алтан хойморт хэд гурван хоргол унагачхаад гарсан байв.

Өгүүлбэрт яагаад? гэсэн асуулт тавибал хариултыг аль өгүүлбэрээс хайх вэ?

“ингэж” гэсэн үйлийн төлөөний үгэнд хамаарах үйл үгийг эхээс ялган, жагсааж бичнэ үү.

Тэр ингэж тахилаа буруу өргөсөн болой.

Эхийн утгад тохирсон хэлц үг бичнэ үү.

◆ Гар бариад бугуй барих

- ◆
- ◆
- ◆

(Ц.Чимэддорж)



1932-1933 онд Д.Нацагдорж “Миний нутаг” шүлгээ бичив. Их сайхан шүлэг болжээ.

Мэдээллийн зорилго юу вэ?

Шалтгааны утгатай өгүүлбэр байна уу.

“Миний нутаг” зохиолыг сонинд хэвлэх гэхээр томдоод, сэтгүүлд хэвлэе гэхээр уран зохиолын сэтгүүл байсангүй. Зохиолчид нь шагнал өгье гэтэл тийм журам байсангүй.

Би уран зохиолын бүлгэмийн нарийн бичгийн дарга байсан бөгөөд зохих хэмжээний мэдэлтэй хүн байв. Тийм учраас бүлгэмийн санхүүгээс Д.Нацагдоржид 500 төгрөг олгосон юм.

“Тийм учраас” гэсэн холбох үг нь шалтгаан, үрийн алийг нь илтгэж байна вэ?

Энэ баримт юуг баталж байна вэ?

Бод л доо. Бүдүүн тарган хонь худалдан авахад 5 төгрөг, сайн морь авахад 15 төгрөг байсан үе шүү дээ. Их Нацагдоржийг миний баярлуулсан нь тэр билээ.

1933 онд би ЗХУ-д сургуульд явах болж, бүлгэмийн ажлыг Өөлдийн Чимидэд хүлээлгэж өгөв. Тэгэхэд Д.Нацагдоржийн “Миний нутаг” шүлгийг Чимидэд хүлээлгэж өгөхдөө “Энэ 500 төгрөгийн үнэтэй шүлэг шүү. Алдаж осолдож болохгүй, цоожтой сайн саванд хадгална шүү” гэдгийг айхавтар сүрхий захиад, “Энэ хүн жинхэнэ шүлэгч хүн. Аргагүй л хайрлаж хамгаалах их авьяас шүү” гэж хэлсэн юм.

Өгүүлэгчийн хэлсэн үгэнд ямар, ямар өнгө аяс ажиглагдаж байна вэ? Үүний шалтгааныг эхээс тодруулаарай.

(Б.Бааст “Ц.Дамдинсүрэн”)

- Д.Нацагдоржийн “Миний нутаг” найраглал нь “Зууны шилдэг найраглал” гэдгийг та нар мэднэ. Тэгвэл энэ бүтээлийн үнэ цэнийг дээрх эхэд хэрхэн тайлбарласан байна вэ?
- Шалтгааныг нь “Миний нутаг” найраглалаас нэг бадаг сонгон тайлбар бичээрэй.

.....

.....


.....

.....



Асуудал дэвшүүлэн, үзэл бодлоо илэрхийлэхдээ шалтгаан, үр дагаврын холбоог үндэслэл нотолгоотой гаргая.

- ◆ Баримтад үндэслэн үзэл бодлоо илэрхийлэх аргыг таньж мэдэх
- ◆ Баримт нотолгоонд үндэслэн үзэл бодлоо илэрхийлэх




19

Зохиолчийн үзэл бодлыг тодорхойлъё.

Ж.Гангаагийн “Ус мөрөн байвчиг говийг минь тойрно” нийтлэлийг цогцолбороор задалж, ялгав.

- Цогцолбор бүрийг уншиж, гол санааг тайлбарлаарай.
- Зохиогч үзэл бодлоо юунд тулгуурлаж илэрхийлсэн байна вэ?



“Дэрээ элээхээр дэвсээ элээ” гэж юу гэсэн үг вэ? Энэхүү хэллэгийн утгыг зөв ойлгохын тулд дараах зүйлийг заавал мэдэх шаардлагатай.

Үүнд: Энэ хэллэг хоёр зүйлийн мэдээлэл агуулсан хоёр өгүүлбэрээс бүтсэн байна.

Дэрээ элээх

Дэвсээ элээх. Гэвч энэ хоёр санааг дэрээ элээснээс дэвсээ элээх нь дээр гэсэн утгаар холбосон байна. **Тэгвэл** яагаад ингэсний учрыг тайлна гэсэн үг.

Ингэхийн тулд дэр ба дэвс гэж юуг хэлдэг, элэгдэх гэж ямар үйлийг хэлдэг, ямар утга илэрхийлдгийг санаж, яавал дэр элэгдэх, дэвс элэгдэх вэ гэдгийг бодож зөв ойлгох ёстой. “Монгол хэлний товч тайлбар толь” -оос (2013) үзье.

Дэр-1. Толгойн тавиур буюу жинтүү, түшүүр. Дэр булаалдах (буриадын хуримын үед дэр булаалдах зан үйл), Дэр нэгдэх (эр эм бололцох), Хөлийн дэр (хэлбэр хэмжээ, гоёл чимэглэлээрээ толгойн дэртэй адил эмэгтэй хүний орны хөлд байх дотуур хувцас хийх дэр), 2. Юмны доогуур тавьсан ивүүр (босгоны дэр, дэр мод, дэр чулуу, төмөр замын дэр мод), Дэр авч үхэх (дайн тулааны үед амийг амиар солих буюу үхэхдээ заавал нэг дайсныг тонилгох ёс),

Дэвс 1. Эмээлийн олонцог

Элэх: 1. Эд хуучрах, үлтрэгдэх, хорогдох, нимгэрэх, цоорох, урагдах,

2. Юмыг огтлох, нүхлэн цоолох, хальслах хэмээн тус тус тайлбарлажээ.

Ингэхлээр дэр бол хэвтэхдээ толгойгоо газар дэвсгэр зэргээс өндийлгөж, хөндийрүүлэн, тав тухтай байлгахад зориулсан түшүүр буюу жинтүү, харин дэвс бол дөрөөний сурыг дарж халхалснаараа морь унах хүний хөлийн борви булчинг сур холгохоос хамгаалсан тоног хэрэгслийн нэг зүйл эдлэл болох нь мэдэгдлээ.

Элэгдэх гэдэг нь “элэ-” гэдэг үйл үндсээс үүссэн хэлбэр бөгөөд ямар нэг зүйлийг удаан хугацаагаар тасралтгүй эдэлж хэрэглэх юм уу, ашигласнаар уг юм өнгө зүс гундах, чанар чансаа нь муудах зэргээр хэврэгшин доройтож, элж хорогдох гэсэн утга илэрхийлж байна. **Тэгвэл** дэр ч тэр, дэвс ч тэр эдлэх тусам үлтрэх, цоорох зэргээр амархан элэгдэж, хуучрах учиртай эд болох нь тодорхой болж байна.

Өөрөөр хэлбэл, амарч хэвтэх хүн дэр дэрлэнэ. **Ингэж** дэрлэхийн тоолонгоор дэр нь элэгдэж муудна. **Харин** аян замд гарах хүн морио эмээллэж мордоно. Ингэхийн тоолонгоор дэвс элэгдэж муудах нь зайлшгүй болно. **Чингээд** унтаж хэвтээд байвал дэр элэгдэнэ, унаж яваад байвал дэвс элэгдэнэ. Өнгөцхөн бодвол, аль аль нь гарз хохиролтой ч юм шиг.

Гэвч, дэрээ элээснээс дэвсээ элээх нь дээр гэж хэлсний учир юу юм бол?

Тэгвэл юм хийхгүй, биеийн амрыг харж зүгээр л суугаад хэвтээд байвал дэр нь элэгдэх зэргээр өөрт нь байгаа юм болгон л элэгдэж хорогдоод байхаас биш, өөр юу ч нэмэгдэхгүй гэсэн дүгнэлт гарч байна ...

Монгол хэлний “явсан нохой яс зууна, хэвтсэн хүн хээл алдана” гэсэн хэллэгтэй утга ойролцоо байгааг ойлгон ухаарч болно.... Дээрх хоёр зүйл хэллэгийн утгыг харьцуулбал, хэвтээд байвал дэр чинь элэгдэхээс биш, өөр юу ч нэмэгдэхгүй, **тийм учраас** яваад дэвсээ элээж явсан нь дээр гэдгийн адилаар хөдлөөд яваад, эрээд хайгаад яваа нохойд ядахдаа яс олодоно, гэтэл хөдөлж явахгүй, хийж бүтээхгүй хэвтээд байвал идсэн уусан чинь шингэж, гэдэс ходоод чинь дундарч хоосроод, хээл алдахаас цаашгүй болно гэсэн санаа юм байна гэх зэргээр ойлгож болно гэсэн үг.

(Ж.Баянсан “Соёл, хэл, үндэсний сэтгэлгээ” 210-213 дугаар тал УБ, 2016)



а. Дараах даалгаврыг гүйцэтгэнэ үү.

№	Асуулт	Хариулт
1	“Дэрээ элээхээр дэвсээ элээ” гэсэн хэллэг нь асуудал мөн үү.	
2	Дараах холбох үгийн утга, үүргийг тайлбарлана уу.	
	Үүнд	
	Тэгвэл	
	Ингэхийн тулд	
	Ингэхлээр	
	Тэгвэл	
	Өөрөөр хэлбэл	
	Ингэж	
	Харин	
	Чингээд	
Гэвч		
Тийм учраас		
3	“Дэрээ элээснээс дэвсээ элээх нь дээр” гэж хэлсний учир юу юм бол? хариулт нь аль хэсэгт байна вэ?.	
4	Тайлбарыг ямар баримтад үндэслэсэн бэ?	
5	“Өнгөцхөн бодвол, аль аль нь гарз хохиролтой ч юм шиг” гэсний учир юу вэ?	
6	“Хэвтээд байвал дэр чинь элэгдэхээс биш, өөр юу ч нэмэгдэхгүй, тийм учраас яваад дэвсээ элээж явсан нь дээр” гэсэн өгүүлбэрээс шалтгаан ба үр дагаврын утгатай өгүүлбэрийг ялгана уу.	
7	Зохиогчийн дүгнэлтийг ялгана уу.	



21 Үндэслэл, баримт, асуудлын учир шалтгааныг тайлбарлая.

- Дараах мэдээллийг уншиж ойлгоод, даалгавар хийхэд бэлтгээрэй.
- Дараах үгс чамд ямар сэтгэгдэл төрүүлж байна вэ?. Шалтгааныг хэлнэ үү.
Үгс нь: гар утас, гар утасны гэрэл, нойргүйдэл, сэтгэл гутрал, таргалалт, хавдар, суралцах идэвх муудах, нүдний болор гэмтэх
- Мэдээллийг уншсаны дараа чи юу ухаарч ойлгосон бэ?




Гар утасны гэрэл таны тархи болон бусад эрхтэнд ингэж нөлөөлнө.


Мелатонин даавар ялгарах үйл явц өөрчлөгдсөнөөр нойрсох хэмнэл алдагддаг. Мөн эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй.



Нойрны хэмнэл алдагдах нь ой тогтоолт муудах, шийдвэр гаргах чадвар доройтох, бүтээлч байдал багасах, сэтгэл хөдлөлөө хянах чадвар буурах зэрэг сөрөг үр дагавар бий болгоно.



Гар утасны гэрэл нь нүдний торлог бүрхэвчийг гэмтээдэг.




Гар утасны цэнхэр гэрлээс үүдэлтэй нойргүйдэл нь суралцах чадварыг бууруулдаг.



Түүнчлэн уг гэрэл өлсгөлөнг хянаж байдаг дааврын ялгаралд нөлөөлж, улмаар таргалуулах эрсдэлтэй.



Удаан хугацаанд нойргүй явбал мэдрэл саармагжуулагч нейротоксин хэмээх хор хуримтлагддаг. Улмаар хэвийн унтаж амрахад хэцүү болдог.



Мелатонин дааврын ялгарал багасаж, биологийн цаг нь өөрчлөгдсөн хүмүүс сэтгэл гутралд орох нь түгээмэл.

Судлаачид болор цайх өвчин тусахад цэнхэр гэрэл нөлөөлдөг эсэхийг судалж байна.




Гар утасны цэнхэр гэрэл хөхний болон түрүү булчирхайн хорт хавдар тусах эрсдэлийг нэмэгдүүлдэг.



г. Өгүүлбэрүүдийг загварт тохируулан задална уу.


Загвар 1: Үр дагаварт төвлөрөх:



Загвар 2: Шалтгаанд төвлөрөх:



Загвар 3: Шалтгаан, үр дагаврын гинжин холбоо:



д. “Мелатонин дааврын ялгарал багасаж, биологийн цаг нь өөрчлөгдсөн хүмүүс сэтгэл гутралд орох нь түгээмэл” гэсэн өгүүлбэрийн утга аль загвартай тохирох вэ?. “түгээмэл” гэдэг үгийг “хялбар, амархан, элбэг, дийлэнх, зайлшгүй” гэсэн үгээр солин найруулбал аль нь зохистой болохыг сонгож тайлбарлаарай.

Элсэн чихэр

Чихэрлэг бүтээгдэхүүнд дуртай бол арьс хурдан хөгширнэ гэсэн үг.	Тэгвэл элсэн чихэр нь:	Биеийн дархлааг сулруулдаг.
Хүүхдүүд амттан идсэний дараа хөдөлгөөнтэй болж байгааг та анзаарсан л биз дээ.		Чихрийн шижин, харшил зэрэг олон өвчний эх үүсвэр нь болдог.
Бор элсэн чихэр бол ердөө л хар бурам нэмсэн цагаан элсэн чихэр.		Арьс унждаг.
Зогьсоод зогсохгүй байвал халбага элсэн чихэр үмхчих.		Хэт идэвхтэй байдлыг мэдрүүлдэг ч дараа нь илүү их ядраадаг.
100 гр сахар 409,2 ккал илчлэгтэй.		Элсэн чихэртэй ямар нэгэн зүйл идэх нь зогьсолтыг зогсоодог.
Сахар нь цусан дахь инсулины хэмжээг нэмэгдүүлдэг.		Тиймээс цагаан элсэн чихрээс эрүүл гэсэн үг биш.
Бие махбодийг бактери, вирустай тэмцэхэд идсэн сахар чинь саад болдог.		Ямар ч тэжээллэг бодис үгүй.
Дээрх баримтыг нэгтгэж, шалтгаан-үрийн харьцааг зөв тайлбарласан эх бичихдээ доорх загварыг ашиглаарай. 1-р цогцолборт: Хүмүүсийн өдөр тутмын байнгын хэрэглээ.	
2-р цогцолборт: Таагүй сөрөг үр дагавар	
3-р цогцолборт: “Цагаан хор”. Хоол биш хор.	

(Хором.ком сайтаас)

- ♦ **Шалтгааныг:** яагаад гэвэл, учир юу вэ гэвэл, учир нь, тиймээс , -аас, (-ээс, -оос, -өөс) -вал, (-вэл, -вол, -вөл)
- ♦ **Тайлбарыг:** – жишээ нь, жишээлбэл, үлгэрлэвэл, үүний тулд, өөрөөр хэлбэл...
- ♦ **Харьцууллыг:** – шиг, мэт, адил, ижил, ялгаагүй, өөрцгүй
- ♦ **Эсрэгцлийг:** –гэвч, ч, гэлээ ч, ялгаатай нь, харин, мөртөө
- ♦ **Асуудал ба шийдлийг:** – эсвэл, нэг бол ... нэг бол, -вал, (-вэл, -вол, -вөл) хэрвээ ... бол, ийм нөхцөлд, тэгвэл ...гэх мэт үгээр таньж болно.



Эхэд задлал хийе.

Сурагч бүр биеийн жингээ хянаж сурах нь хамгийн сайн хэвшил юм.

Бодисын солилцооны өөрчлөлтийн улмаас арьсан доорх өөхлөг болон бусад эдийн дотор илүүдэл хэмжээгээр өөх хуримтлагдах, биеийн жин нэмэгдэхийг таргалалт гэнэ. Таргалалтаас шалтгаалан биеийн жин хэвийн хэмжээнээс хэтрэх нь сүүлийн үед олны анхаарлыг нэлээд татах боллоо.

Ялангуяа охид, бүсгүйчүүд туранхай гоолиг болохыг хүсэн, янз бүрийн баталгаагүй эм, хүнсний нэмэлт бүтээгдэхүүн хэрэглэж, эрүүл мэндээрээ хохирох явдал ч цөөн бус гарч байна.

Иймд, олон хүний сэтгэлийг зовоож байгаа энэ асуудлыг хэрхэн шийдэх вэ? Таргалалтыг тодорхойлох энгийн арга нь биеийн жингийн индекс (БЖИ) – ийг тогтоох. Дунд сургуулийн сурагчдын эрүүл мэндийн сурах бичигт биеийн жингээ олох аргыг тусгасан байдаг боловч түүнийг хэмжиж хэвшил болгох, биеийн жингээ хянаж сурах нь тулгамдсан асуудлын нэг болж байна. БЖИ-ийг бодохдоо биеийн жин ба өндрийг үнэн зөв, нягт нямбай тодорхойлох шаардлагатай. Тухайн хүний биеийн жин ба өндрийг харьцуулж биед агуулагдах өөхлөг эдийн хэмжээг тогтооход БЖИ- ийг ашигладаг.

Яагаад заавал биеийн жингээ хянах ёстой вэ? Таргалах нь эхлээд бие махбодод төдийлөн их хор нөлөө үзүүлэхгүй байгаа юм шиг санагддаг ч аажимдаа хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлдэг. Таргалах нь ерөнхийдөө бодисын солилцооны тэнцвэр алдагдсанаас болж өөх, тослогийн хэмжээ биед их хэмжээгээр хуримтлагдсанаас үүсдэг.

Биеийн жингийн индекс (БЖИ) -ээ сайн мэдэхгүй явснаар жин илүүдэх нь ууц нурууны өвчин үүсгэдгийг тогтоосон. Энэ нь хувь хүний биеийн байдал болон сэтгэл санаанд шууд нөлөөлж, хөдөлгөөнийг хязгаарлаж, амьдралын чанарыг бууруулдаг бөгөөд эрүүл мэндээ сайжруулахад гарах зардлыг ихэсгэдэг байна.

Биеийн жин нэмэгдэхийн хэрээр нурууны зээрэнцэг дээр ирэх биеийн ачаалал нэмэгдсэнээс болж зээрэнцэг гэмтэж эхэлдэг. Мөн өөхний эс нь архаг үрэвслийг бий болгох шалтгаан болдог хэмээн судлаачид үзэж байна.

Эрэгтэйчүүд хэвлий, гэдсээрээ илүү таргалдаг бол эмэгтэйчүүд өгзөг гуя, мөр хэсгээрээ ихэвчлэн таргалдаг. Хэт таргалалтаас болж чихрийн шижин, зүрх судасны өвчин, элэг өөхлөх, даралт ихсэх, цөс, нойр булчирхайн өөрчлөлт, сарын тэмдэг өөрчлөгдөх, хөл муудах зэрэг олон янзын өвчин үүсдэг. Таргалалт нь хоол хүнсний зохисгүй хэрэглээ, хөдөлгөөний дутагдлаас ихээхэн шалтгаалдаг тул зохистой, идэвхтэй дасгал хөдөлгөөн хийхээс гадна хоол хүнсээ тохируулах хэрэгтэй.

Өдөр бүр идэвхтэй дасгал хөдөлгөөн хийх нь хамгийн чухал байдаг учир сургууль дээр долоо хоногт 80 минутын биеийн тамирын хичээлээр хийх хөдөлгөөн нь биеийн тогтмол хөдөлгөөн болж чаддаггүй байна. Иймд идэвхтэй хөдөлгөөнтэй байхын тулд чөлөөт цагаараа дасгал хөдөлгөөн хийж байх нь зүйтэй.

Зөв бичье: олшрох, шагнал, бэлтгэл, сонирхол зэрэг үгийн язгуурыг олж бичнэ үү. Авианы ямар хувирал ажиглагдаж байна вэ?



Ажиллах дараалал:

- а. Эхийг анхааралтай дахин уншина.
- б. Дараах гурван асуултын хариуг олж бичнэ. Үүнд:
 - ◆ Эхэд дэвшүүлсэн асуудал нь юу вэ?
 - ◆ Уг асуудлын шалтгаан нь юу вэ?
 - ◆ Уг шалтгаанаас үүдэн гарах үр дагаврууд нь юу вэ?
- в, Графикт юуг харуулсан байна вэ? Хэчнээн төрлийн мэдээлэл байгааг бүрэн өгүүлбэрээр тоочин бичнэ үү.

Бэлэн бүтээгдэхүүн



Биед тэжээл, амин дэм өгдөггүй хэрнээ их хэмжээний сахар болон өөх тосноос бүтсэн хүнсний бүтээгдэхүүн

Жингийн илүүдэл

ТАРГАЛАЛТ БА ӨВЧЛӨЛ

+52%

Улаан хоолойн хавдар

+24%

Бүдүүн гэдэсний хорт хавдар

+59%


Цөс, умайн хүзүүний хорт хавдар


+12%


Хөхний хавдар

ИЛҮҮДЭЛ ЖИНГИЙН "ХАМААТНУУД"

 Зүрх судасны өвчин

 Цус харвалт

 Хавдар

 II төрлийн чихрийн шижин



г. Эх ба графикт дэвшүүлсэн асуудал болон баримт мэдээллийг адил төстэй шинжээр нь бүлэглэж бичээрэй. Асуудлыг тайлбарласан арга нь юугаараа ялгаатай байна вэ?

Сурагч бүр биеийн жингээ хянаж сурах нь хамгийн сайн хэвшил юм.	Жингийн илүүдэл
Хүнсний нэмэлт бүтээгдэхүүн	Пицца
.....
.....
.....
.....
.....
.....

д. Графикаас шалтгаан, үрийг ялган, бүлэглэн жагсаана уу.



е. Загварыг ашиглаж, хоол хүнсний зохисгүй хэрэглээнээс үүдэн гарах үр дүнг илтгэсэн өгүүлбэр бичээрэй.

1. Пицца	} (ид-)	<ul style="list-style-type: none"> - аас, (-ээс, -оос, -өөс) - вал, (- вэл, - вол, - вөл) - улмаас - хлаар, (- хлээр, - хлоор, - хлөөр) - ээс болж - учраас - х, -д - тул
2.
3.
4.
5.
6.
7.



- ё. Эхэд шалтгаан ба үрийн холбоог илтгэхэд зурж онцолсон үг чухал үүрэгтэй байгаагийн учрыг тайлбарлан ярилцана.
- ж. Нөхцөл ба холбох үгсийг ойролцоо утгатай өөр нэгжээр солин найруулах боломжийг ярилцана.

Гэртээ: Ангийнхандаа зориулж ханын самбарын зөвлөмж бичих: “Эрүүл хооллолт гэдэг нь хоолны дэглэмийг ягштал барих, хэтэрхий туранхай байх, хоол хүнснийхээ хэрэглээг хязгаарлаж, дуртай хоол хүнснээсээ татгалзана гэсэн үг биш юм. Зөв хооллож сурснаар таны эрүүл мэнд, ой ухаан сайжирч, эрч хүч нэмэгдэж, сэтгэл санаа тань тогтвортой болно” гэсэн гол санааг илтгэхэд чиглэнэ. Үг хэллэгийн сонголт, өнгө аяс (хандлага, мэдрэмж), найруулгын төрөл зүйлийн онцлог, уншигчийн онцлогийг харгалзаж бичих.

Нэмэлт үйл ажиллагаа:

- а. Асуудал дэвшүүлэхийн тулд орчин тойрноо ажиглаж, хоол хүнсний зохисгүй хэрэглээ, буруу хооллож буй шалтгаануудыг олж, чухал, чухал бус шинжээр нь эрэмбэлэн бичээрэй.
- б. Тэдгээрээс сонгож асуудлаа дэвшүүлнэ үү.
- в. Эрүүл зөв хооллолтын талаар интернэт болон мэдээллийн бусад эх сурвалжаас хэрэгцээтэй мэдээлэл цуглуулаарай.
- г. Дээрх эхэд байгаа *“улмаас, таргалалтаас шалтгаалан, алдагдсанаас болж, хуримтлагдсанаас, ачаалал нэмэгдсэнээс болж, хэт таргалалтаас болж, дутагдлаас ихээхэн шалтгаалдаг”* гэсэн холбоо үгсэд монгол хэлний гарахын тийн ялгалын нөхцөлийг түгээмэл хэрэглэснийг анхаарах.
- д. Графикт байгаа “Таргалалт ба өвчлөл”, “Илүүдэл жингийн хамаатнууд” хэсгийг ашиглан, гарахын тийн ялгалын -аас, (-ээс,-оос,-өөс) бүтээвэртэй өгүүлбэр зохионо уу.
- е. Өгүүлбэрийн найруулгыг хэрхэн өөрчилснийг харьцуулан жишээд, ялгааг олоорой.

Уг нөхцөл ямар нэг үр дагавар урган гарах шалтгаан, эх үүсвэрийг заах утга агуулдаг.

Бодисын солилцооны өөрчлөлтийн улмаас арьсан доорх өөхлөг болон бусад эдийн дотор илүүдэл хэмжээгээр өөх хуримтлагдах, биеийн жин нэмэгдэхийг таргалалт гэнэ.



Бодисын солилцоо өөрчлөгдсөнөөс арьсан доорх өөхлөг болон бусад эдийн дотор илүүдэл өөх хуримтлагдаж, биеийн жин нэмэгдэхийг таргалалт гэнэ.

Зөв бичье: ашиглалтад-ашиглалтанд, амжилтад-амжилтанд, өөрчлөлтөд-өөрчлөлтөнд, эргэлтэд-эргэлтэнд, таргалалтад-таргалалтанд, услалтад-услалтанд, хооллолтод-хооллолтонд зэрэг үгийн аль хувилбар нь зөв болохыг тайлбарлаарай. Яагаад?



Санаачилга багадна гэж үгүй

Орон сууцны хуучирч муудсан цахилгаан шатны хаалга ашиглан хашлага болон салхлахад зориулсан сандал хийжээ. Энэ бол Баянгол дүүргийн 1 дүгээр байрны гадна талбай юм. Хуучин цахилгаан шатыг шинэчлэх явцад гарсан зарим төмрийн хаягдлыг, нарлахад зориулсан саравч барихад ашиглаж, хаалгануудаар нь сандал, хайс бүтээсэн талаар энэ байрны СӨХ*-ы ажилтан Б.Дулам ярьж байна.

2014 онд Баянгол дүүргийн хуучин орон сууцнуудын цахилгаан шатыг шинэчлэх ажил эхэлсэн байна. Энэ үеэр гарсан хаягдлыг хэрхэн ашиглаж болох тухай яриа СӨХ-ы ажилтнуудын дунд өрнөжээ. Өнгө үзэмж муудаж, хэлбэр дүрсээ алдаад байсан хашлагуудыг цахилгаан шатны хаалгаар сольж болох юм гэдэг санаа тэндээс төрсөн байна.

Хуучирч өнгө үзэмжээ алдсан хаалгануудыг будаж, шинэчлээд хашлага хийсэн бол хуучраагүй хаалгануудыг шууд ашиглажээ. Энэ ажил бусад байрныханд үлгэр дуурайл болж эхэлсэн аж. Зэргэлдээх байр ч ийм хаалга ашиглаж, хашлагуудаа шинэчилсэн байв. Харахад бяцхан санаа боловч, ард нь том агуулга нүүгдаж буй. Бүтээн байгуулалт ид өрнөж байгаа манай улсад энэ мэт ашигтай санаанууд хэрэгтэй.

1 дүгээр байрны өмнө салхилж суусан хоёр эмээгээс байрны ойр орчмынхоо талаар ямар сэтгэгдэлтэй явдгийг нь асуувал, “Өөрсдийнхөө хэмжээнд сайхан орчин бий болгохын төлөө хичээж байна гэж хардаг. Үүнд, бид сэтгэл тун хангалуун байна” хэмээн хариуллаа.

Орц руу нь орвол, хог, эвгүй үнэр байсангүй. Харин үүдний зарлалын самбарт “Хогны цэгийн өмнө машинаа тавихгүй байхыг анхааруулъя. Хогоо орцны шатан дээр тавьж болохгүй” гэж бичжээ. СӨХ-ы ажилтнаас суугчдын дутагдалтай талыг асуухад “Зарлалын самбар дээр бичсэн зүйлээс гадна, иргэд нохойгоо хүүхдийн талбайд салхилуулах нь түгээмэл. Нохойгоо хүүхдийн тоглох талбайд бие засуулчихдаг тал дээр анхаараасай. Түүнчлэн СӨХ-той хамтарч ажиллаасай, шинэ санаагаа хэлж байгаасай гэж хүсмээр байна” хэмээн хариуллаа. Тэгвэл, өндөр хөгжилтэй орнуудад нохойгоо салхилуулахдаа нохойн эзэд уут эсвэл цаас бариад гардаг. Нохойн ялгадсыг цаасанд боож аваад, хогны* саванд хийнэ. Ингэснээр бусад оршин суугчдад төвөг учруулахгүй гэж үздэг байна.

Сайхан орчин бүрдэх эхний алхам бол оршин суугчдын хэрэгцээ шаардлага билээ. Санаа гаргаж, хэрэгжүүлэхийг санал болгох нь амьдрах орчин тав тухтай болох, цаашлаад Улаанбаатар хотын өнгө үзэмж нэмэгдэхэд чухал нөлөө үзүүлнэ. Өндөр хөгжилтэй ихэнх оронд гадна талбайгаа сонирхолтой шийдлээр тохижуулсан байдаг нь тэдний хэрэгцээ, хүсэл сонирхолтой нь холбоотой. Хэн нэгэн тэдэнд хийж өгдөг юм биш харин өөрсдөө санаачилж, оршин суугчдаараа хамтардаг. Энэ аргыг монголчууд ч хэрэгжүүлж болно. Бидний хүсээд буй хөгжил, сайхан гудамж биднээс эхлэхийг харуулсан бодит жишээ 1 дүгээр байр байлаа.

(Г.Чимэдлхам, “Засгийн газрын мэдээ” сонин, 2015)

* Сууц өмчлөгчдийн холбоо

* Хогны сав - бодит ба зориулалтын утга

* Хогийн сав - хийсвэр утга, хэрэггүй, чанаргүй, муу сав гэсэн утга (2018 оны “Монгол хэлний зөв бичих дүрмийн журамласан толь”-ийн 533 дугаар хуудасны тайлбарыг үндэслэв)





- а. Эхийн агуулгаас үүдэн, асуудал дэвшүүлж болох 20 асуулт жагсаан бичээрэй. Үлгэрлэвэл: Зөвхөн эхлэл хэсгээс **“Хаягдлыг үр дүнтэй ашиглах өөр ямар арга замыг эрэлхийлж болох бол? Хаягдал бүхэн хог мөн үү? Бид хог хаягдлаа хэзээ ангилан ялгаж сурах вэ?”** г.м. Хамгийн сайн асуултыг шалгаруулахын тулд, багштайгаа хамтран хэлэлцүүлэг зохиогоорой.
- б. Эхээс баримтыг үлдээгээд, өгүүлэгчийн үзэл бодлыг ялган тодруулаарай. Өгүүлэгчийн үзэл бодол ихэнхдээ догол мөрийн аль хэсэгт илэрч байна вэ? Зарим нэг тодруулсан хэсгийг анхаарч, санаа авч болно.
- в. Асуудал дэвшүүлэн бичихийн тулд баримт, үзэл бодлыг хослуулах нь чухал юм байна.
Өөрийн үгээр товч санал, дүгнэлт гаргахдаа дараах цэгийн оронд **“дараа, эхний, өгүүлбэрийн байр дараалал”** зэрэг үгийг нөхөж бичээрэй.

Өгүүлэгчийн үзэл бодол ихэнхдээ догол мөрийн хэсэгт, баримт мэдээллийн илэрч байна. Тиймээс баримт, үзэл бодлыг хослуулахдаа ыг анхаарах хэрэгтэй юм байна.

- г. Эхийн сүүлчийн догол мөр нь дүгнэлт болохын учрыг тайлбарлаарай.
- д. “хотын өнгө үзэмж нэмэгдэхэд” гэсэн өгүүлбэрийн “нэмэгдэхэд” гэсэн үгийг ямар үгээр солин найруулбал оновчтой болох вэ?



“Хог хаягдал” сэдвийн хүрээнд баримт хэрэглэгдэхүүнийг ажиглая, асуудал дэвшүүлье, ярилцъя.

- ♦ Бид яагаад хогийг ангилж хаядаггүй юм бэ? Шалтгааныг тоочно уу.
- ♦ Хогны сав яагаад өөр өнгөтэй байдаг вэ?
“Санаачилга багадна гэж үгүй” гэсэн эхэд өгүүлсний адил үлгэр жишээ, санаа авууштай бүтээлч ажлыг сурвалжлаарай.

- а. Дараах гурван баримтыг ашиглан, асуудал дэвшүүлсэн эх бичнэ үү. “Бидний хүсээд буй хөгжил, сайхан гудамж биднээс эхлэхийг харуулсан бодит жишээ 1 дүгээр байр байлаа” гэсэнтэй адил бодит баримтаар баяжуулаарай.



Бичихдээ ашиглах холбох үгс:

учраас, тиймээс, тул, учир нь, хэрэв бол...
тэгвэл, ийм болохоор, ийм тохиолдолд, ...
-аас (-ээс, -оос, -өөс) шалтгаалан

- А. Нэг хүн хоногт 0,5 кг, жилд 200 кг хуурай хог хаядаг. УБ хотод өдөрт 800-1000 тонн хуурай хог хаягдал гарч, 50 хувь нь хогны цэг рүү ачигдаж, үлдсэн 50 хувь нь агаар, хөрс, усыг бохирдуулдаг байна.



Б.

шалтгаан уу?

үр дагавар уу?



Тамхины үлдэгдэл (3 сар-2 жил орчим)

Бохь (ойролцоогоор 5 жил)

Хуванцар сав (300-1000 жил)

Хуванцар карт (1000 жил орчим)

Шилэн лонх (4000 жил орчим)

Хөнгөн цагаан лааз (10-1000 жил)

Живх (550 жил)

Бид орчин тойрноо яагаад бохирдуулдаг вэ?

В.



б. Дараах баримт тус бүрийг өөрийн үгээр найруулан бичихдээ, үзэл бодол ба дүгнэлтээр дэлгэрүүлээрэй. Үзэл бодлоо илэрхийлэхдээ таамаглах баймж утгат үг, бүтээврийг аль болох оновчтой сонгон хэрэглэхийг хичээгээрэй. Баримт ба үзэл бодлыг хооронд нь хэрхэн холбодгийг дээрх эхээс дахин нягталж ажиглаарай. Тухайлбал: “Хуучирч өнгө үзэмжээ алдсан хаалгануудыг будаж, шинэчлээд хашлага хийсэн бол хуучраагүй хаалгануудыг шууд ашиглажээ¹. Энэ ажил бусад байрныханд үлгэр дуурайл болж эхэлсэн аж². Зэргэлдээх байр нь ч ийм хаалга ашиглаж, хашлагуудаа шинэчилсэн байв³. Харахад бяцхан санаа боловч, ард нь том агуулга нуугдаж буй⁴.” гэсэн хэсэгт байгаа дөрвөн өгүүлбэрийн 1 ба 3 дугаар нь баримт, 2 ба 4 дүгээр нь үзэл бодол байна. Харин эдгээр өгүүлбэр нь өөр хоорондоо утгын нягт холбоотой байгааг анхаарах нь чухал байна.





Өнгөрсөн хоёр сард нийтийн эзэмшлийн 125 мянган шоо метр талбайд зүлэг, 20 мянган шоо метр талбайд цэцэг тарьж, 9000 шоо метр цэцгийн мандал байгуулсан байна. Энэ зун хур багатай, гантай байгаа учраас шинээр тарьсан зүлэг, мод, сөөгөнд хийх усалгааны давтамжийг нэмэгдүүлжээ.
(Сониноос)

Баримтаас үүдсэн миний үзэл бодол, дүгнэлт
.....
.....

Баримтаас үүдсэн миний үзэл бодол, дүгнэлт
.....
.....
.....
.....
.....

Хөрс нь:

- Хүн амьтны хүнс тэжээл болсон ургамал ногооны ургах орчин болдог;
- Ургамал амьтны амьдрах орчин болдог;
- Нүүрстөрөгчийн давхар ислийг үйлдвэрлэж хадгалдаг;
- Дулаан болон чийглэгийн горимыг зохицуулж байдаг;
- Ус, хог хаягдлыг шүүж хоргүйжүүлдэг;
- Барилга, эм зүй, гоо сайхны бүтээгдэхүүн үйлдвэрлэх үндсэн түүхий эд, материал болдог;
- Хаягдал ялзрах орчин болдог;
- Геологи, уур амьсгал, биологи, хүний түүхийн ул мөрийг хадгалж байдаг.

Хөрсний доройтолд нөлөөлөх хүний хүчин зүйл:

- Төлөвлөлтгүй хот суурин газар
- Замбараагүй хог хаягдал, ил задгай бохир ус угаадас, жорлон
- Замбараагүй зам харгуй
- Мал аж ахуй, бэлчээрийн даац
- Газар тариалан, ой мод ашиглалт
- Уул уурхай

(Сониноос)

Түймэрт өртсөн ойд хус, улиангар ургавал 15-20 жилийн дараа зулзаган мод үүсэж, 150-200 жилийн дараа үндсэн мод нь ургадаг. Түймэрт шатсан ой өөрөө сэргэж ургахыг хүлээвэл 30-40 жилийн дараа зулзаган ой үүсэж, 100-120 жилийн дараа хуучин хэвэндээ ордог.

(Сониноос)

Баримтаас үүдсэн миний үзэл бодол, дүгнэлт
.....
.....



26

Мэдээлэлд үндэслэж, асуудал дэвшүүлэн, үзэл бодлоо илэрхийлье.

1. Туул гол бохирдлоороо дэлхийд тавд орчхоод байна.
2. Туул ширгэвэл уул нурна.
3. Туул голын экосистемийг сайжруулах зорилгоор 11 бүл, 22 толгой минж үржүүлж байна. гэсэн өгүүлбэрээс үр дагавар харагдаж байна уу? Ямар өнгө аяс мэдрэгдэж байна вэ?
 - ♦ Туул гол - анхаарал татсан асуудал мөн үү.
 - ♦ Яагаад заавал минж гэж? Туул голыг аврагч нь минж юм бол түүний талаарх сонирхолтой баримтыг дэлгэе.



Тухайлбал:

- Канадын 5 центийн зоос дээр минжний зураг байдаг. Яагаад?
- Бобруйск хотод минжний 2 төрлийн хөшөө байдаг. Яагаад?
- Минжний гэр бүлд эцэг эх, өнгөрсөн жилийн болон энэ жилийн үр төл багтдаг байна. Ийм гэр бүл 2.9 кв.м талбайг эзлэн амьдардаг.
- Минжнүүд хэзээ ч загасаар хооллодоггүй.
- Нэг минжний гэр бүл өвлийн бэлтгэл хийхдээ ойролцоогоор 70 куб метр хэмжээний навч, холтос цуглуулдаг, гол мөрний цэвэрлэгч юм.
- Усны инженер гэгдэх минж нь Монгол орны “Улаан ном”-д бичигдсэн, ховор амьтан.
- Минж нь амьдарч буй газрынхаа төрх байдлыг өөрчлөн хувиргадаг, газар нутгийнхаа орчны бүтэц, бүрэлдэхүүнийг баяжуулж, биологийн бүтээмжийг нэмэгдүүлдэг байгаль хамгааллын ач холбогдол ихтэй, нөр их хөдөлмөрч амьтан аж.
- Гол бол голдрилоороо л урсана уу гэхээс салаалдаггүй. Харин минж голын олон салааг өвс, модны мөчрөөр босгож, усны урсцыг удаашруулдаг. Ингэснээр тухайн хэсгийн газарт шингэх ус нэмэгддэг юм. Мөн боосон хэсэгт усан тогтоол үүсэж бусад бичил биет, амьтан үржих боломж олгодог. Ингэж минж тухайн голын экосистемд байгалийн жамаар, алгуур нөлөө үзүүлдэг.
- Минжний тоо олшрох тусам л голын экосистемд сайнаар нөлөөлнө.
- Ховд голд минж нутагшуулах ажил 30 гаруй жил үргэлжилсэн. Одоо л нэг амьсгаа авахтай болж байна. ... 15 жилийн дараагаас л голын экосистемд нааштай өөрчлөлт орж эхлэх байх. Яагаад гэвэл манайд жил бүр болдог шар усны үер минжид халгаатай байдаг.
- Минжний эрийг нь борхин, эмийг нь минжүүхэй, төлийг нь дүдэр хэмээнэ.

Бичих дадлага: “Туул голоо аврахын тулд...” сэдвээр эх бичнэ.

- ♦ Салангид мэдээллээс чухал санааг хураангуйлна.
- ♦ 1,2,3 дугаартай өгүүлбэрийг эхийн бүтцийн дараалал болгоорой.
- ♦ Үзэл бодлоо эерэг мэдээлэлд тулгуурлан илэрхийлээрэй.
- ♦ Өмнө нь уншиж судалсан эх бичвэрүүдээс санаа аваарай.







БҮТЭЭЛЧ ДААЛГАВАР:

Баримт мэдээллийг задлан шинжилж, аливаа юмсын учир шалтгаан, үр дагаврын хамаарлыг таньж, үзэл бодлоо илэрхийлье.

1 дүгээр алхам: Графикт байгаа тоон мэдээлэл, нэр томьёо, юуг юутай хэрхэн харьцуулсныг ажиглаарай. Баримт нь юуг өгүүлж байна вэ?



2 дугаар алхам: Шалтгаан, үрийн харьцааг тодорхойлъё. Хоёр графикийн аль нь шалтгаан, аль нь үр дагавар болохыг илэрхийлсэн өгүүлбэр зохиогоорой.

3 дугаар алхам: Мэдээлэл цуглуулъя. Ийм үр дагаварт хүргэсэн шалтгааныг баримтаар нотолъё.

Байгалийн хүчин зүйл

Хүний хүчин зүйл

4 дүгээр алхам: Баримт мэдээллийг харьцуулан эргэцүүлъя. Яагаад жил бүр “Цөлжилттэй тэмцэх дэлхийн өдөр”, “Мод тарих өдөр”, “Усны өдөр”-ийг тэмдэглэдэг вэ?

5 дугаар алхам: Олсон баримт мэдээлэлдээ тулгуурлан асуудал ба түүний учир шалтгааныг оновчтой гаргая. Үзэл бодлоо үндэслэлтэй илэрхийлье.

Хүн төрөлхтний өмнө дэлхийн дулаарал, уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэн цөлжилт хэмээх аюул хаалга тогшиж байна. Дэлхий нийтийн асуудал болсон цөлжилт хурдсаж байна.....гээд үргэлжлүүлэн бичвэл дараах тодорхойлолтоос алийг нь сонгох вэ?

Байгальд хохирол учрахад зохих арга хэмжээ авч байгаа бол та ТЭМЦЭГЧ.	Хэрвээ байгаль орчноо сүйтгэж, цөлжилт бий болоход тодорхой хэмжээгээр нөлөөлж байгаа бол та ГЭМТЭН.
Хэрвээ цөлжилтөөс болж таны эрх зөрчигдөж байгаа бол та ХОХИРОГЧ.	Хэрвээ цөлжилтийн эсрэг юу ч хийхгүй, санаа зовохгүй байгаа бол та ХУВИА ХИЧЭЭГЧ.

6 дугаар алхам: Асуудлыг шийдэх гарцыг олж илрүүлъя. Монголчууд дуртай үедээ хөрөө сүх бариад ойгоос мод тайраад байдаггүй байжээ. Хэрвээ мод тайрсан бол хожуул дээр нь нойтон шороо асгадаг байв. Учир нь, модны хожуул дамжин газрын чийг, хөрсний ус ууршин алга болдог гэж үздэг байжээ. Би цөлжилтийн эсрэг юу хийж болох вэ?. Усны хомсдол, цөлжилт, агаарын бохирдлоос ангижирч, эрүүл орчинд амьдаръя гэвэл мод тарьж, арчлан хамгаалах ёстой юм байна. Мод тарих сайн үйлсэд сургууль, анги хамт олноо уриалъя гэвэл шалтгааныг тодруулаарай.



Өөрийгөө сорьё.

Наран түлш

“Нарлаг монгол” гэж ярьдаг маань учиртай.... Жилийн аль ч улиралд нарны гэрлээс их хишгийг бид зөвхөн дулаацах төдийгөөр ашиглаж байгаа маань хайран!

Нарны гэрлийг ашиглан цахилгаан эрчим хүч гаргаж авах юм бол үүн шиг хямд, түүн шиг барагдашгүй нөөц энэ хорвоод үгүй юм.

Наран авхай дэлхийд секунд тутамд дөчин тэрбум килокалорийн илч дулааныг илгээдэг. Хэрвээ бид дөчин тэрбум килокалорийн эрчим хүчээс дөрөвхөн килог ч билээ ашиглаж чадвал их хэрэг бүтээнэ.

Нарнаас жилдээ манай дэлхийд ирдэг эрчим хүч нь өнөөгийн дэлхий дахины жил бүрийн хэрэглэж байгаа эрчим хүчнээс 35000 дахин их ажээ. Ийм их илч-хүчийг ашиглаж чадахгүй дэмий талаар өнгөрөөсөөр байгаа нь хүн төрөлхтний үрэлгэн цамааны шинж.

Нарны гэрлийг цахилгаан эрчим хүч болгон хувиргаад ахуй амьдралдаа ашигладаг улс орны тоо нэмэгдсээр байна. Нарны гэрлээр том том орон сууц, зочид буудал, бүхэл бүтэн хотыг дулаацуулдаг боллоо. ...

“Суусан газраасаа шороо атгана” гэж монголчууд овсгоотой хүнийг хэлдэг. Тэгвэл зогссон газраасаа нар атгаж болох сон. Яаж, хэрхэн нарыг атгах вэ? Нарны гэрлийг ашиглав гээд наран авхай хэнээс ч татвар авахгүй, мөнгө нэхэхгүй, үнэрхэх ч үгүй.

Нарны эрчим хүчийг тусгай зайгаар хураан авч цахилгаан болгон ашиглахаас гадна галт шилээр гэрлийг төвлөрүүлэн нэг цэгт хураахтай адил аргаар толины тусламжтайгаар хуримтлуулан төвлөрүүлж, 4000 хүртэл хэмийн халуун илч гарган авдаг болсон тул нарны хишгийг хүртэж л чадвал юу ч хийж болох ажээ.

“... Монголд нарыг хазаарлах гэгч хүүхдийн тоглоом байхгүй юу” гэж ЮНЕСКО –ийн “Эх булаг” сэтгүүлд Бетти Уерттер хатагтай бичжээ. *(Л.Түдэв)*

Даалгавар	Асуулт
Үндэслэл нь	Эхийн хэддүгээр догол мөрт, ямар үг, өгүүлбэр?
Асуудал нь	Эхийн хэддүгээр догол мөрт, ямар үг, өгүүлбэр?
Шалтгаан нь	Эхийн хэддүгээр догол мөрт, ямар үг, өгүүлбэр?
Үр дагавар нь	Эхийн хэддүгээр догол мөрт, ямар үг, өгүүлбэр?
Баримт нь	Эхийн хэддүгээр догол мөрт, ямар үг, өгүүлбэр?
Санал, шийдэл	Эхийн хэддүгээр догол мөрт, ямар үг, өгүүлбэр?
Зохиогчийн үзэл бодол	Эхийн хэддүгээр догол мөрт, ямар үг, өгүүлбэр?
Дүгнэлт	Эхийн хэддүгээр догол мөрт, ямар үг, өгүүлбэр?
Үг, өгүүлбэрийн өнгө аяс	Доогуур зурсан үг, өгүүлбэрийн утга?



“Утаагүй гал гаргаж авах шидэт эх булаг”

Нар, салхи, ус гурав бол үнэ хөлс бага, олдоц ихтэйн гадна, байгаль орчинд ээлтэй, дээд зэргийн цэвэр түлш.



Наран авхай дэлхийд секунд тутамд дөчин тэрбум килокалорийн илч дулааныг илгээдэг.



Манай дэлхийг сансар хорвоогийн салхин илбэн таалж хөөрөгдөхдөө 2700т ваттын их эрчим хүч гаргадаг.



Хот айл бүрийн дэргэдүүр хоржигнон урсдаг горхи булгийн усны хүчийг ашиглан гал гаргаж авах бололцоо манайд харьцангуй их.

- “Нар, салхи, ус гурав бол үнэ хөлс бага, олдоц ихтэйн гадна, байгаль орчинд ээлтэй, дээд зэргийн цэвэр түлш.” гэсэн өгүүлбэрийг тонгоргон найруулж бичээрэй.
- “-н гадна” хэмээх зэрэгцүүлэн холбох үгийг **“мөн, бас, төдийгүй, -н зэрэгцээ, улмаар, түүнчлэн”** гэсэн үгээр солин найруулбал, аль нь хамгийн зохистой болохыг сонгож, тайлбарлаарай.
- Сурах бичгийн 96-р хуудсанд байгаа холбох үг, бүтээврээс сонгож, нар, салхи, усны тухай өгүүлсэн дээрх 3 өгүүлбэрийн утгыг дэлгэрүүлнэ үү.



Л.Түдэв “Бүтээлийн чуулган” XV ботиос “Салхин түлш”, “Усан түлш” гэсэн асуудал дэвшүүлсэн эхийг уншиж, хэлэлцүүлэг хийгээрэй.



Шалтгаан хэмээх нь ... алимад бүхний өөр өөрийнх нь урьд байж, өөрийг нь гаргаж өгдөг, өөрийг нь буй болоход нь тус болдог тийм юм. Тодорхой нөхцөлд өөр бусад юмс үзэгдлийг зайлшгүй төрүүлдэг зүйлийг шалтгаан гэх ба шалтгааны үйлчлэлээр төрж гарах буюу өөрчлөгдөж буй зүйлийг үр гэнэ. Шалтгаан, үрийг зөвхөн үүсээд, оршоод, эвдрэх мөнх бус буюу бодит юмс дээр ярьдаг.

Шалтгаан, үрийн дэс дараа хатуу чанд бөгөөд шалтгаан хувьсан өөрчлөгдөж, чанар өөр байдалд орж байж, үр гарахаас биш шалтгаан өөрийн чанарыг гээгээгүй үед үр боловсорч гарах нь үгүй. Шалтгаан нь цаг хугацааны хувьд ямагт үр дагавраас түрүүлдэг.

Тухайлбал, үр соёолж, нахиа гарахад үр дагавар болсон цэцэг ургана. Үүнээс шалтгаан, үр хоёул нэг дор оршихын баталгаа гарна...

(Г.Лувсанцэрэн “Буддын уламжлалт мэдлэг ухааны үндэс”)

5

ДЭВШҮҮЛСЭН АСУУДАЛ,
ҮЗЭЛ БОДОЛ, ДҮГНЭЛТИЙН
ХОЛБОО ХАМААРЛЫГ
ТАЙЛБАРЛАЯ



Эзэмших мэдлэг, чадвар

- ◆ Эхийг уншиж, ойлгон, сэдэв, гол санааг тайлбарлая.
- ◆ Дэвшүүлсэн асуудал, үзэл бодол, дүгнэлтийн холбоо хамаарлыг задлан шинжилж, тайлбарлая.

Эхийг уншиж, ойлгон,
сэдэв, гол санааг
тайлбарлая.

- ◆ Эхийг уншиж, ойлгох
- ◆ Эхийн сэдэв, гол санааг тайлбарлах

I

1

Эхийг уншиж, ойлгоё.

- Эхийг анхааралтай уншихдаа таалагдсан үг, өгүүлбэрийг тэмдэглэж уншаарай. Тэдгээр үг, өгүүлбэр яагаад таалагдсаныг тайлбарлаарай.
- Утгыг нь мэдэхгүй үг байвал хам сэдвээс нь тайлбарлаж, толь бичгээс лавлаарай.

XX зууны хамгийн гайхамшигтай өгүүллэг “Жонатан”-ы тухайд



Зөвхөн XX зууны ч төдийгүй, бүхий л хүн төрөлхтний соёл иргэншлийн түүхэнд хамгийн шилдэг нь байж ч магадгүй. Р.Киплинг нэгэнтээ хамгийн шилдэг зохиол гэж байх боломжгүй тухай "Дэлхийн хамгийн шилдэг тууж" хэмээх өгүүллэгтээ дурдсан байдаг. Гэвч "Жонатан Ливингстон хэмээх цахлай"-г хэн ч гэсэн үнэхээр гайхамшигтай зохиол гэж хүлээн зөвшөөрдөг юм.

...Өгүүллэг шатны гишгүүр мэт гурван хэсэгтэй. Тэдгээр нь яг өгсөх мэт өрнөлтэй. Энд би зохиолын үйл явдлыг ярих гэсэнгүй. Харин Бахын дэвшүүлсэн сэтгэлгээний утгыг зохиолынх нь үгээр дамжуулахыг хичээе.

Энэ бол Жонатан Ливингстон нэрт цахлай сүргийн сэтгэлгээ, амьжиргааны дорд хэвшлээс ангижирч, туйлын дээд гэгээрэлд хүрч байгаа тухай зохиол. Мэдээж хэрэг, бусдаасаа өөрөөр нисдэг цахлайн тухай биш, энэ бол бэлгэдлийн утга. Зохиолч гэгээрлийг энд НИСЛЭГ хэмээжээ. ...Олонхын хувьд нислэгт утга учир байдаггүй. Гол нь ходоодоо тэжээхэд бүлгээ...

Бүхнээс хол, бүхнээс өндөрт нисэх гэсэн цахлайд эцэг эх нь "Элдвийг бодолгүй хоолоо олж идэж сур" хэмээдэг. Үүнийг нь дагаж явахдаа Жонатан:

- Хоол бэдэрсэн энэ бүх цагийг нисэхийн цаад учрыг олоход зарцуулсан бол доо! гэж харамсан бодож, ахуйн аар саар дарамтыг хөсөр орхихоор зэхэж байна.

Жонатан бол бурхан шувуу биш, ердийн л цахлай. Гагцхүү сүргийн сэтгэлгээнээс чөлөөлөгдөж чадсанаараа, туйлын дээд гэгээрэлд тэмүүлдгээрээ онцгой, эрх чөлөөнд дуртай нэгэн юм. Ийм хувь хүн (цахлай) бусдын дунд зохицох чадваргүй байдаг. Гэвч Жонатан хэзээ ч хар амиа бодож байсангүй. Тэр өөрийн хүрсэн өндөрлөг, таньсан мэдлэгээ бусадтай хуваалцахыг нээж олсон дэвшилтэт шинэ бүхнийхээ ололтыг бусдадаа хүргэхийг чармайдаг. Жонатаны оргил өөд (нисэхийг нь) харах цахлай сүргийн дотор байсангүй. Тэд нүдээ нээж харахаас татгалзжээ. Ингэснээрээ сүрэг цахлай гайхамшигт жигүүрээ идэш хоол хайх, өөр хоорондоо хоол булаалдан тэмцэлдэхэд л хэрэгтэй хязгаарлагдмал зэмсэг болгосноо илтгэнэ.

Сүргээс хөөгдсөн цахлай өдөр ирэх тусам бясалгалын гүнд автсаар байдаг. Түүний ухаарлыг ийн томьёолсон байна. "Бүүдгэр саарал уйтгар, айдас, атгаг муу санаа. Энэ бүхэн л амьдрал ийм харамсмаар богинохон байгаагийн гол шалтгаанууд мөн. Хоол, тэмцэл, сүргийн дотор олж авсан эрх нөлөө гэдэг бүх зүйл огтхон ч биш" Ийнхүү Жонатан цахлай ганцаар бясалгалын замд орж байна. ...Аливаа бүхний анхдагч шалтгааныг ойлгох, юуны тулд амьдарч яваагаа таних боломж одоо л бидэнд олдлоо!



Азаар тэр тэнгэрийн шувуудтай тааралддаг. Тэд үнэндээ тэнгэрийн шувууд биш, гэгээрсэн (нисэхийн урлагт нэвтэрсэн) цахлайнууд л даа. Жонатан урьдынхаас өөр ертөнцөд очжээ. Гэхдээ бусад шувуу түмэнтээ амьдарч, төрөл арилжиж байж очих тэр цаг үед нэгэн насандаа хүрч чадав. Зохиолд "Цахлай хэдийчинээ өндөрт ниснэ төдийчинээ алсыг үзнэ" гэж тун энгийн, гэхдээ урнаар үүнийг тайлжээ.

Ингээд Жонатан газар дэлхий рүү, өөрийг нь хөөсөн сүрэг рүү буцаж ирдэг. Өөр шиг нь хөөгдөж ганцаардсан өөрөөр сэтгэгчдийн зовлонг түүнээс илүү мэдэх хэн байх сан билээ. Сүрэг ч, сүргээс хөөгдөгчид ч анхандаа түүнийг бурхан цахлай л гэж боддог. Хөөгдмөл Жонатан ийм ер бусын шидийг олсон гэж хэний ч толгойд орсонгүй. Харин Жонатан бидний мэдэх тэнгэрийн цаад мандалд буй төгс өртөнцийн нислэгийг дэлхийн цахлайнуудад зааж сургана. Жамаараа явж гэмээн түмэн жилийн дараа л хүрэх тэр цаг үеийг нь сүрэгтээ авчрахыг зорьсноороо Жонатан хэчнээн мянган удаагийн амьдралыг хэмнэж чадав.

Хүн (цахлай) бүхний дотор жинхэнэ Жонатан цахлай нь орших бөгөөд тэр л үнэнд хөтлөгч багш, өөр ямар ч найдах зүйл үгүй гэсэн санаа зохиолд нэвт шингэсэн байдаг. Эцэст нь Жонатан тэнгэрийн цаад руу нисэн оддог бөгөөд түүнийг залгамжлагч Флетч цахлай шавь нартаа “хязгааргүй” номлон, танин мэдэхүйн замаа тавина.

“Бид хэн юм бэ?”, “Энд бид юу хийгээд байгаа билээ?”

“Ер нь бид хаачиж яваа юм бэ?” гэсэн мөнхийн асуултуудад үүнээс өөр ямар ч ном хариу өгч чадахгүй гэсэн санал элбэг байдаг. Таны амьдралд ч Жонатан өөрчлөлт оруулж юун магад.

(Г.Аюурзана)

в. Дараах асуултад эхээс жишээ авч тайлбарлаарай.

- ♦ “Сүргийн сэтгэлгээ” – “сүрэг” гэсэн үгийн утгыг чи юу гэж ойлгож байна вэ?
- ♦ “... Жонатан Ливингстон нэрт цахлай сүргийн сэтгэлгээ, амьжиргааны дорд хэвшлээс ангижирч” гэсэн өгүүлбэрийн санааг чи юу гэж ойлгож байна вэ?
- ♦ Зохиолч гэгээрлийг яагаад НИСЛЭГ –тэй зүйрлэж нэрлэсэн бэ?
- ♦ Жонатаны оргил өөд (нисэхийг нь) харах цахлай сүргийн дотор байсангүй. Тэд нүдээ нээж харахаас татгалзжээ. Яагаад?
- ♦ Чиний амьдралд Жонатан байна уу? Тэрээр, чиний амьдралд өөрчлөлт оруулж байсан уу?
- ♦ Хүн бүхний дотор жинхэнэ Жонатан (цахлай) оршдог уу? Чи юу гэж бодож байна вэ?

г. Эхийн цогцолбор тус бүрийн гол өгүүлбэрт үндэслэн сэдэв, гол санааг тодорхойлоорой.

Энэ бол Жонатан Ливингстон нэрт цахлай сүргийн сэтгэлгээ, амьжиргааны дорд хэвшлээс ангижирч, туйлын дээд гэгээрэлд хүрч байгаа тухай зохиол.	Сэдэв ?
<ul style="list-style-type: none"> ♦ Бүхнээс хол, бүхнээс өндөрт нисэх гэсэн цахлайд... ♦ Гагцхүү сүргийн сэтгэлгээнээс чөлөөлөгдөж чадсанаараа, туйлын дээд гэгээрэлд тэмүүлдгээрээ онцгой. ♦ Цахлай хэдийчинээ өндөрт ниснэ, төдийчинээ алсыг үзнэ. ♦ Жонатан хэчнээн мянган удаагийн амьдралыг хэмнэж чадав. ♦ Хүн (цахлай) бүхний дотор жинхэнэ Жонатан цахлай нь орших ... 	Гол санаа ?

Дэвшүүлсэн асуудал, үзэл бодол, дүгнэлтийн холбоо хамаарлыг задлан шинжилж, тайлбарлая.

- ◆ Эхийн дэвшүүлсэн асуудал, тайлбар, үзэл бодол, дүгнэлтийг олж, тайлбарлах
- ◆ Эхийн дэвшүүлсэн асуудал, тайлбар, үзэл бодол, дүгнэлтийн уялдаа холбоог задлан шинжилж, тайлбарлах
- ◆ Өгүүлбэрүүдийг учир шалтгаанаар зөв холбон найруулах, дэлгэрүүлэн тайлбарлах
- ◆ Үгийн сангийн найруулгын үүргээс мэдэх




2

Эхэд дэвшүүлсэн асуудал, тайлбар, үзэл бодол, дүгнэлтийг олж, тайлбарлах

а. Эхийг дахин анхааралтай уншаад, дараах хүснэгтийн дагуу ажиллаарай.

Дэвшүүлсэн асуудал	Эхийн хэддүгээр догол мөрт, ямар үг, өгүүлбэр?
Тайлбар	Эхийн хэддүгээр догол мөрт, ямар үг, өгүүлбэр?
Үзэл бодол	Эхийн хэддүгээр догол мөрт, ямар үг, өгүүлбэр?
Дүгнэлт	Эхийн хэддүгээр догол мөрт, ямар үг, өгүүлбэр?

б. Эхэд хийсэн задлалд үндэслэн, дараах асуултад хариулаарай.



в. Дараах асуух өгүүлбэрүүд эхэд дэвшүүлсэн асуудал мөн үү? Мөн бол яагаад? Үгүй бол яагаад?

Бид хэн юм бэ?
Энд бид юу хийгээд байгаа билээ?
Ер нь бид хаачиж яваа юм бэ?



г. “Жонатан цахлай” зохиол бол шилдэг гэсэн өөрийн үзэл бодлыг зохиогч тухайн зохиолын талаарх тайлбараар баталж чадсан уу? Энэ зохиолын үнэ цэнтэй, шилдэг байж болох санаа нь чинийхээр юу вэ? Үзэл бодлоо эхийн баримтаар илэрхийлээрэй.

д. “Тайлбар - холбоос - дүгнэлт” гэсэн бүтцийг ажиглаад, яагаад тайлбар, яагаад дүгнэлт болж байгааг, тэдгээр нь яаж холбогдож байгааг тайлбарла.

Жонатаны оргил өөд (нисэхийг нь) харах цахлай сүргийн дотор байсангүй. Тэд нүдээ нээж харахаас татгалзжээ.

Ингэснээрээ

...сүрэг цахлай гайхамшигт жигүүрээ идэш хоол хайх, өөр хоорондоо хоол булаалдан тэмцэлдэхэд л хэрэгтэй хязгаарлагдмал зэмсэг болгосноо илтгэнэ.



Дэвшүүлсэн асуудал, тайлбар, үзэл бодол, дүгнэлтийн уялдаа холбоог задлан шинжилж, тайлбарлая.

- Эхийн “Дэвшүүлсэн асуудал, тайлбар, үзэл бодол, дүгнэлт”-ийг жишээгээр загварчлан үзүүлэв. Эдгээр хэсэг нь учир зүйн уялдаа холбоотой байгааг өнгөөр ялгасан үг, өгүүлбэрт үндэслэн тайлбарлаарай.
- Эхийн хэсгүүдийн уялдаа холбоог үргэлжлүүлэн загвараар үзүүлж, дэлгэрэнгүй тайлбарлаарай.



- Эхийн холбоосуудыг олж, утгыг ярилцаад, тэдгээр нь “Дэвшүүлсэн асуудал, тайлбар, үзэл бодол, дүгнэлт”-ийн холбоо хамааралд ямар үүрэгтэйг тайлбарла.



Үг, өгүүлбэр, цогцолборыг зэрэгцүүлэн холбох үгс
Салгах, ялган онцлох: ба, буюу, бөгөөд, болон, болоод, агаад, хийгээд
Эсрэгцүүлэн холбох: гэвч, авч, боловч, гэтэл, атал, бөгөөтөл, эсвэл, нэг бол, ч, гэсэн, тэгтэл, тэглээ ч, гэсэн, харин
Лавшруулан холбох: мөн, байтугай, үл барам, барахгүй, өөрөөр хэлбэл, цаашилбал, түүнчлэн, бас
Тайлбарлан холбох: иймээс, ийм учраас, иймд, ингэхлээр, хэрэв, тиймээс, тийм учраас, тэгэхлээр
Үг, өгүүлбэр, цогцолборыг угсруулан холбох үгс нь:
орчим, гаруй, шахам, дахин, удаа, хавьцаа, эргэм, шиг, мэт, адил, чинээ, тушаа, турш, бүр, тухай, талаар, хүртэл, төлөө, тулд, учраас, улмаас, дагуу, ялдамд, дашрамд, хэрд, болбол, аваас, бөгөөс, дор, тутам, алдад, үед, замд

- а. Дараах өгүүлбэрийн санааг эвдэлгүй, учир шалтгааны холбоосоор холбож, нэг нийлмэл өгүүлбэр болгоорой. Өгүүлбэрүүдийн байрыг сольж болно. Найруулга, санааг нягтлаарай.

1. Сүрэг ч, сүргээс хөөгдөгчид ч анхандаа түүнийг бурхан цахлай л гэж боддог.	Хөөгдмөл Жонатан ийм ер бусын шидийг олсон гэж хэний ч толгойд орсонгүй.	
2. Жонатаны оргил өөд (нисэхийг нь) харах цахлай сүргийн дотор байсангүй.	Тэд нүдээ нээж харахаас татгалзжээ.	Сүрэг цахлай гайхамшигт жигүүрээ идэш хоол хайх, өөр хоорондоо хоол булаалдан тэмцэлдэхэд л хэрэгтэй хязгаарлагдмал зэмсэг болгосон.

- б. Эхний өгүүлбэрийн учир шалтгаанаас үүдэн гарах үр дагаврыг гүйцээж бичээрэй. Утга найруулгын хувьд зөв холбосон эсэхээ хянаарай.

1	Сүргээс хөөгдсөн цахлай өдөр ирэх тусам бясалгалын гүнд автсаар байдаг.	тул
2	Бүүдгэр саарал уйтгар, айдас атгаг муу санаа. Энэ бүхэн л амьдрал ийм харамсмаар богинохон байгаагийн гол шалтгаанууд мөн.	Яагаад гэвэл
3	Хоол, тэмцэл, сүргийн дотор олж авсан эрх нөлөө гэдэг бүх зүйл огтхон ч биш.	учраас

- в. "Жонатан Ливингстон хэмээх цахлай" эхээс авсан дараах асуултын дагуу үзэл бодлоо илэрхийлж ярилцаарай.

Бид хэн юм бэ? Энд бид юу хийгээд байгаа билээ?
Ер нь бид хаачиж яваа юм бэ?

Ярилцахдаа:

- ♦ "...Жонатан Ливингстон нэрт цахлай сүргийн сэтгэлгээнээс ангижирч" гэсэн зохиолын санаанаас үүдэн хувь хүний үзэл бодлын үнэ цэнийг эргэцүүлэх
- ♦ Тухайн сэдвийг чи аль өнцгөөс харж, юу гэж ойлгож байгаагаа илэрхийлэх
- ♦ Ярилцагчийн байр суурь, үзэл бодлыг хүндэтгэн, өөрийн байр сууриас хазайлгүй ярих

Гэртээ: Эхийг уншсанаар Ричард Бахын ХХ зууны хамгийн гайхамшигтай өгүүллэг болох "Жонатан Ливингстон цахлай" – зохиолыг уншмаар санагдаж байна уу? Уншаад ангиараа сэтгэгдэл, үзэл бодлоо илэрхийлж ярилцаарай.



5

Дэлгэрүүлэн тайлбарлан бичих чадвараа хөгжүүлье.

- Д.Нацагдоржийн “Дөрвөн цаг” шүлгийн шүүмжийн санааг дэлгэрүүлэн, нэг цогцолборт багтаан, тайлбарлаж бичээрэй.
- Цогцолборуудаа холбоос ашиглан, холбоорой.
- Бичих санаагаа зохиогчийн санаатай аль болох уялдуулахыг хичээгээрэй.

Зохиол бүтээл гэдэг дангаараа цогц зүйл биш, тайлбартайгаа хамт байж бүтэн болоход илүү ойртож очдог. Түүнд хэчнээн олон шүүмж, тайлал нэмэгдэнэ, тэр хэрээр төгс байдалдаа ойртоно. (С.Энхбаяр)

Д.Нацагдоржийн шүлгийн талаарх дүгнэлт, сэтгэгдэлтэй уялдуулан, шүлгийн санаа, сэдвийн товч тайлбар бичээрэй.

Энэ бол манай яруу найргийн оргил, дээд ололт. Мөр бүрийг уншаад гүйцэхэд сэтгэлийн дотор намрын салхи сэвэлзэж, гунихын хамтаар амьдрал гэж ямар сайхан зүйл болохыг гэнэт олж харах шиг болдог... (Г.Аюурзана)



Урьхан хонгор салхи өвс модыг намилзуулахад
Хөгшин залуу хүмүүсийн сэтгэл бөн бөн бөмбөрнө.
Шарласан модны навч хоёр нэгээр унахад
Сэтгэлийн доторх уйтгарт явдал хааяа хааяа бодогдоно.
(Д.Нацагдорж “Намар”)

Нулимс бөмбөрөм дээрх бадгийг сэтгэл догдлохгүй уншихын аргагүй бөгөөд бидний ердийн ярианд хэрэглэдэг үгс яахаараа Нацагдоржийн шүлгүүдэд ийм ер бусын ид шидтэй мэт байраа яг таг эзэлж, сэтгэл рүү цутгах мэт орж ирээд, хамаг эд эсийг тэмтрэх мэт болдог байна аа!

“Өвс модыг намилзуулахад”,
“Сэтгэл бөн бөн бөмбөрнө”,
“Навч хоёр нэгээр унана” ... (О Дашбалбар)


О.Дашбалбарын “ердийн ярианд хэрэглэдэг үгс яахаараа ...ийм ер бусын ид шидтэй мэт байраа яг таг байраа эзэлж” гэсэн дүгнэлт, сэтгэгдлийг дэлгэрүүлэн, дээрх 4 мөрөөс сонгон, шүлгийн үг сонголт оновчтой болсныг баталж тайлбар бичээрэй.

“Түүний шүлгүүдийг уншсаны эцэст ...” үргэлжлүүлэн 4 мөртийн талаар үзэл бодлоо бичээрэй.



Үгийн сангийн найруулгын үүргээс мэдье.
Мэргэжлийн үг хэллэг, нэр томьёоны найруулгын үүргийг тодорхойлж, зөв сонгон хэрэглэе.

- а. Мэргэжлийн үг хэллэг, нэр томьёоны жишээг ажиглаад, тус бүрийн тодорхойлолтыг гаргаарай.



- б. Бусад мэргэжлийн үг хэллэг, нэр томьёог жагсаан бичээд, мэргэжлийн үг хэллэг, нэр томьёоны ялгааг тодруулж, тайлбарлаарай.

- в. Ярилцаарай.

- ◆ Эдгээр үгийг орчуулж хэрэглэж болох уу? Үгүй бол яагаад? Тийм бол жишээ хэлээрэй.
- ◆ Эдгээр үг салаа утгатай юу? Ганц утгатай юу? Яагаад?
- ◆ Сэтгэлийн хөдөлгөөн илтгэх үү?
- ◆ Нэр томьёо нь шинжлэх ухааны хөгжлийг даган шинээр бий болж байдаг. Ийм жишээ дурдана уу.
- ◆ Зарим нэр томьёо нийт олонд танил байхад, заримыг нь зөвхөн тухайн мэргэжлийн хүмүүс мэддэг. Ийм үгийн жишээ хэлээрэй.

- г. Тодорхой мэргэжлийн нэг ойлголтыг сонгон, мэргэжлийн үг хэллэг, нэр томьёог ашиглан, товч тайлбар бичээрэй. Нэр томьёог зөв бичихэд анхаарна уу.

Жишээлбэл:

- ◆ Өгүүлбэрийн гишүүд
- ◆ Тэгшитгэл
- ◆ Химийн урвал
- ◆ Энерги хадгалагдах хууль
- ◆ Ургамлын өнгө ...



Өөр өөр цаг үед бичигдсэн ижил сэдэвтэй зохиолын үгийн санг харьцуулан дүгнэе.

- а. Монгол улсын үе үеийн төрийн сүлд дууллын үгийг харьцуулан уншаарай.
- б. Аль эхэд чамд ойлгомжгүй үг их байна вэ? Яагаад? Үгийн утгыг толь бичиг болон багшаасаа лавлаарай.
- в. 1, 3 дугаар эхийн мөр бүрийг харьцуулан, ямар үг, санааг, ямар үг, санаагаар сольсныг ажиглаж, яагаад гэдгийг ярилцаарай.
- г. 1, 3 дугаар эхэд давтагдсан ямар санаа, үг байна вэ? Тайлбарлаарай.
- д. Аливаа уран бүтээл тухайн нийгэм, цаг үеийнхээ тусгал байдгийг 1, 2 дугаар эхийн үгийн сонголтод үндэслэн тайлбарлаарай.

Монгол улсын төрийн сүлд дуулал

Эх 1 Үг. Ц.Дамдинсүрэн 1950

Дархан манай хувьсгалт улс
Даяар монголын ариун голомт
Дайсны хөлд хэзээ ч орохгүй
Дандаа энхжиж, үүрд мөнхөжнө.

Дахилт

Хамаг дэлхийн шударга улстай
Хамтран нэгдсэн эгнээг бэхжүүлж
Хатан зориг, бүхий чадлаар
Хайрт монгол орноо мандуулъя.

Алдарт Ленин, Сталины заасан
Ардын төлөө, жаргалын замаар
Агуу монгол орноо удирдсан
Ачит Сүхбаатар, Чойбалсан

Дахилт

Зоригт монголын золтой ардууд
Зовлонг тонилгож жаргалыг эдлэв
Жаргалын түлхүүр, хөгжлийн тулгуур
Жавхлант манай орон мандтугай.

Дахилт

Эх 2 Үг. Ц.Гайтав, Ч.Чимид 1961

Урьдын бэрх дарлалыг устгаж
Ардын эрх жаргалыг тогтоож
Бүх нийтийн зоригийг илтгэсэн
Бүгд Найрамдах улсаа байгуулсан

Дахилт

Сайхан монголын цэлгэр орон
Саруул хөгжлийн дэлгэр гүрэн
Үеийн үед энхжин бадартугай.
Үрийн үрд бэхжин мандтугай.

Ачит нам алсыг гийгүүлж
Хүчит түмэн улсыг хөгжүүлж
Буцашгүй зүтгэл дүүрэн хөвчилсөн
Цуцашгүй тэмцэл түүхийг товчилсон

Дахилт

Зөвлөлт оронтой заяа холбож
Дэвшилт олонтой санаа нийлж
Хандах зүгийг бахтай барьсан
Мандах коммунизмыг цогтой зорьсон

Дахилт

Эх 3 Үг. Ц.Дамдинсүрэн нар 2006

Дархан манай тусгаар улс
Даяар монголын ариун голомт
Далай их дээдсийн гэгээн үйлс
Дандаа энхжиж, үүрд мөнхөжнө.

Хамаг дэлхийн шударга улстай
Хамтран нэгдсэн эвээ бэхжүүлж
Хатан зориг, бүхий л чадлаараа
Хайртай монгол орноо мандуулъя.

Өндөр төрийн минь сүлд ивээж
Өргөн түмний минь заяа түшиж
Үндэс язгуур, хэл соёлоо
Үрийн үрдээ өвлөн бадраая.

Эрэлхэг монголын золтой ардууд
Эрх чөлөө жаргалыг эдлэв.
Жаргалын түлхүүр, хөгжлийн тулгуур
Жавхлант манай орон мандтугай.



Өөрийгөө сорьё.

- а. Эхийн нэрээс юуны тухай эх болохыг таамаглан ярилцана. Эхийг гүйлгэн уншаад, эхийн агуулгыг ярилцана. Эхийг дахин нарийвчлан уншина.

Эрдэнэ нуусан ухаан буюу Б.Золбаярын монгол эсээ

"... Дүмбэнд нэг их сайхан цагаан манан татна. Хүүгтэл хүүгтэл урсаад л. Ийм цагаан манан дунд нь эрхэлж суух сайхан. Юу ч харагдахгүй зөвхөн цагаан манан. Энүүхэнд үсрүүний тарвага тан тан хийж, тэрүүхэн ойроос хонь майлаад, тэртээ зүүн нуруунд хонио алдсан ч юм уу, адууны эрэлчний ч юм уу, бүдэг бадаг хашхираан гуаглааныг сонсож, тэр гуай юу, энэ гуай юу гэж таамаглаж суух хачин сайхан. Хажууд гөлмийг нь шууж чөдөрлөсөн морины амгайвчилсан хазаарын амгай зуузай харшиж, өвс ширд ширд хийлгэн хазлах дуу чимээний сонсголонтой нь ер бусын. Дүмбэнгийн мөөг ийм л мананд товойтол товойтол ургана. Мөнгөн баавар цувуулаад асгачихсан юм шиг цувраад цувраад ургачихсан Дүмбэнгийн мөөгнөөс үзэсгэлэнтэйг хараагүй дээ" мөн ч сайхан дүрсэлжээ ...

(Б.Золбаяр "Бундан зүрхний Дүмбэн" эхээс)

...Монголчууд бид их талын амьд байгалийн дунд тарвалзаж байдаг улс. Тиймдээ ч орон хот, байшин саванд шунамгай, дурламтгай. Гэтэл Европ Америкийн их хотын шуугиант ахуйд төрөгсөд чимээ шуугиангүй, атар онгон байгальд амиа тавьдаг улс.

Б.Золбаярын "Бүгээн"-ийг уншихад аргагүй гоо сайхны мэдрэмжийг сэмлэн, сэтгэл сэртхийлгэж, энэ бүх сайхан сэмрэн урагдаад алга болчих вий дээ гэж шаналгана. Энэ гоо сайхан нь Ховдын Чандманийн, зөвхөн Монголын содон сонин биш, бүр Евро-Азийн нүүдэлчдийн төдийгүй энэ зууны манай цэнхэр өнгөтэй байсан гаргийн маань гоо сайхан болчхоод байгаа юм даа. Тиймдээ ч зөвхөн үүнийг л дэлхийн хүн ардын оюун сэтгэлд хүргэж чадсан тэр монгол зохиолчийг би Нобелийн лекцээ уншина гэдэгт эргэлздэггүй дээ.

Заншил ёс нь байтугай, түүнийг тэмдэглэх үг нь ч алга болох гээд байгаа өнөө үед мартагдаж байгаа ёс заншил, түүнийг тэмдэглэсэн амьд үг хэллэг, чухам үүнийг л Золоо эсээндээ авч үлдсэн нь олзуурхмаар зүйл. Чухамдаа, ардын эрдэнэ нуусан ухаан гэж үүнийг л хэлэх болов уу.

Б.Золбаяр монгол хүний, тэр дундаа малчин монгол хүний бодол ухаарал, ёс заншил, аяг даатхалыг тун нарийн мэдрэмжтэй гаргаж чаджээ. ...Золбаяр тэр гоо сайхныг танин мэдэж, сэтгэл зүрхээрээ хүлээн аваад оносон тохирсон үгээр яв цав илэрхийлэх

хосгүй авьяастан лавтай мөн байна.

Үнэндээ өнөөдөр Монголд маань жинхэнэ хөдөөний юм бүхэн илэрхий сарнин алга болж байна шүү дээ. Үүнтэй хамт гоо сайхныг мэдрэх, амтлах монгол хүний мэдрэмж тэр хэмжээгээр л алга болж байна гэсэн үг. Үнэхээр харамсалтай хэрэг.


...Бидний ой санамжаас алдагдчих гээд айлгаад байгаа, нүүдэлчин удмын бидэнд хосгүй үнэтэй тэр л ахуй байдлыг өнөөдрийн дэлхийн уншигчид хүсэн



хүлээгээд байх шиг ээ. Малаа маллаад, хайрлаад, бахархаад, өсгөж үржүүлээд, үр шимийг нь хүртээд явна гэдэг монгол хүнд хосгүй гайхамшиг юм даа. Энэ гайхамшигийг маань өнөөгийн хотожсон Монголын залуу үе ойлгохдоо нэг л хөшүүн болчихжээ.

Үнэндээ, нүүдэлчин аж төрөх ёсоо алдана гэдэг монголчуудын хувьд мөхөл сөнөлтэй тэнцэж очих хэцүү хэрэг юм. Үүнийг л ухааруулж чадвал манай ирээдүйн өнгө төрх тодроод ирнэ. *(Ч.Билэгсайхан)*


- б. Эхээс ялгасан дараах өгүүлбэрийг уншаад, эхэд дэвшүүлсэн асуудлыг бичээрэй. Асуудлыг шийдвэрлэхэд чи ямар хувь нэмэр оруулж чадах вэ? ярилцаарай.



- в. Эхийг дахин анхааралтай уншаад, дараах даалгаврыг хийгээрэй. Эхийн хэсгүүдийг ямар үг, өгүүлбэрээс таньснаа жишээгээр тайлбарлаарай.

Дэвшүүлсэн асуудал	Эхийн хэддүгээр догол мөрт, ямар үг, өгүүлбэр?
Тайлбар	Эхийн хэддүгээр догол мөрт, ямар үг, өгүүлбэр?
Үзэл бодол	Эхийн хэддүгээр догол мөрт, ямар үг, өгүүлбэр?
Дүгнэлт	Эхийн хэддүгээр догол мөрт, ямар үг, өгүүлбэр?


- г. Дээрх задлалд үндэслэн, дараах асуултын дагуу тайлбарлан яриарай.



Тайлбарлан ярихдаа санаа аваарай.

- ◆ Зохиолын ач холбогдлыг юу гэж тайлбарласан бэ?
- ◆ Зохиолын бусдаас ялгарах онцлогийг юу гэж тайлбарласан бэ?
- ◆ Тухайн бүтээл цаг үеэ олсон эсэх талаар ямар дүгнэлт гаргасан бэ?
- ◆ Зохиолын хэл найруулгыг юу гэж үнэлсэн бэ?

- д. Эхийн дэвшүүлсэн асуудал, үзэл бодол, тайлбар, дүгнэлтүүд нь ямар үг, өгүүлбэрээр холбогдож байгааг нэг бүрчлэн тайлбарлаарай.
- е. Зохиогчийн дараах санааг Б.Золбаярын “Бундан зүрхний Дүмбэн” эхийн хэсгээс батлан тайлбарлаарай.
- ◆ Золбаяр, тэр гоо сайхныг танин мэдэж, сэтгэл зүрхээрээ хүлээн аваад, оносон тохирсон үгээр яв цав илэрхийлэх хосгүй авьяастан лавтай мөн байна.
 - ◆ ... уншихад гоо сайхны мэдрэмжийг сэмлэн, сэтгэл сэртхийлгэж...
 - ◆ Б.Золбаяр монгол хүний, тэр дундаа малчин монгол хүний бодол ухаарал, ёс заншил, аяг даатхалыг тун нарийн мэдрэмжтэй гаргаж чаджээ.
- ё. Өмнөх хуудсан дахь “б” даалгаврын дэвшүүлсэн асуудлаар баримтад үндэслэн, үзэл бодлоо илэрхийлж, баталж, үгүйсгэж ярилцаарай.



Өөрийгөө сорьё.

	Шалгуур	оноо
1	Эхийн дэвшүүлсэн асуудал, тайлбар, үзэл бодол, дүгнэлтийг ялгаж чадаж байна уу?	3
2	Эхийн дэвшүүлсэн асуудал, тайлбар, үзэл бодол, дүгнэлт тэдгээрийн уялдаа холбоог олж, тодорхойлж чадаж байна уу?	3
3	Эхийн шүүмжийн санаанд уялдуулан товч тайлбар хийж чадаж байна уу?	2
4	Зохиолын үгийн сангийн сонголт нь нийгмийн хөгжлийг даган өөрчлөгдөж байдгийг мэдсэн үү?	1
5	Мэргэжлийн үг хэллэг, нэр томъёоны найруулгын үүргийг тодорхойлж сурсан уу?	1

6

БАРИМТАД
ҮНДЭСЛЭН
САНААГАА
ИЛЭРХИЙЛЬЕ



Эзэмших мэдлэг, чадвар

- ◆ Сэдвийн хүрээнд баримт мэдээлэл цуглуулж, эмхлэн цэгцэлье.
- ◆ Баримтад үндэслэн тайлбарлан бичье.


Сэдвийн хүрээнд баримт мэдээлэл цуглуулж, эмхлэн цэгцэлье.

- ◆ Бичих сэдвээ сонгох
- ◆ Сэдвийн хүрээнд судалгаа хийж, баримт мэдээлэл цуглуулах
- ◆ Баримтаа шинжлэх
- ◆ Баримтаа цэгцлэх

I

1

Баримтын талаар ярилцъя.



а. Асуултын дагуу ярилцаарай.

Баримт гэж юу вэ?

- ◆ Бид яагаад баримтад үндэслэж, санаагаа илэрхийлэх ёстой вэ?
- ◆ Баримтад үндэслэхийн ач холбогдол юу вэ?
- ◆ Хангалттай баримт гэж ямар баримтыг хэлэх вэ?
- ◆ Баримт ба үзэл бодлын ялгаа юу вэ?
- ◆ Баримтыг үзэл бодолдоо тохируулан өөрчилж болох уу?



Яагаад баримтад үндэслэх гэж?

- ◆ Үнэн бодитойг батлахад ...
- ◆ Үнэн бодитой байдалд уншигчдыг итгүүлэхэд ...
- ◆ Үзэл бодлыг үгүйсгэх юм уу, хамгаалахад ...
- ◆ Уншигчдыг итгэтэл, гайхтал, ийм юм байдаг аа гэж бодуулахад ...

Ямар баримт сайн бэ?

- ◆ Баримтад тавигдах үндсэн шаардлага - "ҮНЭН" байх
- ◆ Баримт сонирхолтой байх
- ◆ Баримтын эх сурвалж найдвартай байх
- ◆ Уншигчдад нөлөөлөх, итгэл үнэмшил төрүүлэхүйц байх



2

Бичих сэдвээ сонгож, баримт цуглуулъя.

- а. Бүлгээрээ ярилцаад, баримтад үндэслэн, тайлбарлан бичих, сонирхолтой, чухал 5 сэдвийн жагсаалт гаргаарай.

Жишээ нь:

Ном уншихын ач тус

Эх хэлээ хамгаалъя.

Ярих чадвараа хөгжүүлэх нь

Үндэсний бичгээ судлан, суралцахын учир

Амжилттай суралцахын нууц

- б. Юуны тухай, ямар зорилгоор, хэнд бичих вэ? гэдгээ ярилцаарай.

Сэдэв: Хэний, юуны тухай бичих вэ? Энэ асуудал яагаад чухал вэ?

Зорилго: Энэ эхийг бичихийн зорилго юу вэ?

Жишээ нь: Тухайн сэдвийн чухал болохыг батлан тайлбарлах

Уншигч: Чи хэнд зориулж бичих вэ?

Жишээ нь: Ангийн хүүхдүүд, олон нийт ...

Хэмжээ: 2-3 цогцолборт, нэг нүүрэнд багтааж бичнэ гэх мэт.

- в. Сонгосон сэдвээ бусдадаа танилцуулж, яагаад сонгосноо тайлбарлаж ярилцаарай.

Нэг нь сурвалжлагч болоод тухайн сэдвийг сонгосноо шалтгааныг бусдаасаа асуугаарай. Учир нь, бичих сэдвээ сайн ойлгосон байх ёстойг анхаараарай.

Чи ямар сэдэв сонгосон бэ?

Энэ сэдэв чиний хувьд яагаад чухал вэ?

Чи энэ сэдвээр бичвэл ямар асуудлыг дэвшүүлэх вэ?

Энэ сэдвийн чухам юу нь чамд сонирхолтой санагдсан бэ?

Гэртээ: Бүгдээрээ “Ном уншихын ач тус” сэдвийг сонгоё. Гэхдээ, чи өөр сэдэв сонгож болно. Сонгосон сэдвийн хүрээнд ганцаараа болон багаараа баримт мэдээлэл цуглуулаарай.





а. Алдартай хүмүүсийн хэлсэн мэргэн үг, сургаал, баримт нь ямар баримт болох вэ? Дараах эшлэлүүдийг шинжилье.


- Одоо би бүхнийг мэдэх болно. Учир нь би номын сангаа онгичиж байна. Би үүгээрээ **хүн төрөлхтний оюун ухааны гишгүүр** өөд тэмүүлж байна.

Ж.П. Сартр

- Миний номын санд **хүний дээд** бий.

М.Цэдэндорж

- Энэ баахан тэнхээтэйдээ завдан нэгэн хуудас ном уншваас, мөн илүү **нэгэн өдөр амьдарсан (мэт) гавьяа** болой. *В.Инжиннаши*
 - Номын утга нь **тэнгэр мэт агуу, дэлхий мэт өргөн, далай мэт гүн**. Номыг унших нь **тэнгэрт нисэж, дэлхийг тойрч, далайд хөвөх мэт...** *Ц.Дамдинсүрэн*
 - Ном руу орно гэдэг зүв зүгээр байж байгаад л шал өөр ертөнц рүү гэнэт орчих шиг сайхан. Бясалгал хийхэд бид бие, сэтгэлийн нэлээд хат тэвчээр шаардаж өөр ертөнц рүү ордог. Харин ном уншихад **өөр ертөнц рүү, зүв зүгээр сууж байгаад шууд яваад орчхож болохоор** маш энгийн боломж. *Г.Аюурзана*
 - Хүний амьдралын эхний 25 жил бол хүний амьдралын жинхэнэ “эрдэнэ” юм. Хүн энэ жилүүдэд **юу сурч, юу уншиж, мэдэж авснаараа л бүх амьдралаа өнгөрөөнө**. *Д.Урианхай*
- б. Дээрх эшлэлүүдийг яагаад баримт гэж үзэж болох вэ? Учир нь алдартай хүмүүсийн хэлсэн үгс байна. Эдний тухай ангийнхантайгаа яриа өрнүүлээрэй. **Ж.П.Сартр?, М.Цэдэндорж?, В.Инжинаши?, Ц.Дамдинсүрэн?, Г.Аюурзана?, Д.Урианхай?**
- в. Алдартнууд номын үнэ цэнийг хэрхэн үнэлсэн бэ? Дээрх тодруулсан үг хэллэг тус бүрийн утгыг тайлбарлаад, номын тухай ямар асуудалд тохирохыг ярилцаарай.
- г. Мэдээг дараах **зургаан асуултаар** шинжлээрэй. Ямар зорилго, агуулгатай эх бичихэд энэхүү баримт мэдээлэл тохирох вэ?



Саяхан Иэйлийн их сургуулийн эрдэмтэд 50-аас дээш насны 3635 хүнийг судалгаанд хамруулж, нэлээд олон жилийн ажиглалтдаа үндэслэн ном байнга уншдаг хүний нас 20 хувиар уртасдаг болохыг баталжээ. Долоо хоногт 3 цаг 30 минутаас илүү хугацааг ном уншихад зориулж хэвшсэн хүмүүс огт ном уншдаггүйчүүлээс дунджаар 12 жилээр илүү насалдаг аж. (<http://animedia-company.cz/use-of-reading-blog/>)

Атланта хотын Эморигийн Ихсургуулийн судлаачид 12 оюутанд соронзон багаж суулгаж, өдөр бүр Роберт Харрисын “Помпей” зохиолоос 30 хуудас унших даалгавар өгчээ. Туршилтын үр дүнд зүүн тархины үйл ажиллагаа эрс идэвхэжсэнийг тогтоосон байна. (<http://animedia-company.cz/use-of-reading-blog/>)




Баримтыг сонгохдоо, тухайлбал, эшлэлийг хэнээс авах вэ? мэдээ хэр үндэслэлтэй вэ? зэрэг найдвартай байдлыг харгалзана.



Асуулт	Тодруулга
Шууд ба шууд бус ажиглалтын баримтын аль нь вэ?	<p>Шууд ажиглалтын: Мэдээллийг харах, сонсох, үнэрлэх, амтлах, хүртэх зэрэг 5 мэдрэхүйгээр олж авсан баримт.</p> <p>Шууд бус ажиглалтын: Ном зохиол, бичиг баримт зэргээс дам олж авсан баримт.</p>
Баримт уу? Үзэл бодол уу?	<p>Баримтын мэдээлэл: Тухайн өгүүлж байгаа зүйлтэй холбогдсон үзэгдэл, үйл явдлын тухай бодит мэдээлэл.</p> <p>Үзэл бодлын мэдээлэл: Баримтын мэдээллийг харьцуулан ажиглаад, зохиогчид төрсөн санаа, түүний хувийн ухаарал дүгнэлт.</p>
Хэр үр дүнтэй баримт байна вэ?	<p>Сонирхолтой байх Тухайн асуудлаар олон нийтийн анхаарлыг татах, түүнийг сурталчлах, уншигчдыг уриалах, дагуулах баримт</p> <p>Үр дүн, ач холбогдолтой байх Учир шалтгааныг нотлох, үнэн, хөдөлшгүй, хамгийн оновчтой баримт.</p>
Сэдэвтэй холбоотой байна уу?	<ul style="list-style-type: none"> ◆ Бичих гол санааг дэмжсэн баримт
Ямар ямар төрлийн баримт байна вэ?	<ul style="list-style-type: none"> ◆ Судалгаа шинжилгээний баримт ◆ Статистик тоон мэдээлэл ◆ Яриа, эшлэл ◆ Ном зохиолоос авсан жишээ ...
Баримт нь эх сурвалжтай юу?	<ul style="list-style-type: none"> ◆ Баримтын эх сурвалжийг дурдсан байх ёстой.

- в. Баримтаа үр дүн, ач холбогдлоор нь ангилж, эмхлэн цэгцлээрэй.
- ◆ Баримтуудаа агуулгаар нь 3 хэсэгт хуваагаад, нэр өгөөрэй.
 - ◆ Хуудасны голд ерөнхий сэдвээ бичээрэй.
 - ◆ Түүнийг тойруулан хэсгүүдийн нэрийг бичиж, байрлуулаарай.
 - ◆ Дараа нь уг хэсгүүдэд баримтаа харгалзуулан, бүлэглээрэй.
 - ◆ Хэсэг доторх баримтаа ямар дарааллаар байрлуулахаа шийдээрэй.



**Баримтад үндэслэн
тайлбарлан бичье.**

- ◆ Бичих санаагаа олох
- ◆ Бичих төлөвлөгөө гаргах
- ◆ Ноороглох буюу чөлөөт бичлэг хийх
- ◆ Төлөвлөсний дагуу бичих
- ◆ Бичсэнээ сайжруулж, сийрүүлэн бичих




4

Бичих санаагаа олѐ.


- а. “Ном уншихын ач тус” сэдвийн хүрээнд хамаарах үг хэллэгүүдийн жагсаалт гаргаарай.
- ◆ Цаасныхаа хамгийн дээд талд бичих сэдвээ бичээд, доогуур нь зураарай. Ингэснээр эхийн гол санааг үргэлж санана.
 - ◆ Үг жагсаах. Тухайн сэдвийн хүрээнд хамаарах, санаандаа орж ирсэн үгсийг жагсаан бичээрэй. Бичих үедээ санаагаа хянах, тунгаах гэж санаа зоволгүй, үргэлжлүүлэн бичээрэй. Бодох тусам олон үг орж ирнэ. Тэдгээрийг алдалгүй бичиж аваарай.
 - ◆ Холбоо үг бичих. Сонирхолтой, чухал санаа эсэх, үг үсгийн алдаатай эсэх зэрэгт санаа зоволгүй, сэдвийн хүрээнд хамаарах санааг холбоо үгээр буулгаарай. Аль болох богино хугацаанд, олон үг бичихийг хичээгээрэй.

Ном уншихын ач тус

Сэдвийн хүрээний үг



Сэдвийн хүрээний холбоо үг



- б. Жагсаалтаа нягталж, ижил төстэй утга бүхий үгсийг нэгтгэн, сэдэвт тохирохгүй үг, холбоо үгийг хасаарай.



Бичих төлөвлөгөө гаргаж, анхны нооргоо хийцгээе.

а. Эхийн бүтэц ямар байх вэ? Бичих төлөвлөгөө гаргаарай.

1	Эхлэл хэсэг	Сэдвээ товч танилцуулах ♦ Яагаад ном унших ёстой вэ?
2	Гол хэсэг	Сэдвийн нотолгоо, тайлбар, чиний үзэл бодол ♦ Чиний үеийнхэн ном хэр уншиж байна вэ? ♦ Чи ямар асуудлыг хөндөх вэ? ♦ Тухайн асуудал нь уншигчийн анхаарлыг хэрхэн татах, тэднийг уриалж дагуулах үр нөлөө ямар байх вэ? ♦ Асуудлыг шийдвэрлэх ямар хувилбарыг дэвшүүлэх вэ?
3	Төгсгөл хэсэг	Дүгнэлт ♦ Чи ямар санал дэвшүүлэх вэ?

б. Ноороглох буюу чөлөөт бичлэг хийцгээе.
Өмнө боловсруулсан төлөвлөгөөний дагуу эхний санаагаа ноороглон бичээрэй.

Зааврын дагуу бичээрэй.

- ♦ Цаасныхаа дээд талд сэдвээ бичнэ.
- ♦ Тухайн эхээр гаргах гол санаагаа 1-2 өгүүлбэрээр илэрхийлж бичээд, доогуур нь зурна. Ингэснээр эхийнхээ гол санааг үргэлж санана.
- ♦ Цаасныхаа мөрийн хооронд 1-2 мөр бичих зай, цаасныхаа 2 талд мөн зай үлдээнэ. Бичсэнээ сайжруулахын тулд эдгээр зайнд шаардлагатай баримт жишээг дараа нь нэмж бичнэ.
- ♦ Төлөвлөгөөний дагуу эхний нооргоо бичээрэй. Сэдэвтэй холбоотой баримт, жишээ, үзэл бодлоо багтааж, тасралтгүй бичихийг хичээ. Төлөвлөгөөнд байхгүй санааг нэмэх хэрэггүй.
- ♦ Эхний ноорог төгс байх шаардлагагүй тул цэг тэмдэг, үг үсгийн алдаанд санаа зоволгүй төлөвлөгөөний дагуу аль болох их бичих хэрэгтэй. Бичих явцдаа санаагаа бүрэн гаргаж чадахгүй бол зай орхиод дараа нь нөхөж бичиж болно.
- ♦ Бичих явцад өөр шинэ, чухал санаа төрвөл мартаггүйн тулд даруй цаасныхаа хажуу талын зайнд тухайн хэсгийн харалдаа тэмдэглэж авна.



Ноороглон бичихийн гол зорилго нь, бичих тусам чиний санаа илүү тодорхой, өөрийн өнгө аястай болдогт оршино. Дэвшүүлж байгаа санаа илүү нарийсна. Цаашдаа эхлэл, өрнөл, төгсгөлтэй болтлоо өргөждөг. Ноорог бол боловсруулах үе шат тул эмхлэх цэгцлэх гэж санаа зоволгүйгээр бичих хэрэгтэй.




а. Цогцолбор бүтээцгээе. Цогцолборын бүтцийг ажиглаарай.

Ухаалаг гар утсыг сургуулийн орчинд хязгаарласан улсын туршлага олон.

Тухайлбал, Японы Айчи мужийн Кария хотод бүх бага болон дунд сургуулийн сурагчид оройн цагаар ухаалаг гар утас ашиглахыг хоригложээ. Хотын захиргаанаас сурагчдын анхаарал төвлөрөлт, эрүүл мэндийг бодолцон ийм шийдвэр гаргасан байна. Тус хотод эцэг эхчүүд хүүхдийнхээ гар утасны хэрэглээг 21.00 цагаас хязгаарлах бөгөөд интернэт орчинд холбогдох төхөөрөмжүүдийг хамт салгах ёстой аж.

Энэ нь ч үр дүнгээ өгч, сурагчдын нийгмийн идэвх сайжирч, сурлагын амжилт нь огцом өсжээ.



б. “Ном уншихын ач тус” сэдвээр бичих эхийнхээ нэг цогцолборыг бүтээцгээе. Дараах бүтцийн дагуу 10 орчим өгүүлбэртэй цогцолбор бичээрэй.

1. Цогцолборын агуулгын хүрээний үгийн жагсаалт гаргаарай.

2. Агуулга, сэдэвт үндэслэн гол өгүүлбэрээ бичээд, доогуур нь зураарай.



3. Гол өгүүлбэрээ дэмжих өгүүлбэрүүдийг бичээрэй.

Баримт, жишээ

Баримт, жишээ



4. Дүгнэлт өгүүлбэрээ бичээрэй.

5. Зөв бичих болон найруулгын алдаагаа хянаарай.

6. Цогцолбороо эцсийн байдлаар сийрүүлэн бичээрэй.

Өөрийгөө шалгаарай.

- ♦ Цогцолборын гол санааг хадгалсан өгүүлбэр байна уу?
- ♦ Дэмжих өгүүлбэрүүд гол өгүүлбэрийн санааг дэмжиж чадсан уу?

в. Дүгнэлт бичье. Бичсэн цогцолборт бүтцийн дагуу нэг цогцолбор нэмж бичээд, зааврын дагуу дүгнэлт бичээрэй. Дүгнэлт бичихдээ дараах үгээс ашиглаж болно. (Эцэст нь, дүгнэж хэлэхэд, дүгнэж үзэхэд, үүний үр дүнд, бид үүнийг харж болно...)

Эхний цогцолборын гол санааг илэрхийлсэн өгүүлбэр бич. Гол санааг дэмжсэн баримт, жишээ бич. Цогцолборын дүгнэлт өгүүлбэр бич.

Удаах цогцолборын гол санааг илэрхийлсэн өгүүлбэр бич. Гол санааг дэмжсэн баримт, жишээ бич. Цогцолборын дүгнэлт өгүүлбэр бич.

Цогцолбор тус бүрийн дүгнэлт өгүүлбэрт үндэслэн, эхийн дүгнэлт бичээрэй.



Бичсэнээ сайжруулъя, сийрүүлэн бичье.

- а. Бичсэнээ нөхдөдөө уншаарай. Гаргасан санааны юу нь таалагдаж, юу сэтгэлд нь нийцэхгүй байгаа талаар бусдынхаа санал бодлыг сонсоорой. Сайжруулах санал ойлгомжтой, тодорхой байх ёстойг анхаараарай. Жишээ нь: Ямар үг, өгүүлбэрийг солих, найруулгыг хэрхэн сайжруулах талаар ярилцаж, үлдээсэн мөрөндөө тодруулга хийнэ үү.
- б. Бичсэнээ хянаарай.

Бичсэнээ анхааралтай уншаарай. Цаасны хажуу зайнд “санаа нэмэх, жишээ оруулах” гэх мэтээр тэмдэглэл хийж, сайжруулах шаардлагатай хэсгүүдийг дахин бичээрэй.

1. Эхийн агуулга, бүтцийг хянаарай.

- ◆ Зурж тэмдэглэсэн сэдвээ тодорхой илэрхийлсэн үү?
- ◆ Бичих санаагаа бүрэн гаргаж чадсан уу?
- ◆ Цогцолборууд дэс дараалалтай, уялдаа холбоотой байна уу?
- ◆ Уншигч үзэл бодлыг чинь хүлээн зөвшөөрөхөөр баталж нотолж чадсан уу?
- ◆ Баримтууд гол санааг дэмжиж чадсан уу?
- ◆ Эхийн гол санааг илэрхийлэх өгүүлбэр байна уу?
- ◆ Цогцолборын гол санааг дэмжихгүй өгүүлбэр байна уу?
- ◆ Дүгнэлт чинь оновчтой болж чадсан уу?
- ◆ Дэвшүүлсэн асуудлаа үнэмшилтэй, үндэслэлтэй тайлбарлаж чадсан уу?

2. Зөв бичих, цэг цэглэлийн алдааг хянаарай.

- ◆ Бүх үгээ зөв бичсэн үү?
- ◆ Өгүүлбэр дотор том үсгээр бичих үгсийг зөв бичсэн үү? (Оноосон нэр, гаргуудын нэр, сар, хаяг гэх мэт)
- ◆ Таслал, хашилт болон бусад цэг цэглэлийг зөв хэрэглэсэн үү?
- ◆ Догол мөрийг зөв хэрэглэсэн үү?

Дээрх асуултын дагуу тохирох оноог дугуйлан, өөрийгөө үнэлээрэй.

	бага				их
1.	1	2	3	4	5
2.	1	2	3	4	5
3.	1	2	3	4	5
4.	1	2	3	4	5
5.	1	2	3	4	5
6.	1	2	3	4	5

3. Найруулгын алдааг хянаарай.

- ◆ Үг илүүдсэн, дутсан, буруу сонгосон, буруу хэлбэржүүлсэн, үг, өгүүлбэрийг буруу холбосон, буруу байрлуулсан зэрэг алдаа байна уу?
- ◆ Найруулгын алдааг олоод, засаж найруулан, зассан үндэслэлээ тайлбарлаарай.

- v. Өөрийн үнэлгээнд үндэслэн, эхээ сийрүүлэн бичээрэй.



Өмнө судалсан бичих арга барилын дагуу өөр сэдэв сонгон, тайлбарлан бичиж, өөрийгөө сорьё.

Байгаль, нийгмийн асуудлаас сонгон, баримтад үндэслэн санаагаа илэрхийлье.

Сэдэв: Тулгамдаж байгаа асуудал.

Уншигч: Сургууль, ангийн хүүхдүүд

Зорилго: Тулгамдаж байгаа асуудлыг тайлбарлах

Хэмжээ: Нэг нүүрэнд багтааж бичих.

а. Хүүхдүүд ээ! Хүрээлэн буй орчин, нийгэмд ямар асуудал тулгамдаж байна вэ? Ангиараа ярилцаад, жагсаан бичээрэй.

Хүрээлэн буй орчны асуудал: Орчны бохирдол, ой мод огтлох, цэвэр усны хомсдол, хог хаягдал ...

Нийгэм, соёлын асуудал: Хүүхдийн эрх, эрүүл мэнд, гар утасны хэрэглээ ...

- ◆ Жагсаасан асуудлаа эн тэргүүнд тулгамдсан эсэхээр нь эрэмбэлээд, учрыг нь тайлбарлаарай.
 - ◆ Энэ асуудлыг яагаад эн түрүүнд шийдвэрлэх ёстой вэ? гэдгийг хэлэлцээрэй.
 - ◆ Чиний хувьд хамгийн түрүүнд шийдвэрлэх шаардлагатай, чухал санагдсан, сонирхолтой асуудлаа сонгоорой. Ганцаараа эсвэл багаараа нэг асуудлыг сонгож болно.
- б. Тулгамдсан асуудлаар бичихийн тулд тухайн асуудлаа илүү тодорхой болгох хэрэгтэй. Үүний тулд:

Сонгосон ерөнхий сэдвээ тодорхой сэдэв болгоорой.

Тэгснээр чиний бичих сэдэв илүү ойлгомжтой, үр дүнтэй болно. Жишээлбэл:

Ерөнхий сэдэв

- ◆ Тодорхой
- ◆ Бүр тодорхой

Хог хаягдал

- ◆ Ахуйн хог хаягдал
- ◆ Гялгар уут хаях

Цахим хэрэглээ

- ◆ Интернэтийн зохисгүй хэрэглээ
- ◆ Цахим тоглоомын донтолт

Орчны бохирдол

- ◆ Хөрсний бохирдол
- ◆ Суурин газрын хөрсний бохирдол

В.

Сэдвийн хүрээнд баримт мэдээлэл цуглуулж, шинжилж, цэгцэлье.

Бичих сэдвээ сонгох
Сэдвийн хүрээнд судалгаа хийж, баримт мэдээлэл цуглуулах
Баримтаа шинжлэх
Баримтаа цэгцлэх

Байгаль, нийгмийн асуудлаас баримтад үндэслэн тайлбарлан бичье.

Бичих санаагаа олох
Бичих төлөвлөгөө гаргах
Ноороглох буюу чөлөөт бичлэг хийх
Төлөвлөсний дагуу бичих
Бичсэнээ сайжруулах
Сийрүүлэн бичих

Шалгуур	Үзүүлэлт	Гүйцэд	Дутуу
Агуулга, ач холбогдол	Баримтад үндэслэн, байгаль, нийгмийн асуудлын	2	1
	◆ Нөхцөл байдлыг тодорхойлсон уу?	2	1
	◆ Асуудал дэвшүүлсэн үү?	2	1
	◆ Дүгнэлт гаргасан уу?	2	1
Баримт жишээ нотолгооны чанар	◆ Санал дэвшүүлсэн үү?	2	1
	◆ Сэдвийн агуулгад нийцсэн жишээ баримт сонгож, судалгаанд тулгуурласан уу?	2	1
	◆ Бичвэрийн нотлон үнэмшүүлэх байдал хэр байна вэ?	2	1
Хэл найруулга	◆ Чи дэвшүүлсэн асуудлаа чухал болохыг тодорхой тайлбарлаж бичсэн үү?	2	1
	◆ Найруулгын алдаагаа хянасан уу? ◆ Зөв бичих дүрмийг баримталсан уу?	2	1
Нийт 18 оноо			

7

МЭТГЭЛЦЭЭН ЗОХИОН БАЙГУУЛЪЯ



Эзэмших мэдлэг, чадвар

- ◆ Мэтгэлцээн зохион байгуулах дарааллыг мэдэх
- ◆ Асуудлыг олон талаас авч үзэх
- ◆ Баримт мэдээлэл сонгох
- ◆ Мэтгэлцэх

**Мэтгэлцээн
зохион
байгуулъя.**

- ◆ Мэтгэлцээн зохион байгуулах дарааллыг мэдэх
- ◆ Асуудлыг олон талаас авч үзэх
- ◆ Баримт мэдээлэл сонгох
- ◆ Мэтгэлцэх

I

1

Мэтгэлцээн зохион байгуулах дарааллыг мэдье.

- ◆ Мэтгэлцээний сэдвийг сонгож мэтгэлцэх асуудлаа дэвшүүлнэ. Мэтгэлцээн нь ямар нэг маргаантай асуудлаас үүдэж гардаг. Баталсан өгүүлбэр байж болно. Тухайлбал: “Найзынхаа төрсөн өдрөөр бэлэг өгөх хэрэгтэй.” гэсэн баталсан өгүүлбэрийг “Найзынхаа төрсөн өдрөөр заавал бэлэг өгөх албагүй.” хэмээн няцааж болно.
- ◆ Ангийн сурагчид дөрвөн баг болно. Нэг багт таваас доошгүй хүн байж болно.

Багууд дараах үүрэгтэй байна.

- ◆ 1 дүгээр баг: Дэвшүүлсэн асуудлыг нотолно.
- ◆ 2 дугаар баг: Нотлох багийн саналыг няцаана.
- ◆ 3 дугаар баг: Хоёр багаас асуулт асууна.
- ◆ 4 дүгээр баг: Багштай хамтран, хоёр багийн аль нь илүү үндэслэл нотолгоо гаргасан бэ? гэдэгт үнэлгээ өгч, шүүгчээр ажиллана.
- ◆ Асуудалтай санал нийлж нотлох гэж байгаа баг, няцаах гэж байгаа баг тус тусдаа зөвлөлдөөд, нотолгоогоо яаж гаргавал эсрэг багаас илүү үндэслэлтэй болох тухай хэлэлцэнэ.





2

Дараах удирдамж тайлбарыг уншаад, мэтгэлцээнийг хэрхэн зохион байгуулах аргыг ойлгож ярилцаад, мэтгэлцээнд бэлтгэе.

Сэдэв: Сургуулийн орчинд утасгүй интернэт байх хэрэгтэй юү?

Эхний нотолгоо:

- ♦ Нотлох ба няцаах багийн гишүүд өөрийнхөө дэвшүүлж байгаа асуудалд аль болох үндэслэлтэй нотолгоо гаргахын тулд зөвлөлдөж, санаагаа гаргана. Тухайлбал: Нотлох ба няцаах үндэслэлээ гурван шалтгаанаар тайлбарлаж болно.

Нотлох баг: Сургуулийн орчинд утасгүй интернэт байх хэрэгтэй. Үүний давуу талыг харуулах гурван шалтгааныг дурдаж болно.

1. Интернэт дэлхий нийтийн хэрэглээ болсон үед интернэтгүй сургууль байх нь хоцрогдож байгааг илэрхийлнэ. Тиймээс байх нь зүйтэй.
2. Хичээлийн үед ямар нэг чухал мэдээлэл хэрэг болоход багш, сурагчид цаг алдалгүй олж мэдэхэд тустай.
3. Хичээлийг олон зүйлтэй холбож ойлгох боломжтой болно.

Няцаах баг: Сургуулийн орчинд утасгүй интернэт байх хэрэггүй. Үүнийг батлах гурван шалтгааныг дурдаж болно.

1. Хот, хөдөөгийн хүүхэд бүр интернэтэд цагаа өнгөрөөгөөд байх боломж хэдийгээр бага боловч ухаалаг утсаар хичээлийн үеэр ч чөлөөтэй орох боломжтой. Тиймээс үүнийг хязгаарлах шаардлагатай.
2. Хэдийгээр интернэтээс хүссэн мэдээлэлээ олж унших боломжтой ч түүний үнэн худлыг дэнслэх боломжгүй тул хичээлийн үед тийм ч сайн нөлөө үзүүлж чадахгүй.
3. Сэтгэл судлаачид, "интернэт ганцаардал" нь хүүхдүүдийг ууртай, танхай, цаашлаад дарангуйлагч зантай болоход хүргэдэг гэдгийг тогтоосон байна. Тиймээс хичээлийн цагаар интернэт ашиглах шаардлагагүй.

Ажиглагч сурагч Цэцэг:



Нотлох ба няцаах баг байр сууриа хамгаалахын тулд нэлээд сайн үндэслэлтэй шалтгааныг гаргах хэрэгтэй юм байна шүү дээ.

Асуулт - Хариулт

- ♦ Асуулт асуух багийнхан хоёр багаас аль болох байр суурьтай нь холбоотой асуулт асуухын тулд зөвлөлдөнө. Нотлох баг, няцаах багийн үндэслэлийг асуулт асуух багийнхан хэлэлцээд, үндэслэлээ илүү нарийвчлахыг сануулах, үзэл бодлоо зөвтгөх, тайлбарлах чадварыг шалгах асуулт асууна.



Нотлох багаас асуух:

Асуулт: “Аливаа үйл явдал, баримттай холбоотой мэдээллийг хүн цээжилж, ой тоондоо оруулахын оронд хүссэн хайлтын системдээ хоёр үг бичээд л олчихдог болсон. Энэ хэрээр хүний оюуны чадамж ч буурах аюултай.” гэсэн судалгаа гарсан. Хичээлийн үед хүүхдүүд оюун ухаанаа ажиллуулах ёстой биш үү?

Нотлох багийн хариулт: Хичээлийн үед хүүхдүүд оюун ухаанаа хөгжүүлэх хэрэгтэй гэдэг нь үнэн. Гэхдээ, интернэттэй байлаа гээд оюун ухаанаа хөгжүүлэх боломж нь багасахгүй гэж бодож байна.

Няцаах багаас асуух:

Асуулт: Интернэт орчин нь бидний мэдлэгийн түвшнийг сайжруулсан гэж үздэг. Интернэт бидний амьдралд сөрөг нөлөө үзүүлээгүй, харин ч хүн төрөлхтний хөгжлийг хурдасгагч, эерэг нөлөө үзүүлэгч гэж бодож байна. Дэлхий ертөнцтэй танилцаж, шинэ соргог санаа дэвшүүлж, түүнийгээ бусадтай хуваалцах асар өргөн боломж олгодог шүү дээ. Тэгэхлээр сургуулийн орчинд утасгүй интернэт байх зайлшгүй хэрэгтэй биш үү?

Няцаах багийн хариулт: Мэдээллийн асар их урсгал дундаас хормын дотор хүссэн мэдээллээ олж авах боломжийг интернэт олгодог төдийгүй бидний амьдралыг илүү хялбаршуулсан нь үнэн. Гэхдээ сүүлийн үед интернэт хүүхдүүдийг ганцаардмал болгож, гадаад орчноос хязгаарлаж байгааг судлаачид тогтоосон. Үүнийг “Интернэт ганцаардал” гэж ч томъёолж болох юм. Чухамдаа, хүүхдүүд нийгэмших, хүмүүстэй хэрхэн харьцах боловсрол олж авах хамгийн чухал орчин бол сургууль гэж бодож байна. Тиймээс сургуулийн орчинд утасгүй интернэтийг хязгаарлах хэрэгтэй.

- ◆ Эхний нотолгоо ба асуултад хариулсан байдалдаа дүн шинжилгээ хийж, сүүлчийн дүгнэлтээ үндэслэлтэй гаргахын тулд сайтар ярилцана.

Сүүлчийн дүгнэлт:

Нотлох баг: Компьютерийн хулганын товчлуурыг ганц дараад л гэрээсээ төлбөр тооцоогоо хийдэг болсон. Интернэт бидний амьдралд сөрөг нөлөө үзүүлээгүй, харин хүн төрөлхтний хөгжлийг хурдасгаж, эерэг нөлөө үзүүлсэн. Утасгүй интернэт сургуулийн орчинд байснаараа дэлхий ертөнцтэй танилцаж, шинэ соргог санаа дэвшүүлж, түүнийгээ бусадтай хуваалцах асар өргөн боломж олгоно гэж бодож байна.




Няцаах баг: Интернэтийг устай зүйрлэе. Хүн усгүй амьдарч чадахгүй шиг, өнөөдөр интернэтгүйгээр ажил төрлөө явуулах бололцоогүй болчхоод байгаа нь үнэн. Гэвч, саяхныг хүртэл крантаар үнэгүй гоожиж байсан усыг тоолууртай болгосноор хэмнэлт буй болсон. Ядаж л шүдээ угаахдаа усаа хэмнэдэг айлын тоо асар их нэмэгдсэн. Үүн шиг интернэтийн хэрэглээнд бас хязгаар тогтоох ёстой гэж бодож байна. Учир нь, сургууль дээр 6 наснаас эхлээд бүх насны хүүхдүүд хичээлийн болон хичээлээс гадуурх үйл ажиллагаанд оролцдог. Тухайлбал: Өөрийн үйлдлийн зөв бурууг шүүн тунгааж, үнэлэлт өгч хараахан чадахгүй бага ангийн хүүхдүүд компьютер тоглоомоос болж сэтгэцийн эмгэг тусаж буй олон жишээ байгаа шүү дээ. Ядаж сургуулийн орчинд интернэтийг хязгаарлах шаардлагатай.

- ◆ Шүүгчийн багийнхан аль багийн нотолгоо, хариулт, эцсийн дүгнэлт илүү үндэслэлтэй болсныг хэлэлцээд, дүгнэлт гаргана.

Шүүх баг: Нотлох баг, няцаах багийнхны тайлбар үндэслэл нотолгоог ажиглаж, дүгнэлт гаргая.

Нотлох багийнхан “Сургуулийн орчинд утасгүй интернэт байх хэрэгтэй” гэсэн асуудлын шалтгааныг гурван зүйлээр дурдахдаа интернэтийн давуу талыг харуулсан, жишээ баримт, судалгаа гэх мэт баримт дутагдалтай байгаа учраас мэтгэлцээнд ялагдсан гэж үзэж байна.

Няцаах багийнхан “Сургуулийн орчинд утасгүй интернэт байх шаардлагагүй” гэсэн асуудлын шалтгааныг дурдахдаа, мөн асуултад хариулахдаа, эцсийн дүгнэлтийг хэлэхдээ судалгаа болон бодит амьдралын жишээг илүү нотолгоотой дурдсан учир мэтгэлцээнд ялсан гэж үзэж байна.





Мэтгэлцээний үед тэмдэглэл яаж хөтлөх вэ?

Асуух баг

Дэвтрийнхээ нүүрийг хоёр хэсэгт хувааж зурна.
Дэвтэртээ нотлох ба няцаах багийн тайлбар тус бүрээс хамгийн чухал үгийг хоёр баганад ялгаж түргэн бичнэ. Зөвлөж ярихдаа тэмдэглэлээ ашиглана.

Үлгэрлэвэл:

Нотлох

- - Хоцрогдох
- Хугацаа ашиглах
- Олон хичээл холбох
- - Дэлхийтэй танилцах
баримт, нотолгоо!!!

Няцаах

- - Интернэт донтолт
- Судалгаа
- Бага насны хүүхдүүд
- - Интернэтийг устай зүйрлэе.

+ ✓✓



Асуудлыг олон талаас авч үзье.

“Унадаг дугуйтай Улаанбаатар” жагсаал зохион байгуулах гэж байгаа юм байна. 2013 оноос хэрэгжүүлж эхэлсэн төслийн ач холбогдолтой ба шүүмжлүүштэй тал нь юу байж болохыг дараах мэдээнээс гаргаж ярилцъя.

Ярилцахын тулд:

1. Мэдээг анхааралтай уншина.
2. Эрүүл мэндэд чухал тал нь мэдээллийн эерэг тал байж болох юм. Энэ талаас тодруулах асуудал юу байна вэ?
3. Энэ үйл ажиллагааны хүрээнд малгай худалдах, гэр бүлийн унадаг дугуй түрээслэх зэрэг санхүүтэй холбоотой ямар нэг сөрөг асуудал гарч болох талаар асуумаар зүйл байна уу?

“Дугуйтай Улаанбаатар” баярын жагсаал маргааш болно.

“Автомашингүй өдөр” буюу маргааш Нийслэлийн Захирагчийн ажлын алба, Монголын Залуучуудын Холбоо хамтран “Унадаг дугуйтай Улаанбаатар” дугуйн парадыг зохион байгуулна. МЗХ* -оос санаачлан 2013 оноос дугуй унадаг залуусын тоог нэмэгдүүлэх, нийслэлд унадаг дугуйн зам бий болгох зорилгоор “Дугуйтай Улаанбаатар” төслийг хэрэгжүүлж эхэлсэн. Сүүлийн жилүүдэд унадаг дугуй унах залуусын тоо ч эрс нэмэгдсэн нь төслийн үр дүнг харуулж байгаа юм.

* МЗХ – Монголын Залуучуудын Холбоо



Энэ жилийн дугуйн парадаар дугуй унадаг залуусыг хамгаалалтын малгай өмсөж хэвшихийг уриалж байгаа юм. Унадаг дугуй бол хүн хөдөлгүүр бүхий тээврийн хэрэгсэл. Тиймээс замын хөдөлгөөнд оролцохдоо дугуйчид зайлшгүй хамгаалалтын малгай өмсөж хэвших хэрэгтэй. Энэ нь тархины гэмтлээс бүрэн хамгаалах боломжтой юм. Энэ өдөр зориулалтын сайн чанарын хамгаалалтын малгайг 20000 төгрөгөөр худалдах юм байна. Дугуйчид жил бүр унадаг дугуйгаар үг болон дүрс бүтээдэг бөгөөд энэ жил “Дугуйн замыг нэмье” гэсэн уриа үг, “Дугуйтай Монгол” гэсэн утга бүхий дүрс бүтээх юм байна.

Дугуйн парад маргааш 14 цагаас МУИС-ийн төв байрны баруун талаас эхэлнэ. Энэ үеэр Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд ажиллагаа явуулдаг “GREEN BIKE” байгууллага гэр бүлийн унадаг дугуй түрээсэлж үйлчилнэ. (2017.05.19 “oloo.mn” - ээс)



Асуудлыг олон талаас харахын тулд эсээ бичвэрийг эргэцүүлье.

Интернэт бүхнийг манлайлагч уу?

Арван жилийн өмнө интернэтийн тухай ихэнх хүн бараг сонсоогүй байсан гэж болно. Гэтэл өнөөдөр дэлхий дахиныг хамарч чадсан мэдээллийн хамгийн хүчирхэг хэрэгсэл болжээ. Интернэт нь төрөл бүрийн үйлчилгээний нөөцтэй болно. Түүний үндсэн бүрэлдэхүүн нь и - мэйл болон олон төрлийн вэб болно. Ер нь интернэтэд и - мэйлээс илүү их хэрэглэгддэг төрөл бүрийн хайлтын системүүд, алдартай вэб сайтууд, түүнчлэн спортын оноо тоолох, чат хэлэлцүүлэг гээд тоочоод баршгүй олон зүйл бий. Өнөөдөр албан газар, айл өрх бүр интернэтийн орчинтой болжээ гэж дүгнэж болно. Гэвч интернэтийн давуу ба сул талыг сайтар мэддэг байх хэрэгтэй юм. Ихэнх хүн интернэтийн сул тал гэхээр айдас, аюулгүй байдлын тухай л ярьдаг. Энэ нь тийм ч оновчтой дүгнэлт биш юм. Харин ч интернэт нь хүнд аюулгүй байдлаа хангахад тус болдог ч байж болно.

Үүнээс гадна, хүүхдүүдийн интернэт хэрэглээ хамгийн том асуудал болж байна. Тэд интернэтээс ямар мэдээлэл авч байгааг эцэг эхчүүд тэр бүр хянах боломжгүй байгаагаас интернэтийн сөрөг нөлөөнөөс урьдчилан сэргийлж чадахгүй байна. Жишээ нь: Хүүхдүүд интернэтээр садар самууныг үзэж ч болно. Ийм аюулаас хол байлгахын тулд эцэг эх, багш нар байнга анхаарч байхын тулд интернэт орчны сөрөг үр дагаврыг сайтар мэддэг байх ёстой.

Мөн интернэтэд байдаг сэтгэгдэл гээч нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөт олгож байгаа боловч нөгөө талаараа хэнийг ч, яаж ч доромжилж болох талбар болжээ. Үүнийг чөлөөт хэвлэл гэж нэрлэх нь арай л утгагүй юм. Иймэрхүү гүтгэлэг доромжлолын хариуцлагыг хэн ч үүрэхгүй байна. Сайтын эзэн гэх нөхөр "Би мэдэхгүй. Хүмүүс л сэтгэгдлээ бичсэн" гээд л амыг чинь таглана. Тухайн бичигчийг, сэтгэгдэл нэрээр эрээ цээргүй доромжилж гүтгэх явдал хаа сайгүй байна. Буцах хаяггүй, буух эзэнгүй энэ мэдээллийн цаана үзэн ядалт, эрээ цээргүй доромжлол үнэртдэг. Хэн ч, тэр доромжилсныхоо үнэн, худалд ямар ч хариуцлага хүлээдэггүй. Юу ч гэж бурж болдог, нууцыг хадгалдаггүй, интернэтийн энэ сул талыг дэлхий нийтээрээ мэдэж эхэлж байна.

Тэгвэл цаасан хэвлэл зах зээлд хүчтэй хэвээрээ байгаа юм. Цагаан дээр хараар бичсэн, баримттай, буух эзэн, буцах хаягтай байдгаараа онцлог. Хариуцлагатай сэтгүүл зүй гэдэг бол энэ. Хэвлэл мэдээлэл тэр дундаа чөлөөт хэвлэл гэдэг хэн





дуртай нь бусдыг хүссэнээрээ гүтгэж доромжилж байдаг зүйл биш. Шуурхай байна гэдэг худал хэлэхийн нэр биш.

Дэлхийн чиг хандлага цаасан хэвлэлээс татгалзахгүй, харин ч түүний хэрэглээ өсөх хандлагатай байгааг дэлхийн хэвлэлийнхний томоохон хурлын үеэр авсан судалгаанд дурджээ. Хариуцах эзэнтэй, баримт болж үлддэгээрээ сайт хэмээх дураараа дургигчдаас өөр. Орон сууц, байр байршил нь тодорхой. Цаасан хэвлэл бол ид шидийн мэт баригддаггүй, харагддаггүй ертөнцөөс хамаагүй амьд. Ертөнц дэлхий ер бусын хурдтай өөрчлөгдөн хувьсаж байгаа ч хэвлэмэл сонины хэрэгцээ өссөөр л байна.

Эргэцүүлэн бодож, ярилцах асуултууд

- а. Зохиогч энэ эхэд интернэтийн сул тал ба давуу талыг аль байр сууринаас бичсэн байна вэ?
- б. Хэвлэмэл сонины ямар ямар давуу талыг дурдсан бэ?
- в. Энд байгаа интернэт мэдээллийн тухай баримтууд нь интернэтийн эерэг талыг нотлох багийнханд дэмжлэг болж чадах уу? Яагаад?
- г. Эхэд өгүүлж байгаа “Буцах хаяггүй, буух эзэнгүй энэ мэдээллийн цаана үзэн ядалт, эрээ цээргүй доромжлол үнэртдэг. Хэн ч тэр доромжилсныхоо үнэн, худалд хариуцлага хүлээхгүй” гэсэн сөрөг үр дагаврыг бууруулахын тулд чи юу хийж чадах вэ? Таван зүйлийг дурдана уу.
 1.
 2.
 3.
 4.
 5.
- д. Эхэд өгүүлж байгаа ямар мэдээлэл чиний санаанд нийцэхгүй байна вэ? Шалтгааныг тайлбарлана уу.
- е. Эхийн гол санааг хадгалсан нэг оновчтой асуулт бичнэ үү.



Мэтгэлцээний асуудалд дүгнэлт хийе.

- а. Хоёр хэсэгт байгаа мэдээллийг уншаад, мэтгэлцээний шинж байгаа эсэхийг жишээгээр баталж, дүгнэлт гаргана уу. Ингэхийн тулд мэтгэлцээний онцлог шинжүүдийг ашиглаарай.



Мэтгэлцээний онцлог шинжүүд:

- ◆ Тодорхой асуудлын талаар хэлэлцэнэ. Дэвшүүлсэн асуудал байна.
- ◆ Нийгэмд өрнөж байгаа ямар нэгэн асуудлын тухай сэдэвтэй байж болно.
- ◆ Хоёр баг үзэл бодлоо уралдуулан, асуудалд өөр өөрийн үзэл бодлоо илэрхийлнэ.
- ◆ Үзэл бодлоо илэрхийлээд, хүмүүст аль болох хэрэгтэй шийдлийг санал болгоно.

**А**

Аливаа зүйлийн үнэ цэнийг ухаарч амжаагүй байгаа балчир насныханд интернэт сөргөөр нөлөөлдөг. Юу чухал болох, ямар үр дагавартай болохыг мэдэхгүй хүүхдүүд интернэтэд асар их цагийг өнгөрүүлдэг. Багаасаа хүсээгүй, шаардлагагүй зүйлсийн талаар уншиж, үзэж, хүмүүжлийн доголдолтой болох нь ч бий.

Сүүлийн үед интернэт нь хүүхдүүдийг ганцаардмал болгож, гадаад орчноос хязгаарлаж байгааг судлаачид тогтоожээ. Үүнийг “Интернэт ганцаардал” гэж ч томъёолж болох юм. Чухамдаа хүүхдүүд нийгэмших, хүн хүнтэйгээ харьцах чухал боловсролоос өөрийгөө тусгаарлан, ганцаардах болов. Тэд бусадтай нөхөрлөж, хорвоог танин мэдэх цаг хугацаагаа компьютерийн өмнө сууж, интернэтээс дуу сонсох, кино үзэх, тоглоом тоглоход зарцуулдаг болсон.

“Интернэт ганцаардал” нь хүүхдүүдийг ууртай, танхай, цаашлаад дарангуйлагч зантай болоход хүргэдэг гэдгийг сэтгэл судлаачид тогтоожээ.


Манай орны хувьд хүүхэд бүр чөлөөт цагаа интернэтэд өнгөрөөгөөд байх боломж харахан байхгүй ч сүүлийн үед хүүхдүүдийн дунд тархсан компьютер тоглоомын дон нь нэлээд томоохон асуудал үүсгэж буй.

Б

Интернэт хүн төрөлхтөнд сөргөөр нөлөөлөөгүй гэдэгт би итгэдэг. Харин ч бидний мэдлэгийн түвшинг сайжруулсан. Мэдээллийн асар их урсгал дундаас хормын дотор хүссэн мэдээллээ олж авах боломжийг интернэтл бидэндолгодог, бидний амьдралыг илүү хялбаршуулсан. Компьютерийнхаа хулганын товчлуурыг ганц дараад л гэрээсээ төлбөр тооцоогоо хийж, онлайнар худалдан авалт хийж болно. Интернэтийн давуу тал нь сөрөг талаасаа хамаагүй илүү гэж дүгнэж болно. Интернэт бидний амьдралд сөрөг нөлөө үзүүлээгүй, харин ч хүн төрөлхтний хөгжлийг хурдасгагч, эерэг нөлөө үзүүлэгч гэж бодож байна. Дэлхий ертөнцтэй танилцаж, шинэ соргог санаа дэвшүүлж, түүнийгээ дэлхий нийттэй хуваалцах асар өргөн боломж олгодог шүү дээ.

Дүгнэлт: Дараах хоёр хэсгээс зөвшөөрч байгаагаа сонгож, нөхөж бичээрэй.

- а. Миний бодлоор, энэхүү хоёр эхэд мэтгэлцээний шинж байна. Яагаад гэвэл
- б. Миний бодлоор, энэхүү хоёр эхэд мэтгэлцээний шинж байхгүй. Яагаад гэвэл
- в. Гаргасан дүгнэлтүүдээс давхцаагүй санаагаа түүвэрлэн, самбарт жагсааж бичээд, хэрэгтэйгээ сонгоорой.
- г. Дээрх хоёр эхийг дуурайлган “Ухаалаг гар утас хэрэглэхийн давуу ба сул тал” гэсэн сэдвээр 3 минутын мэдээлэл бэлтгэж, ангийнхандаа илтгэнэ үү. 95, 140-р талаас тохирох баримт мэдээллийг ашиглаж болно.



Бүтэц нь:
 1 дүгээрт: Дэвшүүлсэн асуудлаа тодорхойлох
 2 дугаарт: Давуу тал: Баримт ба үзэл бодол
 3 дугаарт: Сул тал: Баримт ба үзэл бодол
 4 дүгээрт: Дүгнэлт



6

Баримт мэдээлэл сонгоё.

Дараах мэдээллүүдэд асуултын дагуу дүн шинжилгээ хийж ярилцаарай. Аль нь танай багийнхны нотолгоо болж чадах вэ?



Дэвшүүлж буй асуудлаа статистик тоо баримт, түүхэн үнэн, шинжлэх ухааны дүгнэлт нээлт, болсон явдал гэх мэт баримтаар нотолж үнэмшилтэй болгодог.

А. Эрдэмтний үг

Хүний зан төлөвийн өөрчлөлтийг судлах төвийн захирал Питер Виброугийн дүгнэлт “Интернэт, гар утасны хэрэглээ эдүгээ дэлхийн дулаарлаас дутахгүй эмзэг асуудал болж хувирлаа. Бидний эргэн тойронд байгалийн бүтээсэн олон гайхалтай зүйл буй нь аз. Гэвч хүн төрөлхтөн байгалиас холдож, технологид сүсэглэх болсон нь тэдний сэтгэц, мэдрэлд нөлөөлж эхэлсэн. Зүүдэндээ ярих, босож явах, нойргүйдэх зэрэг нь энгийн зүйл мэт болж, ийм шинж тэмдэг илрэх үед хүмүүс эмчид үзүүлэхээ ч байж, дасал болов. Технологи биднийг зомби шиг болгож байна.”

Б. “Засгийн газрын мэдээ” сонины 2015.09. 11 -ий өдрийн нийтлэл

Харвардын их сургуулийн профессор Ж.Колвин “Технологи хэрхэн хөгжихөөс үл хамааран хүнийг хүн болгодог зүйлс байдаг. Хүнд юун түрүүнд хүн л хэрэгтэй. Тархи чухал. Гэхдээ зүрх сэтгэл буюу мэдрэмж, бусдыг ойлгох, хамтдаа баярлах, зовох, нэгнийхээ мэдрэмжийг хуваалцах чанар нь технологийн ертөнцөд хүртэл ухаалаг шийдвэрээс дутахгүй шаардлагатай” -г онцолжээ.

В. ГХЯ -ы Олон талт хамтын ажиллагааны газрын захирлын хэлсэн үг:

Төрийн үйлчилгээг иргэдэд ойртуулж, ил тод, хөнгөн шуурхай болгоход интернэт тун чухал. Хүний бодол сэтгэлгээ, ахуй амьдрал, соёл, эдийн засаг, улс нийгэм, олон улсын харилцаанд ч интернэт хүчтэй нөлөө үзүүлж байна. Интернэт ашиглан орон зай, цаг хугацааны эрхшээлгүйгээр бизнес эрхэлж, ашиг орлогоо нэмэгдүүлж мэдээлэл авах, итгэж үнэмших, эвлэлдэн нэгдэх, амьдралд оролцох эрхээ эдлэх боломж хэнд ч нээлттэй байна.



Статистик тоо баримт

- ◆ Лондонгийн эдийн засгийн сургуулийн эрдэмтэд 91 сургуулийн 130 гаруй мянган сурагчийг судалгаанд хамруулж, хичээлийн үеэр утас хэрэглэхийг нь хязгаарлажээ. Өмнөх жилүүдийнх нь дүнтэй харьцуулахад сурлагын дүн нь дунджаар 6,4 хувиар дээшилсэн байна.
- ◆ Британийн нэгэн хуулийн байгууллага долоон хос тутмын нэгнийх нь салах шалтгааныг эхнэр, нөхрийн аль нэг цахим сүлжээнд донтсонтой холбоотой гэж үзжээ.
- ◆ Ютагийн их сургуулийн судалгаагаар, гар утас хүмүүсийн чөлөөт цагаас хумсалдаг учир ойр дотно хүмүүсийн харилцаанд сэв суулгадаг гэсэн дүгнэлт гарчээ.



Баримтуудад дүн шинжилгээ хийж, ярилцах асуултууд:

- ◆ Дээрх дөрвөн баримт мэдээллээс аль нь танай багийн нотолгоо болох боломжтой вэ? Учир нь ...
- ◆ Багаараа ярилцаж, эдгээрийг хамгийн чухал, найдвартайгаас эхлэн 1,2,3,4 хэмээн дугаарлаад, учрыг нь тайлбарлана уу.



Мэтгэлцье.

Бусдыг хүндэтгэж харилцъя.

- a. Дараах өгүүлбэрийг эерүүлж хэлэхийн тулд өгсөн үгээс сонгож, ойролцоо утгатай өгүүлбэр бичнэ үү.
 - ◆ Чинийх буруу байна.
 - ◆ Чи худлаа ярьж байна.

(жаахан андуурах, ташаарах, хэлбийх, хазайх, гажуудах, давуудуулах, хэтрүүлэх, туйлшрах)
- b. Дараах асуудлуудыг ангиараа хэлэлцээд, аль нэгийг сонгож, мэтгэлцээн зохион байгуулаарай. Дээрхийн адил дөрвөн баг болоорой. Нотлох ба няцаах багууд сэдвийн талаар өөр өөрийн байр суурийг илтгэсэн асуудлыг дэвшүүлнэ.

Үлгэрлэвэл: Нотлох баг: Циркийн амьтад жаргалтай байдаг. Няцаах баг: Циркийн амьтад тийм ч жаргалтай байдаггүй.

1. Монгол хүн ногоо идсэнээс мах идсэн нь дээр.
2. Уучлал гуйхад утсаар ярьснаас, захиа бичсэн нь дээр.
3. Сурагч хүн заавал “А” үнэлгээтэй суралцах ёстой.
4. Өглөөний цайнд хоносон хоол идэж болно.
5. Зуны улиралд хөдөө амарснаас хотод амарсан нь дээр.
6. Хүүхэд байхаасаа мөнгө хадгалж сурах ёстой.
7. Математикийн хичээл дээр тооны машин хэрэглэх шаардлагатай.
8. Дунд сургууль зуны улиралд хичээллээд, өвлийн улиралд амардаг байх нь дээр.
9. Цэцэрлэг, эмнэлэг зэрэг газарт ороходоо гялгар уутан улавч өмсөх нь сайн арга.



10. Энгийн шатар тоглосноос, компьютерийн шатар тоглох нь дээр.
11. 9 дүгээр ангийнханд товчлууртай утаснаас, ухаалаг утас зайлшгүй хэрэгтэй.
12. Найзынхаа төрсөн өдрөөр бэлэг өгөх хэрэгтэй.

Гэртээ: Найм, есдүгээр ангид үзсэн уран зохиолын хэд хэдэн зохиолын дүр, үйл явдлаас ургуулан мэтгэлцээний сэдэв бэлтгэж ирээрэй. Хоёр талаас үзэж болох, маргаантай, олон асуудлыг дэвшүүлээрэй.

Үлгэрлэвэл: “Болдоггүй бор өвгөн” үлгэрийн баатар Болдоггүй бор өвгөний үйлдэл нь энэрэнгүй биш. / Болдоггүй бор өвгөн ийм үйлдэл хийхээс өөр аргагүй.



Мэтгэлцээний дүрэм

1. **Сэдэв:** Мэтгэлцэхийн тулд ямар нэг сэдэв сонгоно. Үүнийг дэвшүүлсэн асуудал бүхий баталсан өгүүлбэрээр илэрхийлж болно.
2. **Нотлох тал:** Дэвшүүлсэн асуудал зөв болохыг нотлох үүрэгтэй.
3. **Няцаах тал:** Нотлогч талын гаргаж буй нотолгоо хангалтгүй болохыг шүүгчдэд батлан харуулж няцаах үүрэгтэй.
4. **Нотолгоо:** Өөрсдийн үзэл бодол, санал зөв гэдгийг шүүгчдэд баталж харуулахын тулд янз бүрийн нотолгоо гаргана.
5. **Дэмжлэг:** Дэвшүүлж буй асуудлаа статистик тоо баримт, түүхэн үнэн, шинжлэх ухааны дүгнэлт нээлт, болсон явдал гэх мэт баримтаар нотолж үнэмшилтэй болгоно.
6. **Солбисон асуулт:** Мэтгэлцээнд оролцогч багийн гишүүд бие биеэс асуулт асууж, хариулт авах боломж юм.
7. **Шүүгчийн шийдвэр:** Шүүгч нь хоёр талын нотолгоог нэг бүрчлэн сонсож, тэмдэглэл хөтөлсний үндсэн дээр аль баг нь уялдаа холбоо сайтай, үнэн зөв нотолгоо гаргасныг харгалзан, ялагчийг тодруулна.

Үйл ажиллагааны дараалал

Нэг баг гурван илтгэгчтэй байна. Хүн бүр үүрэгтэй. Нотлох багийн 1 дүгээр илтгэгч эхэлж, өөрийн нотолгоог 6 минутын хугацаанд танилцуулна. Няцаагч багийн 3 дугаар гишүүн түүнээс асуулт асууж, хариултыг сонсоно. Үүний дараа мөн няцаах талын 1 дүгээр илтгэгч эсрэг талын нотолгоог няцаан, 6 минутын турш өөрийн нотолгоог танилцуулна. Няцаах талын 1 дүгээр гишүүнээс нотлох талын 3 дугаар гишүүн асуулт асууж, хариултыг сонсоно. Дараа нь нотлох багийн 2 дугаар илтгэгч өөрийн нотолгоог сэргээж, эсрэг багийн нотолгоог няцаана. Хоёр талын 2 дугаар илтгэгч тус бүр 5 минут ярих ба тэднээс 1 дүгээр илтгэгчид асуулт асууна. Асуулт, хариултын хугацаа тус бүр адил 3 минут байна. 3 дугаар илтгэгч тус бүр 5 минут ярих ба тэднээс асуулт асуухгүй.

Илтгэлүүдийн хооронд, мөн солбисон асуултын өмнө бэлтгэх хугацаа авч болно. Энэ нь нийт дүнгээрээ 8 минутаас хэтрэхгүй. Мэтгэлцээнийг албан ёсны ба албан ёсны бус гэж ангилдаг. Албан ёсны мэтгэлцээн нь тодорхой зарчим, журам, хугацаатай байдаг. Албан бус мэтгэлцээнийг хичээлийн явцад ч хийж болдог.

Мэтгэлцээний сэдвийг тухайн цаг үе, нийгэмд тулгамдсан маргаантай байж болох асуудлыг сонгон авч дэвшүүлбэл тохиромжтой.



МЭДЛЭГ, ЧАДВАРАА ДҮГНЭ

Эсээг анхааралтай уншиж, даалгаврыг гүйцэтгээрэй.

Зүүдний тухай яриа

1. Амьдрал бол зүүд гэх нь бий. Зүүд тэгвэл юу вэ? Жинхэнэ амьдрал уу? Ингэхэд би зүүдэлж байна уу, амьдарч явна уу?

Зүүд, амьдрал хоёрын ялгаа бүрхэг л дээ. Бүдүүлэг омог аймгийнхны хувьд ийм ялгаа ерөөсөө байдаггүй юм гэнэ билээ. Би хувьдаа зүүдийг энэ амьдралаас тусдаа зүйл гэдэгт итгэлтэй явдаг ч, эвгүйгээр зүүдлэгдсэн хэн нэгэнтэй инээмсэглээд ярилцчихаж чаддаггүй л юм.

2. Зүүдний ертөнц бидний ертөнцтэй ерөнхийдөө адилхан. Харин тэнд бид энэ ертөнцөд байдгаасаа хамаагүй чөлөөтэй, өөрийнхөөрөө байдаг. Ганц баримт дурдахад, би зүүдэндээ дугуй унаж сурсан юм. Дунд сургуулийн найзууд маань бүгд дугуй унадаг, би л ганцаараа чаддаггүй. Хоёр ч дахин тун эвгүй унасны эцэст дугуйнаас өөрийн эрхгүй айдаг болж билээ. Түшүүлж байгаад нэгэнт дөрөө жийгээд эхэлбэл шулуун замд бол дажгүй явчихна. Харин ганцаараа дугуйгаа хөдөлгөөд явж чаддаггүй, бас эргэлт дээр будилдаг байв. Нэг удаа, яавал дугуйг унагалгүй хөдөлгөж болдгийг зүүдлэв. Тэгээд эргэлтийг тун ч чадмаг хийж явна гэж зүүдэллээ. Дөрөөг доош жийсэн тал руугаа эргэхэд хялбар байх юм. Маргааш нь ангийнхаа хүүхдийн унадаг дугуйг гуйж, зүүднийхээ мэдлэгийг туршиж үзвэл яг болж билээ.

3. Зүүдийг энэ амьдралтай зэрэгцээ оршдог, өөр хэмжээс бүхий ертөнц гэх үзэл нэлээд түгээмэл. Бие биеэ ч танихгүй хүмүүсийн зүүдний хачин уялдаа холбооны талаарх хамгийн сонин баримтуудын нэг нь Чингис хааны ач Хубилай хаан, ХҮIII зууны английн романтик яруу найрагч Самюэл Тейлор Колриж хоёрт хамаарна. Хубилай хаан өөрийнхөө ордныг барьж байгуулахаасаа өмнө зүүдэндээ харж, сэрүүтээ барилгын төлөвлөгөөг гардан хийж бариулсан юм санж. Энэ тухай Хубилайн удмын Гасан хааны элч өгүүлсэн гэж Рашид- ад-Дины “Судрын чуулган” дотор бий. “Судрын чуулган” европын хэлнээ анх удаа 1836 онд франц руу орчуулагдсан гэдэг. Тэгвэл 1797 онд яруу найрагч Колриж тун хачин хэлбэрээр холбогдсон тавин хэдэн мөр шүлэг зүүдэлсэн нь чухамхүү Хубилай хааны ордны зохион байгуулалтын тухай өгүүлсэн байжээ. Колриж зүүдэлсэн мөрүүдээ утгын хувьд баяжуулан **«Kubla Khan»** хэмээх найраглал бичсэн нь өнөө хэр англи хэлний яруу эгшиглэнгийн оргил гэгддэг.

4. Миний эхнэрийн зүүдэлсэн юмс ихэнхдээ биелдэг юм. Анхандаа бид хачирхдаг байсан боловч сүүлдээ мэргэн зүүд дэндүү олон тохиолдсон тул тоогоо ч алдчихсан. Тэр хэрээр хачирхахаа ч больсон. Бүр намайг хол газар хэрхэн явсныг зурагтаар харсан мэт яг таг зүүдэлсэн тохиолдол ч бий.

Зүүдээр хувь заяаны оноолтыг тааж мэргэлж болно! Христос шашны анхны томоохон онолчдын нэг Ориген: “Бурхан урьдчилан анхааруулалгүйгээр хэнийг ч шийтгэдэггүй” гэж хэлсэн аж. Хүнд аливаа үйл явдлыг урьдаас мэдрэх зөн совин байдаг. Тэр нь ихэвчлэн зүүдээр илэрдэг бололтой.

Авраам Линкольн алагдахаасаа хэдхэн хоногийн өмнө өөрийнхөө үхлийг зөгнөн зүүдэлж эхнэртээ, бас бус хүмүүст ярьсан байдаг. Харин ерөнхийлөгчийн амь насанд халдсан хойно л ойр дотнынхон нь тэр зүүдийг санацгаажээ.





“Мянга нэгэн шөнийн үлгэр”-т гардаг булсан эрдэнэсийн тухай мэргэн зүүдийг та санаж байна уу?

Зүүдэлсэн эрдэнэсээ хайгаад, Египетээс Перс ордог адал явдалт тэнүүлчинд тэндхийн цагдаагийн дарга:

-Тэнэг минь, надад л лав Каирт байдаг цагтай цамхаг бүхий байшингийн ёроолд булаатай алт эрдэнэс гурван удаа зүүдлэгдсэн юм даг. Би тэр хоосон зүүдэнд итгэж, тэнүүлчлээгүй л байна. Ийм мунхаг юм бүү хөөцөлд гэж зөвлөдөггүй юү. Цагдаагийн даргын зүүдэлдэг байшин бол мань тэнүүлчний байшин л даа. Ингээд тэр харьж, хашаан дотроосоо бөөн алт ухаж олоод, баяждаг юм. Атаархмаар сайхан үлгэр шүү.

5. ...Ертөнцийн логик зүүдэнд ер үйлчилдэггүй. Тэгэхээр хүний далд ухамсар, санаатай бус үйлдэлд логик байдаггүй гэсэн үг. Логикгүй, зөвхөн нууцлагдмал ухамсраар зохицуулагдаж байгаа зүүдний ертөнц уг ертөнцийг бүтээгээгүй бусад хүмүүст мөн танигдахааргүй юм. Жишээ нь, миний зүүд ямагт бүрэнхий, үл мэдэгхэн сүүмгэр манантай орчинд өрнөдөг, гагцхүү хар цагаан байдаг.

Харин эхнэр минь тод өнгөтэй зүүдэлдэг тухайгаа ярьдаг. Хэдийгээр бүрсгэр, манантай, хар цагаан боловч би өөрийнхөө зүүдийг хар багаасаа үзсээр дасчихсан тул ямар ч тод, өнгөт зураг харж байгаагаас илүү учрыг нь олж, өчүүхэн зүйлийг ч ялгаж таньдаг. Өөр хүн бол тэнд юу болоод байгааг ч ойлгохгүй биз.

6. Номоос уншсанаа эргэцүүлэн бодоход, зүүдээс төрсөн аялгуу сэтгэлд илүү хүчтэй нөлөөлдөг юм шиг. Та, Жузеппе Тартинийн “Trillo del Diavolo”-г хайж олоод сонсоорой. Битлзийн “Yesterday” ч зүүдэнд төрсөн аялгуу шүү дээ. Зүүдлэгдсэн шүлэг зохиол, аялгууг хамгийн гол нь мартаггүй тэмдэглэж авах хэрэгтэй юм билээ. Би зүүдээ ер нь л мартчихдаг юм.


Миний далд ухамсарт ер нь юу ч нуугдаж байж мэднэ. Юу ч нуугдаж ... Юу ч..
(Г. Аюурзана)

Даалгавар

1. Дараах хүснэгтэд тохирох жишээг бичнэ үү.


Цогцолборын утга	Тайлбарлагдаж буй юм	Тайлбарлаж буй юм	Хэрхэн тайлбарласан

2. Эхийн цогцолборыг дугаарласан байна. 3, 4, 5 дугаар цогцолборуудын ялгааг бичээрэй.





3. Дэвшүүлсэн асуудал нь аль вэ?
 - а. Ингэхэд би зүүдэлж байна уу, амьдарч явна уу?
 - б. Зүүдний ертөнц ерөнхийдээ бидний ертөнцтэй адилхан.
 - в. Амьдрал бол зүүд.
 - г. Миний далд ухамсарт ер нь юу ч нуугдаж болно.
4. “Амьдрал бол зүүд гэх нь бий. Зүүд тэгвэл юу вэ? Жинхэнэ амьдрал уу? Ингэхэд би зүүдэлж байна уу, амьдарч явна уу?” гэсэн өгүүлбэр нь эхийн гол санааг хадгалсан хөтөч нь мөн үү.
5. Эхийн бүтцийг хэрхэн задалсныг ажиглаад, тэдгээрийн утга, үүргийг тайлбарлаарай.



6. Эхийг дахин нягтлан уншаад, доорх жишээг олно уу.

Үндэслэл нь	Эхийн хэддүгээр догол мөрт, ямар үг, өгүүлбэр?
Асуудал нь	Эхийн хэддүгээр догол мөрт, ямар үг, өгүүлбэр?
Таамаглал нь	Эхийн хэддүгээр догол мөрт, ямар үг, өгүүлбэр?
Шалтгаан нь	Эхийн хэддүгээр догол мөрт, ямар үг, өгүүлбэр?
Үр дагавар нь	Эхийн хэддүгээр догол мөрт, ямар үг, өгүүлбэр?
Баримт нь	Эхийн хэддүгээр догол мөрт, ямар үг, өгүүлбэр?
Тайлбар нь	Эхийн хэддүгээр догол мөрт, ямар үг, өгүүлбэр?
Сэтгэгдэл нь	Эхийн хэддүгээр догол мөрт, ямар үг, өгүүлбэр?
Зохиогчийн үзэл бодол	Эхийн хэддүгээр догол мөрт, ямар үг, өгүүлбэр?
Дүгнэлт нь	Эхийн хэддүгээр догол мөрт, ямар үг, өгүүлбэр?



7. Дараах өгүүлбэрийг олж, ялган бүлэглэнэ үү.
 Таамагласан өгүүлбэр
 Баталсан өгүүлбэр
 Үгүйсгэсэн өгүүлбэр
 Шалтгаан, үрийн харьцаатай өгүүлбэр
8. “Миний зүүд ямагт бүрэнхий, үл мэдэгхэн сүүмгэр манантай орчинд өрнөдөг, гагцхүү хар цагаан байдаг” гэсэн өгүүлбэрийн эсрэг утгатай өгүүлбэрийг эхээс олж бичээрэй.
9. “Тэр хэрээр хачирхахаа ч больсон” гэсэн өгүүлбэрийн шалтгааныг олж бичнэ үү. “хачирхах” гэсэн үгийн ойролцоо утгатай үгийг нэрлээрэй.
10. “Хоёр ч дахин тун эвгүй унасны **эцэст** дугуйнаас өөрийн эрхгүй айдаг болж билээ” гэсэн нийлмэл өгүүлбэрийг шалтгаан, үрийн утгаар ялгаад, онцолсон үгийг өөр 3-4 бүтээвэр ба холбох үгээр солин найруулж, хувиргана уу.
11. “Зүүдний ертөнц бидний ертөнцтэй **ерөнхийдөө** адилхан” гэсэн өгүүлбэрт зүүдний ертөнц бидний ертөнцөөс ялгаатай гэсэн утга байна уу? Онцолсон үгийн утгыг тайлбарлаарай.
12. Дараах баймж үг хэллэгийн өнгө аясыг тодорхойлоорой.

- гэнэ билээ
- чаддаггүй л юм
- бариулсан юм санж
- оргил гэгддэг
- тэнэг минь
- тэнүүчлээгүй л байна
- бүү хөөцөлд
- ойлгохгүй биз
- нөлөөлдөг юм шиг
- аялгуу шүү дээ
- юм билээ
- байж мэднэ


13. Эхээс шалтгааны утгатай бүтээвэр ба холбох үгийг олж, тайлбарлаарай.
14. “Тэнэг минь, надад л лав Каирт байдаг цагтай цамхаг бүхий байшингийн ёроолд булаатай алт эрдэнэс гурван удаа зүүдлэгдсэн юм даг. Би тэр хоосон зүүдэнд итгэж, тэнүүчлээгүй л байна. Ийм мунхаг юм бүү хөөцөлд” гэж цагдаагийн дарга өгүүлсэн нь юуг илэрхийлж байна вэ?

а. мэдрэмж б. сэтгэгдэл в. үзэл бодол

15. Зохиогчийн үзэл бодол Чиний үзэл бодол




16. “Хамгийн сонирхолтой эхлэл, төгсгөл бол асуултаар эхэлж, үргэлжлэлтэй мэт санагдах буюу асуулт үлдээх төгсгөл” гэдэг. Эх яаж эхэлж, төгссөн байна вэ? Чи өөрөөр яаж төгсгөж болох вэ? Төгсгөлийн цуваа цэгийн оронд чи ямар санаа хэлж болох вэ? Үргэлжлүүлж, ярилцаарай.
17. “хэлнээ” гэсэн үгийн -ээ бүтээвэр ямар утгатай вэ? Ойролцоо бүтээврээр солин найруулаарай.
18. Эхийн задлалд үндэслэн, дараах асуултад хариулж, дүгнэлт хийнэ үү.



19. Уламжлалт бичлэгтэй дараах үгийг үндэсний бичгээр бичээрэй. Үүнд: ертөнц, явал, шүлэг, ганцаараа, айдаг, хүүхэд, утга, гол, ёроол.
20. Эхэд онцолсон гадаад үгийг үндэсний бичгээр бичээрэй.
21. Эхэд хэчнээн цэг тэмдэг байна вэ? Тэдгээрийн үүргийг тайлбарлаарай.
22. Эхэд байгаа “зөн совин, бас бус, унадаг дугуй, уялдаа холбоо, хувь заяа, ойр дотно, омог аймгийнхан, хэн нэгэнтэй, алт эрдэнэс, хар цагаан, хар багаасаа” зэрэг нийлмэл үгийн утга, бүтцийг тайлбарлаарай.

Гэртээ

- Сэдэв сонгон, бүтцийн дагуу хоёр цогцолбор бүхий эх зохиогоорой.



МОНГОЛ ХЭЛ IX

Ерөнхий боловсролын 12 жилийн сургуулийн
9 дүгээр ангийн сурах бичиг

Зохиогчийн баг

Ахлагч:	Д.Эрдэнэсан
Гишүүд:	А.Цог-Очир Б.Цасанчимэг Д.Наранцэцэг

Редактор:	Б.Мөнхтуяа
Техник редактор:	Ш.Баттөгс
Хэвлэлийн эх бэлтгэгч:	С.Болд

Засварласан баг:	П.Эрдэнэсан
Хэвлэлийн дизайнер:	Ц.Сугар

Формат 70x100/16

Офсет хэвлэл. Офсет хэвлэлийн цаас 80гр/м²
Хэвлэлийн хуудас 12 х.х

Хэвлэлийн эхийг “СОДПРЕСС” ХХК-д бэлтгэж,
“Таван Богд Менежмент” ХХК-д 26000 хувь хэвлэв.